



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-40
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	40-144
<hr/>	
<i>1.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх /Монгол Улсын Ерөнхийлөгч 2022.10.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/</i>	49-59
<i>2.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	59-72
<i>3.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн анхны хэлэлцүүлэг/</i>	72-122
<i>4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	122-144

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын
ээлжит чуулганы 11 дүгээр сарын 03-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Ганбаатар, Б.Саранчимэг;

Чөлөөтэй: Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ;

Хоцорсон: А.Адъяасүрэн- 14 минут, С.Амарсайхан- 1 цаг 52 минут, С.Батболд- 1 цаг 52 минут, Э.Батишугар- 55 минут, С.Ганбаатар- 37 минут, Д.Ганбат- 35 минут, Т.Доржханд- 1 цаг 45 минут, Л.Мөнхбаатар- 56 минут, Ж.Мөнхбат- 1 цаг 52 минут, Х.Нямбаатар- 21 минут, С.Одонтуяа- 29 минут, М.Оюунчимэг- 28 минут, Д.Өнөрболор- 54 минут, Ж.Сүхбаатар- 22 минут, Ц.Сэргэлэн- 1 цаг 26 минут, Н.Учрал- 17 минут, Ч.Хүрэлбаатар- 25 минут, Д.Цогтбаатар- 35 минут, Б.Чойжилсүрэн- 1 цаг 34 минут, Т.Энхтүвшин- 21 минут, Ж.Эрдэнэбат- 22 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас 2022.06.03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:08/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Алтанхуяг, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, Б.Жавхлан нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Алтанхуяг, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж, Б.Жавхлан нар үг хэлэв.

Нэг.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх /Монгол Улсын Ерөнхийлөгч 2022.10.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй

байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх Ц.Тогоо, нэр дэвшигч, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга С.Ганбямба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, С.Одонтуяа, Ц.Туваан, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга С.Ганбямба, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.2-т заасны дагуу нууц санал хураалтыг явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар Сүнрэвийн Ганбямбыг томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	42
Татгалзсан:	20
Бүгд:	62

67.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэхээр ТОГТОВ.

Уг асуудлыг 11 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт,

хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, С.Одонтуяа, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Дэд бүтцийн хяналтын газрын дарга Д.Жаргал, Хүнсний аюулгүй байдлын хяналтын газрын дарга Б.Алтантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, Л.Батмөнх, Ц.Баянмөнх, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 52 минут үргэлжилж, 11 цаг 56 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 04 минутад эхлэв.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, О.Цогтгэрэл, Ц.Туваан, Ж.Чинбүрэн, Б.Бейсен нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Б.Баасандорж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нар хариулж, тайлбар хийв.

Хуралдаан 14 цаг 52 минутаас 15 цаг 48 минут хүртэл түр завсарлав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хураалт явуулав.

Нэг.Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ш.Адьяа, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Батгөмөр, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, С.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрэм, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 онд 25, 2025 онд 45, 2026 оноос 65 байна” гэснийг “Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 оноос 65 байна” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	29
Татгалзсан:	27
Бүгд:	56

51.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэж,” гэснийг хасаж, төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1/10 дугаар зүйлийн 10.1.19 дэх заалт:

“10.1.19.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 23

Бүгд: 52

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 24

Бүгд: 55

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлээс “47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг,” гэснийг хасаж, хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“2/47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг:

“47.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж

зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлнэ. Энэ тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана.”” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “Ашигт малтмалын тухай хуулийн” гэсний дараах “26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “, мэргэжлийн хяналтын албанд” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	25
Бүгд:	55

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“57.17.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно.” гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	34
Бүгд:	58

41.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 28
Бүгд: 58

51.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 23
Бүгд: 55

58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар ногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 25
Бүгд: 56

55.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, Төслийн 1, 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 19
Бүгд: 56
66.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

2.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 17
Бүгд: 57
70.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 16
Бүгд: 57
71.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:18/

Долоо.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дугаар зүйлийн 18.19 дэх хэсгийн “түүний дэд бүтцийг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зориулалтаар зарцуулна.” гэснийг “хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан төсвөөс санхүүжүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 15
Бүгд: 56
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.5} дахь хэсгийн “тус байгууллагад” гэсний өмнө “энэ хуулийн 32^{1.4} дэх хэсэгт заасны дагуу баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 15
Бүгд: 56
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.9} дэх хэсгийн “32^{1.1}” гэснийг “32^{1.1.1}, 32^{1.1.6}, 32^{1.1.8}” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 16
Бүгд: 56
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.1} дэх хэсгийн 32^{1.1.1} дэх заалтын “түргэн,” гэснийг хасаж, мөн хэсгийн 32^{1.1.6} дахь заалтын “тасралтгүй, найдвартай” гэснийг “хэвийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 15
Бүгд: 56
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ” гэсэн хуулийн нэрийг “ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ” гэж өөрчлөх. Үүнтэй уялдуулан төсөлд тусгагдсан “Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай” гэснийг “Засгийн газар дахь хяналтын тухай” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 19
Бүгд: 56

66.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4 дэх хэсэг нэмэх:

“11.4.Улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн бол төсвийн хяналтын сонсголыг явуулна.” гэсэн саналаа татаж авав./16:30/

Г.Занданшатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “асуудлаар урьдчилан мэдэгдэх асуудлаар” гэснийг “асуудлын хүрээнд урьдчилан мэдэгдэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 19
Бүгд: 58

67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагч байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 13
Бүгд: 58

77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Гүйцэтгэх засаглалын хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 45

Бүгд: 58
22.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ес.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5³ дугаар зүйлийн гарчгийн “Урьдчилан сэргийлэх” гэсний дараа “хяналт шалгалт” гэж нэмж, мөн заалтын 5^{3.2} дахь хэсгийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий хэд хэдэн байгууллага” гэснийг “хяналт шалгалтын байгууллагууд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 17
Бүгд: 58
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 8.1.3 дахь заалтын “27.1-д заасны дагуу” гэснийг “27 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 16
Бүгд: 58
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлээс “5.1 дэх хэсгийн “төлөвлөгөөт бус,” гэсний дараа “урьдчилан сэргийлэх,” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18
Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмж, дугаарыг өөрчлөх:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэж ангилна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 20
Бүгд: 58

65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтын “нийгмийн баталгааг хангах ажлыг” гэсний дараа “хууль тогтоомжийн хүрээнд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 20
Бүгд: 58

65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 9.2.4, 9.2.5, 9.2.6 дахь заалтын дугаарыг “9.2.3, 9.2.4, 9.2.5” болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 20
Бүгд: 58

65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Хяналт” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт” гэж өөрчилж, мөн хэсгийн “, төрийн захиргааны байгууллагад тухайн байгууллагын дарга” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 20
Бүгд: 58

65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт” гэснийг “хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналт шалгалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 19
Бүгд: 58

67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5.1 дэх хэсгийн “Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/” гэснийг “Хуулиар хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх олгосон байгууллага /цаашид “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэх/” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 19
Бүгд: 58
67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Үндэсний лавлагаа лабораторийн” гэснийг “стандартчилал, хэмжил зүйн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18
Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн гарчгийн, мөн 9.1 дэх хэсэг, 9.2.2 дахь заалт, 9.5 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “хяналт шалгалтын” гэж, мөн хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “хяналт шалгалтын” гэж тохиолдол бүрд тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18
Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арав.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлээс “хэсэг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 20
Бүгд: 58
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван нэг.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, 15.5” гэснийг, мөн зүйлийн “21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18
Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “22 дугаар зүйлийн” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг,” гэж, мөн зүйлийн “22.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэсний дараа, “23.3 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын” гэсний дараа “төв” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 21
Бүгд: 58
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “геологи, уул уурхайн асуудал” гэсний дараах “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж тохиолдолд бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 20
Бүгд: 57
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван хоёр.Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж,” гэсний дараа “46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “барилгын асуудал эрхэлсэн

төрийн захиргааны төв” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 20
Бүгд: 57
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлээс “40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.4, 41.5, 41.8, 41.9 дэх хэсэг,” гэснийг, “, 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “улсын хяналт хэрэгжүүлэх” гэснийг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 23
Бүгд: 57
59.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван гурав.Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан” гэснийг “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн “хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх бөгөөд дарга нь салбарын улсын ерөнхий байцаагч байна.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 21
Бүгд: 57
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван дөрөв.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн” гэсний дараа “6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “хяналтын байгууллага” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Хяналтын” гэснийг “Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “, 18.2 дахь

хэсгийн “5⁴.3-т” гэснийг “5⁵.3-т” гэж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 20
Бүгд: 57
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван тав.Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “10.7 дахь хэсгийн” гэснийг “10.7.2 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 21
Бүгд: 57
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван зургаа.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн санхүүгийн асуудал эрхэлсэн сайд” гэснийг “санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж,” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18
Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван долоо.Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “мэргэжлийн хяналтын” гэсний өмнөх “болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 17
Бүгд: 58
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн хяналтын төв” гэснийг, Зургаадугаар бүлгийн гарчгийн, 15 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 17
Бүгд: 58
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван найм.Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “17.1.4 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг” гэсний дараа ““холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 16
Бүгд: 58
72.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Арван ес.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “42 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг, мөн зүйлийн 42.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын,”” гэснийг “42 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 42.1 дэх хэсгийн “мэргэжлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 18

Бүгд: 58
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорь.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлээс “7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “, мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 22
Бүгд: 57
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин нэг.Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “мэргэжлийн хяналтын” гэсний дараа “байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 24
Бүгд: 57
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин хоёр.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт
орлуулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 21

Бүгд: 57
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин гурав.Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 17.1 дэх хэсгийн “хууль, хяналтын” гэсний өмнө “холбогдох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 21
Бүгд: 57
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин дөрөв.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт
тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, дугаарыг 14.3 болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38
Татгалзсан: 18
Бүгд: 56
67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин тав.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл,
үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “хүнсний,” гэсний дараа “болон” гэж нэмж, мөн зүйлийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “, албан тушаалтан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 16
Бүгд: 56

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин зургаа.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага,” гэсний дараа “төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 18

Бүгд: 56

67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “улсын байцаагчийн” гэсний өмнө “болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 15

Бүгд: 56

73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин долоо.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “эрх олгосон хөдөлмөрийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 18

Бүгд: 56

67.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин найм.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 161 дүгээр зүйлийн 161.1 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг

“эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 20
Бүгд: 56
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хорин ес.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гуч.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг эхлэв.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 34
Бүгд: 55
38.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гучин нэг.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг

“эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 23
Бүгд: 55
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин хоёр.Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 23
Бүгд: 54
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин гурав.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дүгээр зүйлийн “39.2 дахь хэсгийн “Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын” гэснийг “Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус” гэснийг хасаж, мөн хуульд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 22
Бүгд: 54
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин дөрөв.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналт,” гэсний дараа “цагдаагийн зэрэг” гэж, “холбогдох хяналтын болон” гэсний дараа “цагдаа,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 23
Бүгд: 54
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин тав.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэснийг “заалтын мэргэжлийн хяналтын” гэснийг “Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 22
Бүгд: 54
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин зургаа.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 26
Бүгд: 54
51.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин долоо.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар” гэснийг “27.Төрийн цахим үйлчилгээний

зохицуулалтын газар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 19
Бүгд: 54
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтын “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар”” гэсний өмнө “Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Хөрөнгө оруулалт, худалдааны газар” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ч.Хүрэлбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 22
Бүгд: 54
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын гаргасан, Төслийн 1 дэх заалтын “, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар” гэж” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 22
Бүгд: 55
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин найм. “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалт болон 2.2 дахь дэд заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 20
Бүгд: 55
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын 1 дэх дэд заалтын “2023 оны төсөвт тусгагдаагүй төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн дараа онуудын төсөвт тусган шийдвэрлэх” гэснийг “улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шаардлагатай бол төсвийн хуульд тусган шийдвэрлүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 20
Бүгд: 55
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 19
Бүгд: 55
65.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

“9/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, экспортын гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг экспортод гаргахгүй байх, борлуулалт болон худалдан авах нууц гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ч.Хүрэлбаатар, Ш.Адьяа, Х.Булгантуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 19
Бүгд: 54
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 10 дахь дэд заалт нэмэх:

“10/Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 19
Бүгд: 54
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд нарын 19 гишүүний гаргасан, Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 11 дэх дэд заалт нэмэх:

“11/Орон нутагт нислэг үйлдэж байгаа авиа компанид олгож байгаа татаасыг тухайн аймагт байнга оршин суугч зорчин явагч иргэдийн тийзийн үнээс хөнгөлөх зарчмаар өөрчлөн шийдвэрлэхийг Засгийн газарт даалгах.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Д.Батлут, Ш.Раднаасэд, Ш.Адьяа, Х.Болорчулуун, Б.Жавхлан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 39
Бүгд: 55
29.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 22
Бүгд: 56
60.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдааны цагийг сунгаж, үргэлжлүүлэн хуралдах талаар хэлэв./18:06/

Дөрөв. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, референт С.Төрмөнх нар байлцав.

Төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, төсвийн санал нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 70.7.2, 70.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар тус тус танилцуулав.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой
төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

1.Төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ш.Адьяа, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, С.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрам, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 37,754.7 сая төгрөгөөр, газрын төлбөрөөс аймаг, нийслэлийн орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 60,860.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 29

Бүгд: 55

47.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 24
Бүгд: 48
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Хуралдаан 18 цаг 30 минутаас 19 цаг 03 минут хүртэл түр завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 16
Бүгд: 49
67.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 16
Бүгд: 49
67.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 1.2.Монголбанкны худалдан авах алтны хэмжээг 2023 оны төсвийн жилд 20 тонн болгохтой холбогдуулан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 29,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 14
Бүгд: 49
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Төсвийн зардал нэмэгдүүлэх, бууруулах санал:

2.1.Төсвийн зардал бууруулах санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, 2.1.1.Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн цалин хөлс, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, зээлийн хүүгийн төлбөрийн зардлаас бусад улсын төсвөөс санхүүжих үйл ажиллагааны зардлыг 1.88 хувиар буюу 94,527.6 сая төгрөгөөр бууруулах;

2.1.2.Төслийн 2 дугаар хавсралтын “VI.2.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2023-2023 он, төсөвт өртөг 80,000.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 80,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнг 40,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах;

2.1.3.Төслийн 2 дугаар хавсралтын “XII.1.1.73.Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам 50 км” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 10,969.1 сая төгрөгөөр, мөн хавсралтын “VI.2.1.1.Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр буюу нийт 15,969.1 сая төгрөгөөр бууруулах;

2.1.4.Төслийн 2 дугаар хавсралтын “VI.2.1.2.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 26,365.2 сая төгрөгөөр бууруулах.

Нийт 176,861.9 сая төгрөгөөр дараах хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх.Үүнд:

2.2.Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал:

2.2.1.Улсын хэмжээнд гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн зардалд шаардагдах 33,628.0 сая төгрөгийг Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах.

2.2.2.“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд шаардагдах 13,500.0 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх.

2.2.3.Ойн хортон шавжтай тэмцэх ажилд зориулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын урсгал зардлыг 8,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгагдсан Өнөр бүл хүүхдийн төвийн урсгал зардлыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.5.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгагдсан Хүүхэд хамгаалах арга хэмжээний зардлыг 2,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.6.Шинэ сэргэлтийн бодлогын тэргүүлэх зорилт-Боомтын сэргэлтийг дэмжих хүрээнд Боомтын асуудал хариуцсан сайдын урсгал зардлыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.7.Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Монгол Улсад зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын урсгал зардлыг 3,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.8.Хууль тогтоох байгууллагын хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангахад зориулан урсгал зардлыг 5,919.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.9.Санхүүгийн зохицуулах хорооны урсгал зардлыг 2,900.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.10.Жендэрийн үндэсний хорооны урсгал зардлыг 217.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.11.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын урсгал зардлыг 242.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.12.Байгаль цаг уурын эрсдэлд өртсөн орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зориулж Нийгмийн халамжийн сангийн урсгал зардлыг Ховд аймагт 1,000.0 сая төгрөгөөр, Увс аймагт 622.2 сая төгрөгөөр, нийт 1,622.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнтэй холбогдуулан орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээнд зохих өөрчлөлтийг тусгах.

2.2.13.Төсвийн орлого нэмэгдүүлэх 1.1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн холбогдох зардлыг 10,692.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх:

/аймаг, нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 82,647.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймаг, нийслэлд үлдэх орлогын хэмжээг 10,692.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 5,274.1 сая төгрөгөөр бууруулах/

2.2.14.Төсвийн орлого нэмэгдүүлэх 1.2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн холбогдох зардлыг 2,910.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх:

/орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг 2,910.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх/

2.3.Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал:

2.3.1.Саналын томъёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 10,222.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан тухайн төслийн хэрэгжиж дуусах хугацааг өөрчлөх.

2.3.2.Саналын томъёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан 82 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалын дүгнэлтэд үндэслэн төсөвт өртгийг

221,285.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан тухайн төслүүдийн санхүүжих дүнд 50,628.4 сая төгрөгийн өөрчлөлт оруулах.

2.3.3.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдсан, 2023 оны төсвийн төсөлд тусгагдаагүй, саналын томъёоллын 3 дугаар хавсралтад тусгагдсан 32 хөрөнгө оруулалтын болон 6 төрлийн урсгал зардлыг 23,678.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөлд нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 24

Бүгд: 51

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.2023 оны төсвийн санхүүжих дүнд нөлөөлөхгүй
зохицуулалт хийх санал:

3.1.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хоорондын зохицуулалт:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.1.Саналын томъёоллын 4 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал өөрчлөх, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжүүлэн өөрчлөх 2 төсөл, арга хэмжээний зохицуулалт хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 47

Бүгд: 51

7.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Өнөрболор нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 19

Бүгд: 50

62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар 1 цагийн завсарлага авав./19:37/

Хуралдаан 19 цаг 37 минутаас 20 цаг 39 минут хүртэл түр завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн тухай асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./20:42/

Г.Занданшатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.2.Саналын томъёоллын 5 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 оны санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 58 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнд холбогдох зохицуулалт хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 25
Бүгд: 50
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэдийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 3.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.3.Төслийн 2 дугаар хавсралтын ХХ.3.1.Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 22,000.0 сая төгрөгөөр бууруулж хэрэгжих хугацааг 2023-2024 он болгон өөрчилж, “Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ хэрэгжих хугацаа 2023-2024 он, төсөвт өртөг 45,000.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 22,000.0 сая төгрөг”

гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж, зохицуулалт хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 4.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.4.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцын урсгал зардал болох бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх борооны пуужин 2500 ширхэг авахад 1,500.0 сая төгрөгийг мөн сайдын багцын урсгал зардалд нэмж, зохицуулалт хийх гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.5.Соёлын сайдын урсгал зардлыг 100.0 сая төгрөгөөр бууруулж, Кино урлагийг дэмжих сангийн үйл ажиллагааны зардалд 100.0 сая төгрөгийг шилжүүлэн зохицуулалт хийх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Бусад зарчмын санал:

4.1.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, 4.1.1.хүснэгтийн толгой хэсгийн “Үр дүнгийн” гэсний дараа “талаарх” гэж, 9.1.2 дахь заалтын дараа “9.1.3 Нийцлийн аудитын тоо”, 2023 оны зорилтот түвшинг “0” гэж, 15.2.1, 15.2.2 дахь заалтын “Хуулийн” гэсний өмнө “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай” гэж, 23.6.1, 23.6.2, 23.6.3, 23.6.4, 23.7.1, 23.8.1, 23.8.2, 23.9.1 дэх заалтын “тоо” гэсний дараа “мянга” гэж, 28.1.2 дахь заалтын “Малын гоц халдварт” гэсний дараа “өвчний” гэж тус тус нэмэх;

4.1.2.хүснэгтийн 1.1.3 дахь заалтын “хөдөлгөөнийг” гэснийг “үндэсний хөдөлгөөнийг” гэж, мөн заалтын “270-аас доошгүй тогтоолын төсөл” гэснийг “270-

аас доошгүй хууль, тогтоолын төсөл” гэж, 2.1.3 дахь заалтын “Цахим мэдээллийн санд төвлөрүүлсэн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн тоо” гэснийг “Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж цахим мэдээллийн санд төвлөрүүлэх тайлангийн тоо” гэж, 4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтын “хуулийн хугацаанд шийдвэрлэх” гэснийг “хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах” гэж, 7.1.1 дэх заалтын “хяналт тавих” гэснийг “тавих хяналтын” гэж, 12.1.2 дахь заалтын “шилжүүлэлтийн” гэснийг “шилжүүлэх” гэж, 16.1.1 дэх заалтын “Нийт төрийн өмчит” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит” гэж, 16.1.3 дахь заалтын “Төрийн өмчийн байгууллагын” гэснийг “Төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж, 18.2.1 дэх заалтын “Бүсийн тээвэр логистикийн шинээр нэмэгдэх төв” гэснийг “Шинээр нэмэгдэх бүсийн тээвэр логистикийн төв” гэж, 19.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт” гэснийг “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт” гэж, 19.2.1 дэх заалтын “стандартад нийцүүлэн ханган ажиллах” гэснийг “стандартыг хангаж ажиллах” гэж, 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.2.1 дэх заалтын “га” гэснийг “мянган га” гэж, 20.1.2 дахь заалтын “Ойн хөнөөлт шавж” гэснийг “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх” гэж, 20.2.2 дахь заалтын “хамгаалалтын зурвасын нэмэгдсэн” гэснийг “хамгаалалтын зурвас хийх талбайн хэмжээ” гэж тус тус өөрчлөх;

4.1.3.хүснэгтийн 15.2 дахь хэсгийн дэд гарчгийн “талаар” гэснийг, 16.2.5 дахь заалтын “хохирогчийг” гэсний дараа “хамгаалах” гэснийг, 20.1.2 дахь заалтын “тэмцлийн” гэснийг, 25.1.1 дэх заалтын “Зорилтыг бүрэн хэрэгжсэн,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 15
Бүгд: 49
69.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.2.Бусад санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, 4.2.1.Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томьёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 17
Бүгд: 49
65.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 4.2.2.Төсөлд зүйл заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт

оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 14

Бүгд: 49

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, 4.2.3.Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 18

Бүгд: 49

63.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын
зөрүүтэй саналын томъёолол

1.Хууль зүйн байнгын хороо:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр” нэмэгдүүлэх гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 19

Бүгд: 49

61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг 350.0 сая төгрөгөөр бууруулж, “Гурван хүүхдийн заставын засвар /Ховд, Булган сум/, хэрэгжих хугацаа 2023-2023 он, төсөвт өртөг 350.0 сая төгрөг, санхүүжих дүн 350.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 19
Бүгд: 50
62.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эдийн засгийн байнгын хороо:

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайдын багц дахь Иргэний нисэхийн ерөнхий газрын төсөвт төвлөрүүлэх агаарын навигацийн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Орон нутгийн /Алтай, Ховд, Өлгий, Улаангом, Улиастай, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад, Баянхонгор/” чиглэлд нислэг гүйцэтгүүлэхэд тийзийн үнийн татаас олгоход 9,800.0 сая төгрөг нэмж тусгах гэсэн Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 23
Бүгд: 50
54.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Улсын Их Хурлын даргын урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналаа татаж авав./20:59/

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын “IX.1.50.Сумын төвийн цэвэр усны шугам /Өвөрхангай, Төгрөг сум/ хэрэгжих хугацаа 2021-2023 он, төсөвт өртөг 1,892.5 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,292.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 33
Бүгд: 49
32.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Бусад. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж “7 биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгоцгооё”, “10 төсөвтэй МАН” гэсэн лоозонг ширээн дээрээ байрлуулсан байв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ё.Баатарбилэг, Ж.Мөнхбат нарын урилгаар Архангай аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Ж.Чинбүрэн, Э.Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн 28 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1982 оны төгсөгчид, Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбооны ажлын алба болон гишүүн байгууллагуудын ахмадууд, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар “Ментора” коллежийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн урилгаар Монгол Улсын Боловсролын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын сургуулийн 12а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Энхболд, Ц.Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Т.Аюурсайхан, Ж.Сүхбаатар нарын урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, Баянхонгор аймгийн Баянговь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн урилгаар Булган аймгийн Баян-Агт сумын иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 24 минут үргэлжилж, 76 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 93.4 хувийн ирцтэйгээр 21 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 04 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Эрхэм гишүүд ээ, ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 6 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, ЗХЖШ-ын даргыг томилох саналыг зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн зөвшилцөх саналыг хэлэлцэнэ зөвшилцөнө,

Хоёрдугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна,

Гуравт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна, зарчмын зөрүүтэй 87 саналтай юм байна. 87 саналаар өнөөдөр санал хураалт дуусгах ёстой,

Дөрөвт, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн

даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна,

Тавдугаарт, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

Зургаадугаарт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-т хууль, тогтоолын төслөө татан авсан тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаагаас 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр 10/311 тоот албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татах тухай.
Монгол Улсын Үндсэн хуулийн 26

дугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд хэлэлцүүлгийн шатуудад байгаа болно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд АТГ ХОМ гаргадаг албан тушаалтан, төрийн албан хаагч ипотекийн зээл болон эрүүл мэндийн үйлчилгээ авахаас бусад зориулалтаар хувийн ашиг сонирхлын мэдүүлэгтээ мэдүүлсэн жилийн орлогын наян хувиас дээш хэмжээний зээлийг бусад этгээдээс авахыг хориглон, зохицуулалтыг тусгасан бөгөөд эдийн засгийн хүндрэлтэй цаг үед иргэдийн орлогоос шалтгаалан хуулийг хэрэгжүүлэх явцад бэрхшээл үүсээж болзошгүй байгааг харгалзан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт хууль санаачлагч, хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хууль, тогтоолын төслөө татан авч болно гэж заасны дагуу хуулийн төслөө татан авч байна. Зохих журмын дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье. Хүндэтгэсэн, Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяа гэжээ.

Хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Норовын Алтанхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж, Болдын Жавхлан нараас тус тус албан бичгүүдийг ирүүлсэн байна. Уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа. Миний бие 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үндэслэл бүхий саналаа ирүүлсэн байна. Үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан гэсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлнэ.

Ц.Туваан: Бүгдэд энэ өглөөний мэндийг дэвшүүлье. Миний бие болон Улсын Их Хурлын гишүүн Адьяасүрэн, Батлут, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Ганибал, Наранбаатар, Тэмүүлэн, Мөнхбаатар нарын зэрэг 10 гишүүн өнгөрсөн 6 сард төрөөс олгох урамшууллаас Нийгмийн даатгалын болон ЭМД-ын шимтгэл суутган төлөх тухай гэдэг хуулийн төслийг өргөн барьсан. Тэгээд өнөөдөр энэ УИХ дээр, улсын төсөв дээр голчлон ажиллаж байгаа энэ цаг үед бас энэ хуулийн төслөө хэлэлцэх асуудлын дараалалд удахгүй болох даргын зөвлөлийн хурлаар оруулж хийж өгнө үү гэсэн ийм саналыг хэлж

байна. Энэ хуулийн төсөл маань яагаад ийм энэ төсөвтэй бас зэрэгцээд, зэрэгцэхүйц хэмжээний ач холбогдолтой гэхээр төрөөс Монгол Улсын улсын төсөв дээр, ялангуяа энэ ХАА-н салбарт урамшууллуудыг олгодог. Энэ дээр бол ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал, улаан буудайн урамшуулал, сүүний урамшуулал, сүүлд бас хүнсний ногоонд олгох урамшуулал гээд ЗГ-аас шийдвэр гаргаад энэ дараах урамшууллуудыг олгодог. Тэгэхээр улсын төсөв дээр өнгөрсөн жилүүдэд 2020, 21 онд гэхэд 66 орчим тэрбум төгрөгийг эдгээр урамшууллуудад олгож ирсэн.

Тэгтэл энэ жилийн төсөв дээр гэхэд улсын төсөв дээр энэ урамшууллын хэмжээ буурч орж ирсэн байгаа, 45 орчим тэрбум төгрөг болж буурч орж ирсэн. Тэгэхээр энэ төрөөс олгож байгаа урамшуулаас энэ малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбарт ажилладаг хүмүүсийн эрүүл мэнд, НДШ-ийг л сайн дурын үндсэн дээр суутган тооцох тухай ийм асуудал байгаад байгаа юм. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид маань байнгын тодорхой орлогогүй, дээрээс нь хөдөө орон нутагт гэхэд сумын төвөөс суурин газраасаа нэлээн алслагдсан байдалтай байнга орж ирж энэ харилцаанд орж чаддаггүй энэ асуудлууд бол нэлээн байдаг. Жишээлэх юм бол малчид гэхэд л 17743 малчин л гэхэд энэ НДШ-ээ сайн дураараа төлж чадаж байгаа. Манай төр засгийн зүгээс, малчдад бол бас ер нь онцгой, ийм боломжийг олгосон, энэ нь болохоор малчин эрэгтэй хүн 55 нас, эмэгтэй хүн 50 нас хүрсэн бол, дээрээс нь 20 жил НДШ төлсөн, үүнээс бол малчнаар 12,5 жилээс дээш хугацаанд

ажилласан гэсэн ийм шаардлага боломжуудыг нээж өгсөн байдаг. Тэгэхээр үүнийгээ эдлэх гэхээр НДШ-ээ байнгын орлогогүй алслагдмал байдлаасаа болоод төлж чадахгүй байна.

Тэгэхээр сайн дурын үндсэн дээр энэ ноос, арьс шир, сүү, улаан буудай, хүнсний ногооны урамшуулаасаа энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс НДШ-ээ өргөдлөө гаргаж өгөх замаар сайн дурын үндсэн дээр төлчихвөл маш олон төрлийн ач холбогдолтой асуудал гол нь шийдэгдэх гээд байгаа юм. Энэ хууль батлагдсанаар үндэсний үйлдвэрүүд бол түүхий эдээр хангагдах нь нэмэгдэнэ, малчид, ногоочид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, нийгмийн даатгал, ЭМД-д хамрагдалт нь бол маш өндөр хувьтай нэмэгдэнэ. Одоо өнөөдрийн байдлаар гэхэд ЭМД-д малчдын нэг 30 гаруй хувь л хамрагдаад байгаа юм. Яагаад гэхээр байнга орж ирж, энэ ЭМД-даа хамрагдаж чадахгүй байгаа юм. Тэгээд гэнэтийн янз бүрийн асуудал болоод орж ирлээ гэхэд өнөөдрийн байдлаар 2019 оноос хойших буюу 160 гаруй төгрөгийн шимтгэл төлж байж эрүүл мэндийн үйлчилгээ авах ийм боломжтой болчихоод байгаа юм. Ялангуяа гүйцэтгэлээр санхүүжих энэ тогтолцоонд бол ЭМД төлөөгүй хүн үйлчилгээ авах боломжгүй болж байгаа юм.

Энэ хууль батлагдсанаар ЗГ-аас бол нэг ч төгрөгийн нэмэлт зүйл төсөв дээр хүндрэл учрахгүй. Харин эргээд ЭМД-ын сангийн хуримтлал нэмэгдэнэ, Нийгмийн даатгалын сангийн хуримтлал нэмэгдэхээр гарч байгаа. Энэ хөшүүрэг явснаар ард иргэд маань ч гэсэн энэ

Ерөнхийлөгчийн хүнсний хангамжтай холбоотой тогтоол явж байгаа энэ үед бол органик үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангагдах ийм боломж нэмэгдэж байгаа. Тэгээд энэ сайн дурын үндсэн дээр малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид НДШ-ээ төлж байгаа. Тэгэхээр үүнийг л илүү өндөр хувьтай болгох гэсэн ийм зорилготой хууль байгаа юм. Тэгэхээр энэ хуулийг энэ 7 хоногт Даргын зөвлөлийн хурлаар оруулж, дараагийн 7 хоногоос хэлэлцэж өгөх хуваарь тавьж өгнө үү гэсэн ийм саналыг хэлж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Туваан гишүүн ээ, ер нь манай гишүүд ч гэсэн бас нэг юуг энэ хэлэлцэх асуудлын дараалал тогтоож байгаа. Улсын Их Хурлын тухай хуулийнхаа холбогдох заалтыг бол сайн тодруулж, тодорхой болгож мэдэж баймаар байгаа юм. Хэлэлцэх асуудлын дараалал тогтооход тов тогтооход холбогдох Байнгын хороод, намын бүлгүүд, ялангуяа Байнгын хороод бол хэлэлцэх асуудлынхаа товыг гаргаад Тамгын газарт өгөөд нэгтгээд, тэгээд даргын дэргэдэх зөвлөлөөр чинь шийдэж байгаа шүү дээ. Тийм ээ, тийм учраас энэ саналуудыг уул нь Байнгын хороон дээрээ ирээд Байнгын хорооны дарга Байнгын хороогоор хэлэлцээд энэ асуудлыг хэлэлцэнэ гээд сарын тав тогтоочхож байгаа. Сарын цаглавараа баталдаг болчихсон, хэлэлцэх асуудлын дарааллаа баталдаг болчихсон, тэндээ оруулаад, ингээд даргын дэргэдэх зөвлөл дээр ороод ирэхээр Байнгын хороо нь хэлэлцье гээд ингээд үзэх юм бол Байнгын хороод өөрийнхөө хэлэлцэх асуудалд тавиад, тэгээд л хэлэлцээд явж байгаа шүү дээ. Түүнээс биш шууд ингээд

хэлэлцээд чуулган дээр ингээд хэлэлцээд шийдвэрлэх бололцоогүй гэдгийг бас ойлгохыг хүсье. Улсын Их Хурлын тухай хуульд тийм, Байнгын хороодоос санал орж ирээд үүнийг үндэслээд даргын дэргэдэх зөвлөл шийдэж байгаа. Байнгын хорооноос орж ирээгүй бол даргын дэргэдэх зөвлөл дээр шийдэх бололцоогүй байдаг юм байна лээ.

Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ. Үндэслэл бүхий саналаа ирүүлж үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэж хүссэн байна.

Н.Алтанхуяг: Баярлалаа. Эрхэм гишүүдийн өглөөний амрыг айлтгая. Би 2 асуудал хөндөх гэсэн юм.

Нэгдүгээрт, өнгөрсөн 7 хоногт Эрдэнэт үйлдвэрийн технологид тохирохгүй, зэсийн хүдрийн овоолгыг ашиглах тухай гэсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын эрхэм гишүүд дэмжиж хэлэлцэхээр болсонд би бас талархлаа илэрхийлье. Одоо тэгэхдээ нэг юм байгаа. Бид нар ийм асуудалд жаахан уян хатан хандах ёстой, тэгэхээр орон нутаг тодорхой хэмжээний мөнгөтэй болох, орон нутагт байгаа ард иргэд тодорхой хэмжээний бас боломжийн, өөр өөрсдийн хувийг хүртэх энэ асуудал бол энэ тогтоолоор яригдаж байгаа. Тэгэхээр би эрхэм гишүүдийг та бүхэн нэгэнт дэмжсэн юм чинь энэ ажлын хэсэгт орж ажиллаж өгөөч ээ, ялангуяа аймгийн гишүүд, аймгаас сонгогдсон гишүүдээс заавал орж ажиллаж өгөөч ээ. Энэ дээр бол нэг ийм уян хатан байдлыг би та нарт хэлэх гэсэн юм. Заавал энэ оруулсан байдлаар үүнийг эцэслэн гаргая гэх шаардлагагүй, эцсийн үр дүндээ бол

орон нутагт бол ноогдол ашиг хэлбэрээр заавал тодорхой хувиар очиж байдаг, иргэдэд бас ноогдол ашиг хэлбэрээр тодорхой хувь очиж байдаг, ийм л болгочих юм бол орон нутагтаа иргэддээ хэрэгтэй болно гэж ингэж бодож байгаа юм.

2 дахь асуудал нь бол би яаж явдгийг мэдэхгүй байна л даа, Занданшатар дарга аа. Би энэ 4 сарын 12-нд Ерөнхий сайдад асуулга тавиад түүнийхээ хариуг авчихсан юм, тэгээд 5 сарын 20-нд энэ асуулгын хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж өгөөч ээ, сонсгож өгөөч гэсэн ийм хүсэлтээ өгсөн юм. Одоо тэгэхээр чинь 5 сарын 20 гэхээр 6, зун амарчихсан юм чинь 10-аас эхэлчихье л дээ, 10, 11 гээд 2 сар өнгөрч байна л даа. Тэгээд үүнийг энэ чуулганахаа хэлэлцэх асуудлын дараалалд оруулаад энэ асуулгын хариу гээд ингээд уг нь 4 дэх, 5 дахид чинь чөлөө гараад л байх шиг байгаа юм. Тэгэхээр энэ ямар асуудал вэ гэхээр Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн асуудлаар би Ерөнхий сайдад асуулга тавьсан юм. Тэгэхээр үүнийг маань энэ хэлэлцэх асуудалд бас нэг оруулаад сонсчихмоор байх юм. Бид нар энэ хууль тогтоохоос гадна энэ хянан шалгах ажиллагааг энэ УИХ дээр татаж авчирч хэдүүлээ хийж баймаар байна. Нэг ийм хов живийн шинжтэй, эсвэл нэг сошиал, эсвэл нэг сонин хэвлэлээр янз бүрийн захиалгатай гарсан материалаар Их Хурлын гишүүд бол дүгнэлт хиймээргүй байна. Би энэ Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн асуудлыг бол Улсын Их Хурлын 76 гишүүн сонсож, юу болж өнгөрсөн, яасан, цаашаа хэдүүлээ, яах дээр бол тодорхой шийдвэр гаргах ёстой гэж бодож байгаа юм. Яагаад гэхээр ингээд л нэг захирал тавиад л төр авлаа гэж

хэлээд нэг захирал тавиад л нэг хэд хонож байснаа дахиад захирлаа солиод л, энэ бол ер нь их буруу л зүйл рүү явж байна л даа. Тийм учраас эрхэм гишүүд энэ хууль тогтоох эрх мэдлээсээ гадна бид нар Улсын Их Хурлын хянан шалгах эрх мэдлийг хэрэгжүүлэхэд бас сайн хамтарч ажилламаар байна, үүнийг хэлэлцэх асуудалд оруулж өгөөч гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Ойлголоо. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар сарын эхний 7 хоног болон 3 дахь 7 хоногт Ерөнхий сайдын мэдээллийг сонсдог, 2 дахь 4 дэх 7 хоногт асуултын хариу сонсдог болчихсон юм байна лээ. 15 оны дэгийн тухай хуулийн өөрчлөлтөөр. Тийм учраас нөгөө асуулгууд ингээд хуримтлагдсан маш олон жагсаалтууд дарааллаараа ингээд явж байгаа. Нэлээн олон ийм асуулгын хариугаа сонсёё гээд ирчихсэн, тэгээд л нөгөө он сарынхаа дарааллаар л ингээд л явж байгаа, түрүүчийнх нь бүр 3, 4 сард тавьсан асуулгууд. Тэр юугаараа л аль болох яаруулахыг холбогдох газрууд нь анхаарна биз.

Одоо эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өглөөний мэндийг эрье. Өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал гаргах гэсэн юм. 23 оны төсвийн тухай хуулийг дагасан хуулиуд дотор нэг тогтоол байгаа. Тэр тогтоолын 2 дахь заалтаар Хөгжлийн банкны гадаад зээлийн өрийг төр баталгаа гаргаж төлөх ийм заалт явж байгаа юм. Жавхлан чи, энэ заалтаа татаж ав аа. Чи хамгийн их Хөгжлийн банкныг үймүүлсэн, чиний менежер

Мөнхбаяр, зээлийн газрын дарга хийсэн, чиний танил хүүхэн Уянга зээлийн санхүүжилтийн хэлтсийн захирал хийсэн, Пүрэвсүрэн чинь Ди Би Эм лизингийн захирал хийсэн. Тэгээд яасан, Хөгжлийн банкны 40 гаруй тэрбум төгрөгийг тэр Батхүү захиралтай нь эдний авгай Нью Гови Гэт гэж компани хамтран эзэмшдэг байхгүй юу. Чингис банкныг эд нар эзэмшдэг гэсэн үг. Тэр лүү 40 гаруй тэрбум төгрөгийн хадгаламж байршуулаад өнөөдөр байхгүй. Тэгээд үүнийг хэн төлөх юм, хэн төлөх юм, үүнийг. Чи хаана банк байна, хаана сан байна, бүгд рүү нь гар дүрж байна. ЖДҮ ч тэр, бичил санхүүжилтийн хөгжлийн сан ч тэр, Төрийн банк ч тэр зээл шилжүүлнэ.

Одоо ямар юм хийж байна гэвч, энэ нөхөр. Энэ нэг төсөвт 60 гаруй тэрбум төгрөг байгаа юм, арилжааны банкнуудын зээлийн хүүгийн зөрүүд олгодог. Үүнийг олгоод л банкнуудын захирлыг удирддаг болчихсон, хэнд ямар зээл авч байгаа юм үүнийг шалгах хэрэгтэй. Энэ зээлээр мэргэшихсэн ийм хүн Сангийн сайд хийгээд өнөөдөр бүх сан, бүх банк руу ийм луйвар хийж байна шүү дээ. Худлаа байгаа бол чи надыг энэ Их Хурлын Ёс зүйн байнгын хороонд өгөөрэй, худлаа байгаа бол. Энэ бүгдийг энэ түр хороо хянах хэрэгтэй, Түр хороо шалгах хэрэгтэй, түүний дараа энэ Хөгжлийн банкны зээлийг төлөх тухай асуудал ярих ёстой. Ийм ёс зүйгүй юм байж болохгүй шүү дээ. Одоо хэрвээ Хөгжлийн банкны зээлийг төр баталгаагаараа төлчих юм бол морал хазаарлуулна, хэн ч төлөхгүй. Тэгээд эцэс сүүлдээ яах вэ? Хөгжлийн банкаа дамнууруулах юм уу, экспортын банк болгох юм уу? Ингээд л алга болно. Тэгээд энэ өр барагдуулж байна гэсэн

нэртэй, тэгээд байхгүй болох байхгүй юу.

Тэгэхээр ялангуяа өчигдөр энэ хуулийг Байнгын хороогоор хэлэлцэхэд энэ Амартүвшин тэр 30 хэдэн тэрбумыг авчхаад гөлийчхөөд, энэ юуг төлнө гээд сууж байгаа байхгүй юу, ичих ч үгүй. Төрийн баталгаа гаргаж төлнө гэж. Чи Их Хурлаас татгалзаад шалгуулна гэсэн яасан шалгуул, шалгуулаарай чи, тэгэхгүй зүгээр, ингээд хар аа. Тэгээд чи зүгээр Их Хуралд суух эрх байхгүй байхгүй юу. Тэгэхэд, үгүй ээ, чи надад юм байвал гаргаад ир л дээ, чаддаг юм бол. Тэгээд би энэ асуудлыг Их Хурлаар хэлэлцэхэд энэ мэтийн 10 гаруй нөхөд энэ тогтоолын төсөл дээр оролцохгүй байх ёстой шүү, ашиг сонирхлын зөрчилтэй. Тэгээд ирц хүрэхгүй байж бас магадгүй л дээ, үгүй ээ, нийгэм юу гэж бодож байгаа юм. Их Хурлын гишүүд нь баахан авчихсан. Үгүй ээ, тэгээд энд би буруу юм яриад байгаа юм уу? Амартүвшин. Үгүй ээ, чи авсан чинь худлаа юм уу? Яана аа, одоо ингэж хэлж байна шүү дээ. Одоо тэр Баярцогттой яг ижилхэн байгаа байхгүй юу. Иймэрхүү улсуудыг Их Хуралд оруулж ирээд, тэгээд өнөөдөр Их Хурлын нэр хүндийг энэ чинь төрийн эрх барих дээд байгууллага шүү дээ, тэгэхэд энд өнөөдөр нөгөө улс төрчдийн авсан зээлийг төлөх тухай яриад байж байгаа байхгүй юу, төр баталгаа гаргаж. Тэгээд ингээд төлөөд ингээд явах юм бол дараагийн банк, дараагийн сангууд чинь тэгээд л байхгүй болно шүү дээ.

Г.Занданшатар: Өнөөдрийн энэ хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал бол багцаараа явж байгаа учраас төсвийн тухай хуулиуд,

дагалдах хуулиуд дээр тухайн үедээ ярих юм байна.

Ингээд хэлэлцэх асуудалд орно.

Уучлаарай, 2 гишүүн байгаа юм байна. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: 7 жил биш 5 жилээр тэтгэврээ тогтоолгох гэж байгаа Монгол Улсын иргэд ээ, ирэх 2 дахь өдөр цөмөөрөө энэ талбай дээр гарч жагсаал хийж, энэ хуулийг урагшлуулахгүй бол болохгүй нь ээ.

Бас нэг зүйлийг бас тайлбарлаж хэлэх нь зүйтэй байх. Энэ хуучин Оюунчимэг Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байж байхдаа ажлын хэсэг Чинзориг гишүүнээр ахлуулаад гаргуулчихсан юм байх гэсэн чинь огт тийм тушаал гаргалгүйгээр явчихсан байна. Тийм учраас Чинзориг даргатай ажлын хэсэг огт байгуулагдаагүй байсныг өчигдөр мэдлээ. Тэгэхээр бид энэ ер нь эрх баригч нар энэ хуулийг явуулах ямар ч сонирхолгүй байгаа юм байна. Тийм учраас энэ 2 дахь өдөр буюу хэдний өдөр байна, 8-ны өдөр 11 сарын 08-ны өдөр ахмадууд цөмөөрөө энэ жагсаалаа хийцгээе ээ. Их олон хүн хэрэггүй ээ, би эхний ирсэн 200, 300 хүнд автобусны мөнгийг нь өгнө өө, халуун аарц өгнө өө. Тэгэхдээ бас ингээд цөөхөн гэсэн гээд нэгэндээ найдаад битгий найдчихаарай, бас бүгдээрээ ирэхийг бодоорой. Тэгээд энэ хуулийг урагшлуулж энэ урагшлуулахгүй бол болохгүй байна.

Нийт тэтгэвэр авч байгаа хүмүүсийн чинь 91 хувь нь, цаашидаа 93 хувь нь 400000, 500000 төгрөгийн л тэтгэвэртэй байх нь хамгийн доод хэмжээндээ л байгаад байх юм байна.

Тийм учраас энэ тэмцлийг өрнүүлж байж энэ ядаж 100, 150000 төгрөгөөр тэтгэврээ нэмэгдүүлэх энэ ажлыг хийхгүй бол ерөөсөө болохгүй нь гэдгийг нэгдүгээрт хэлье. Тэгээд ахмадууд минь 11 сарын 08-ны өдөр, 2 дахь өдөр Сүхбаатарын талбай дээр уулзъя гэж, 12 цагаас уулзацгаая гэсэн ийм уриалгыг гаргаж байна.

2-т нь, энэ эрх баригч нар энэ дотроо асуудлаасаа ярь, тэр намынхаа бүлэг дээр ярь, энд хийгдсэн, бүх янз янзын асуудлууд чинь та нарын л өөрсдийн чинь асуудлууд байгаа. Тэгээд ингээд юу руу Их Хурал руу оруулж ирээд л нам дотроо юм хумаа ярихгүй, тэгээд тэр Даваасүрэн гишүүнийг тэр Төсвийн байнгын хорооны дарга болгочихгүй яасан юм бэ, та нар. Тэгээд сайд болгочихгүй, тэгээд л ингээд л хэрүүл хэл ам хийгээд байх юм. Түүнийгээ та нар дотроо ярьж байгаарай, тэгээд энэ ер нь бол эрх баригч нар энд одоо 1 өглөө чуулганы асуудал дээр үг хэлэх бол нэг их тийм зохистой биш, ер нь бол сөрөг хүчин л үг хэлэх ёстой юм байгаа юм.

Г.Занданшатар: Тэтгэврийн хуулийн асуудал ЗГ-аас өргөн баригдсаны дараа хэлэлцэнэ.

Эрхэм гишүүн Болдын Жавхлан үг хэлнэ.

Б.Жавхлан: Гишүүдийнхээ өглөөний мэндийг эрье, минут яваад байдаг. Их Хурлын дарга энэ минут яваад байна, яах вэ? Ярьж байх уу.

Гишүүдийнхээ өглөөний мэндийг эрье. Манай Даваасүрэн гишүүн маань сүүлийн үед зөндөө л доромжиллоо, зөндөө л гүтгэлээ, зөндөө л тэвчлээ. Даваасүрэн гишүүн

уг нь олон удаа парламентад суусан манай туршлагатай, бас сайн үлгэр үзүүлэх ёстой ийм гишүүдийн нэг гэж би боддог. Харамсалтай нь энэ парламентыг яаж өөртөө, өөрийнхөө улс төрд яаж ашиглаж болдгийг, харин яруу тодоор сүүлийн үед нэлээн бүр туршлага нь цөмөрчихсөн нь харуулж байгаа юм.

Саяын ярьсан зүйлүүд дээр би тайлбар хэлсэн. Мөн сая тэр төсөвтэй холбоотой тэр ЗГ-ын боомттой холбоотой асуудлуудыг хэлэлцээд явахад нь би тодруулаад хэлнэ ээ, өнөөдөр надад цаг бага байгаа учраас би зүгээр өөр зүйл хэлэх гэсэн юм. Даваасүрэн гишүүн маань өөрөө шударга үнэний туйлд, ийм дүрд гүйгээд байдаг, цаанаа бодит үйлдэл нь ямар байгааг мэдэж байгаа хүний хувьд бодоход үнэхээр харамсмаар зүйл болж байгаа шүү, үнэхээр харамсмаар зүйл болж байгаа юм. Зүгээр сүүлийн үед юу болж байгаа гэхээр ганц нэг зүйлийг нь хэлэхээс өөр аргагүй болж байна. Уг нь энд нэг их яриад байх зүйл биш, харамсалтай л юм болж байгаа юм.

Гишүүн маань Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргаар ажиллаж байсан, 12-20 онд ажиллаж байсан, улс төр судлаач Цэрэнбадамын Гансүх гэж залууг энэ Гансүх гэх залууд ямар хүнийх нь буруу байх вэ, Дарханы арьс ширний цогцолбор бүтээн байгуулалт ТӨҮГ-ын захирлаар томилуулсан, томилуулсан. Одоо тэнд юу болж байгаа вэ. Монгол улс жилдээ нэг 650000 үхрийн шир л боловсруулдаг, үүнийг бүтэн боловсруулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж шүү, зөвхөн тоног төхөөрөмж нь нэг 13-14 сая долларын ийм үнийн судалгаа мэргэжлийн холбоодод байдаг.

Монгол Улсад богийн нэг сая ширхэг арьс боловсруулахад 3-4 сая долларын тоног төхөөрөмж шаардлагатай. Ингээд нөгөө арван сая арьс шир боловсруулж байсан үйлдвэр маань одоо 4,4 сая арьс боловсруулдаг, тоо нь буураад, хөрөнгө оруулалт нь нэмэгдчихсэн байгаа.

Хуучин ТЭЗҮ-ээр нь тоног төхөөрөмж нь, зөвхөн тоног төхөөрөмжийн шүү, 30-аад сая доллар, барилга байгууламж, дэд бүтэц нь нийлээд нэг 60-аад сая доллар л болох л ийм ТЭЗҮ байсан. Одоо юу болсон бэ гэвэл 159 сая евро болсон. 160 сая евро. Гишүүн маань өөрөө эрчим хүчний мэргэжилтэн хүн, гэнэт арьс ширний үнэ болоод гадаадад очоод үйлдвэр дотор ороод селфидээд гүйгээд байсан. Энэ 160 сая еврогоос 103 сая евро дээр нь ЗГ-ын баталгаа гаргая гээд хүсэлтээ ирүүлчихсэн байгаа. Тун удахгүй бид энэ ямар ч боломжгүй ээ, ийм ийм хуультай юм. Ийм хуулийн хүрээнд энэ чинь эрсдэлтэй байна. Бодит байдал дээр ТЭЗҮ нь хэт зөрүүтэй байна. Ийм хариуг өгнө.

Таны яриад байдаг нөгөө үнэлэмжээр бодит үнэн, шударга байдал чинь энэ үү? Та сонсчих, та сонсчих, энэ бүгдийг нь та хийж байгаа юм, бүгдийг нь та хийж байгаа. Ийм байна. Зүгээр би нэг хэсгийг л хэлж байгаа юм шүү, нэг хэсгийг л хэлж байгаа. Та тайван сонсож сур.

Г.Занданшатар: Энэ хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна.

Гишүүд үг хэлж дууслаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлж суръя.

Хэлэлцэх асуудалд орно.

Нэг.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх /Монгол Улсын Ерөнхийлөгч 2022.10.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

ЗХЖШ-ын даргаар томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Ажлын хэсэг ороод голд сууя.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар таныг индэрт урьж байна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн Сүнрэвийн Ганбямбыг ЗХЖШ-ын даргаар Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг танилцуулж байна.

Сүнрэв овогтой Ганбямба нь 1975 онд Улаанбаатар хотод төрсөн, 47 настай, 1983-1993 онд нийслэлийн 33 дугаар дунд сургуулийг, 1994-1997 онд Цэргийн их сургуулийн Артиллер команд тактикийн ангийг, 2007-2009 онд Батлан хамгаалахын удирдлагын академийг стратеги тактик, команд штаб, 2017-2019 онд ОХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын академийг Төрийн цэргийн аюулгүй байдал мэргэжлээр тус тус төгссөн. Цэргийн ухааны магистрын зэрэгтэй, одоо ҮБХИС-ийн докторантурт

суралцаж байна. Афганистан улсад энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг удирдан оролцсон туршилагатай.

Тэрээр 1997-2007 онд Зэвсэгт хүчний ангиудад салааны захирагч, рот, батарейны захирагч, ангийн артиллерийн дарга, 2009-2012 онд Батлан хамгаалах удирдлагын академийн багш, ахлах багшаар, 2012 оноос БХЯ-нд тасгийн дарга, ахлах мэргэжилтэн, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгааны хэлтсийн дарга, Стратеги бодлого төлөвлөлтийн газрын даргаар ажиллаж байгаад 2021 оны 9 дүгээр сараас Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч даргаар томилогдон ажиллаж байна.

Бригадын генерал С.Ганбямба нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичиг, батлан хамгаалахын багц хуулийг боловсруулах, орон нутгийн хамгаалалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, улс орныг батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн салбарын эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажилласнаас гадна Зэвсэгт хүчний стратегийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах, цэргийн нийтлэг дүрмүүдийг шинэчлэх, зэвсэгт хүчнийг улс орны бүтээн байгуулалтын ажилд оролцуулах зэрэг томоохон ажлуудыг чадварлаг удирдан зохион байгуулж ирсэн.

Тэрээр цэргийн хэргийн мэдлэг боловсрол, ур чадвар, дадлага туршилагын хувьд Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан тушаалд тавигдах шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн

сургалтад хамрагдсан, цэргийн мэргэжлийн нэгдүгээр зэрэгтэй, мэргэшсэн төрийн албан хаагч юм.

С.Ганбямба нь зан төлөв, ёс зүйн хувьд төлөвшсөн, хамт олны дунд нэр хүндтэй, зэвсэгт хүчин, салааны захирагчаас ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хүртэл шат дараалан 30 жил тасралтгүй ажилласан удирдах албан тушаалтан, дээд офицер бөгөөд төрийн албаны мерит зарчмын дагуу дэвшүүлэн томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар Сүнрэвийн Ганбямбыг УИХ-тай зөвшилцөн томилох саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Г.Занданишатар: Эхлээд зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Жамъянгийн Мөнхбат нарын урилгаар Архангай аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс та бүхэндээ сурлагын өндөр амжилт, ажлын сайн сайхныг хүсэн ерөөе.

Одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Халдашгүй байдлын дэд хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох саналыг зөвшилцөхөөр 2022 оны 10 сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2022 оны 11 сарын 01-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн дэвшүүлсэн саналыг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Адьяаа гадаад улс оронд ажиллах, цэргийн атташег томилохдоо ямар байр суурь баримтлах, энхийг сахиулах ажиллагаанд оролцогчдын цалин хөлс, хангамж болон үүрэг гүйцэтгэх хугацаанд үүсэж байгаа зөрчлийг хэрхэн шийдвэрлэсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр энхийн бүтээн байгуулалтын оролцож байгаа Зэвсэгт хүчний анги, салбарыг тендер зарлахгүйгээр тодорхой бүтээн байгуулалтын ажилд оролцдог эрх зүйн орчныг бүрдүүлэх, дотооддоо цэргийн хувцас хэрэглэл, хүнсний бүтээгдэхүүнээр зуун хувь хангахад анхаарах, хугацаат цэргийн албан хаах хугацааг 1,5-2 жил болгон нэмэгдүүлж, эзэмисэн мэргэжилтэй халагддаг болгох, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хугацаат цэргийн албан хаагчийн эрүүл мэнд, амь нас хохирсон, халдварт сүрьеэ өвчин гарсан анги, салбарын удирдлагад хариуцлага тооцсон эсэх, ЗХЖШ-ын удирдлагуудын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалтад шат дараатайгаар хамруулах, хээрийн

сургуулийн бэлтгэлийг улс орны эрх ашиг, нөхцөл байдал, гадаад бодлоготой уялдуулан зохион байгуулдаг болох талаар ажлын хэсэг болон нэр дэвшигчээс тодруулан асууж, хариулт авсан.

Хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Энхболд орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийн явц байдал, цаашид авах арга хэмжээний тухай, ҮАБЗ, УИХ тухайн асуудлыг эрхлэх Байнгын хороонд Зэвсэгт хүчний хангалт, төсөв, хөрөнгийн талаар холбогдох мэдээллийг үнэн бодитойгоор өгдөг байх, кибер аюулгүй байдлын асуудалд анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн цэргийн анги, салбарын удирдагч нар өөрийн ажлын туршилага, ур чадвараа байнга дээшлүүлдэг байхаас гадна төрлийн цэргийн командын удирдлагын боловсрол, ажлын ур чадварыг нэмэгдүүлэх, бүтцийг бодит байдалтай нийцүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй гэсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар цаашид цэргийн хувцас, формыг дүрмийн дагуу хэрэглэдэг байх, энгийн хүмүүс өмсөж хэрэглэж байгааг цэгцлэх, хугацаат цэргийн албан хаагчдын эрүүл мэнд, амь нас хохирох явдлыг таслан зогсоох, дунд шатны дарга, удирдлагуудтай холбоотой харьцаа, хандлага, ёс зүйн зөрчил байгааг болон цэргийн албан хаагчдыг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, хамгааллын асуудлыг орхигдуулж байгааг анхаарах, эцэг эх, ар гэрт нь тухайн цэргийн албан хаагчийн талаарх мэдээллийг нээлттэй хүргэдэг утастай болгох, цэргийн эрдмээс гадна мэргэжлийн сургалт явуулахад анхаарч тухайн

аймаг орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтарч ажиллах, мэргэжлийн үнэмлэх олгох, орон нутагт байрлах цэргийн анги, салбарын барилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх, тохижуулах, их засвар хийх шаардлагатай байгаа талаар санал хэлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Д.Бат Эрдэнэ Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн Монголоороо бахархах, эх оронч үзлийг нэмэгдүүлэхэд анхаарах, Тэмүүжин Өрлөг цэргийн сургуулийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт цэргийн анги, салбарын дэргэд явуулж, хүүхдэд багаас нь эх орноороо бахархах, хүмүүжил олгох, төлөвшүүлэх, Монголын ирээдүйд шаардлагатай байгаа инновац, технологийн шинэчлэлд онцгой анхаарах, энэ чиглэлээр офицер, албан хаагчдыг бэлтгэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд Монгол Улс батлан хамгаалахын салбарын хувьд боловсон хүчний нөөц сайтай гэж үздэгээ илэрхийлээд хээрийн сургуулийг зохион байгуулах цаг хугацааг улс төрийн болон тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзаж тогтоодог байх, мэдээллээ олон нийтэд зөв түгээх шаардлагатай байгаа талаар саналаа илэрхийллээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан цэргийн анги салбараас эхлээд рот, батарейн захирагчаар ажиллаж, мерит зарчмаар дэвшсэн, салбартаа 29 жил тасралтгүй ажилласан нэр дэвшигчийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Улсын Их Хурлын гишүүний хэлсэн саналуудыг ажилдаа

хэрэгжүүлж, өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнц, бүс нутгийн нөхцөл байдал эгзэгтэй энэ үед Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, шинэ дэвшилт техник, технологи, инновацыг нэвтрүүлэх, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг чадавхжуулах, туршлагажуулах, эмнэлэг, инженерийн ротыг бэхжүүлэх, энхийг сахиулах ажиллагаанд цэргийн албан хаагчдыг оролцуулах, улс орны стратегийн томоохон бүтээн байгуулалтад барилга, инженерийн цэргийг оролцуулж байгааг дэмжих, бүс нутгийн аюулгүй байдал, хөрш орнуудын харилцаанд анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй гэсэн болно.

Монгол Улсын ЗХЖШ-ын даргаар Сүнрэвийн Ганбямбыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг томилох тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг зөвшилцсөн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалахын бодлогын зөвлөх Цэвэгсүрэнгийн Тогоо, нэр дэвшигч ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга,

бригадын генерал Сүнрэвийн Ганбямба.

Ерөнхийлөгчийн санал, байнгын хорооны санал, дүгнэлт болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу.

Баярсайхан гишүүнээр тасаллаа. Балжиннямын Баярсайхан гишүүнээр тасаллаа. Одоо Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Ганбямба генералыг л дэмжиж байна. Бас цэргийн байгууллагад гуч гаруй жил ажилласан, шат шатны ажил хийж байсан ийм бас бригадын генералыг оруулж ирж байгаад бас талархаж байна. Ингээд нэг 2 асуулт асууя.

Манай Дорноговь аймгийн Зүүнбаян гэж баг байдаг, Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг гэж. Хуучин бол Зүүнбаянгийн дивиз байсан, сүүлийн жилүүдэд Зүүнбаян анги өргөтгөөд мотобуудлагын хороо болсон байж байгаа, маш олон цэргийн албан хаагч нар гэр бүлтэйгээ очиж бас суурьшиж байгаа. Тэдний орон сууцны асуудлыг бас нэгдүгээрт шийдэж өгөх шаардлагатай байна. Зүүнбаян бол хэзээнээсээ Монгол Улсын томоохон дивиз байсан, орон сууцны материаллаг бааз, тухайн үед бас нэлээн материаллаг бааз байсан. 90 оны хувьчлалаас хойш бүгдийг нь хувьчилснаас болоод ингээд шинээр очиж байгаа цэргийн офицерууд, цэргийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүс маань бас байргүй байгаад байна. энэ дээр бас та нэг анхаараач гэдгээ бас асуумаар байна.

2 дахь асуудал бол манай Зүүнбаян дээр барилгын цэргийн ангийг яаралтай байгуулж өгөөч ээ. Ер нь томоохон төсөл хөтөлбөр, хөтөлбөрүүд томоохон төслүүд бол Дорноговь аймаг, Өмнөговь аймаг дээр л явагдаж байна. Сая Энхболд гишүүнийг Батлан хамгаалахын сайд байхад 2 ч томоохон хэмжээний төмөр замын ажил бол хийгдээд дууссан. Цаашидаа ч гэсэн Эйч-3 гээд хурдны зам тавигдах гээд нефть боловсруулах үйлдвэр гээд томоохон төсөл хөтөлбөрүүд бас хэрэгжиж байна. Тийм учраас Зүүнбаянгийн цэргийн ангийг дагалдуулсан барилгын цэргийн ангийг байгуулахад бас та ямар санал хүсэлтэй байдаг вэ? Энэ дээр байгуулбал бас үр дүнтэй юм биш үү гээд.

3 дахь асуудал бол Зүүнбаян дээр хуучин байсан цэргийн ангийн барилга байгууламж хуучирсан, үүнийг нэг буулгаж өгөх, цэвэрлэх энэ ажил дээр бас нэг анхаарч өгөөч ээ. Хуучин Зүүнбаянд цэргийн прокурорын барилга гээд байсан, танай цэргийн тэр 332 дугаар ангид шилжүүлж өгсөн, шатсан, балгас нь байгаад байдаг, үүнийг цэвэрлээд орон сууц барьдаг ч гэдэг юм уу, өөр юу гэдэг юм цэргийн өөр объектыг барих ийм бололцоо боломж байгаа юу?

Ер нь нэг Зүүнбаян нэг жоохон цэгцэлмээр байна, хогноос нь салгамаар байна. Хуучин цэргийн анги нэгтгэлүүдийн хуучин барилга балгасаас нь бас салгаж, цэвэрлэх зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Энэ дээр та бас нэг хариулт хэлж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 84, нэр дэвшигч Сүнрэвийн Ганбямба.

С.Ганбямба: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Дорноговь аймгийн Зүүнбаян баг дээр хуучин мотобуудлагын том дивиз байсан. Түүний суурин дээр өнөөдөр Зэвсэгт хүчний хороо ажиллаж байгаа. Орон сууцны хуучин барилгуудыг сэргээн сайжруулах, алба хаагчдынхаа амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд ЗХЖШ, БХЯ-тайгаа хамтраад жил бүр тодорхой төсөв хөрөнгө суулгаж, сэргээн сайжруулах үйл ажиллагааг явуулж байгаа. Мөн орон нутгийн зүгээс бас нэлээдгүй бидэнд бас дэмжлэг үзүүлж байгаа, цаашидаа энэ ажлыг үргэлжлүүлнэ гэсэн бодолтой байна.

Цэргийн анги байгуулах асуудлын хувьд өнөөдрийн нөхцөл байдлаар Зэвсэгт хүчинд Говь-Алтай, Архангай аймагт шинээр барилга, инженерийн цэргийн анги байгуулчихсан, өнөөдөр бүтээн байгуулалтын ажлууд явагдаж байгаа. Тэгээд улс орны төсөв хөрөнгө хүндрэлтэй байгаа учраас үүнийг бол бас БХЯ, ЗГ-ын түвшинд ярьж байгаад шийдэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж бодож байна. Хуучин барилгуудын буулгах асуудал дээр зэвсэгт хүчин дэмжлэг үзүүлж болно оо, Энхтүвшин гишүүн ээ, тийм. Энэ дээр би тантай хамтраад холбогдох техник хэрэгслийг гаргаад энэ асуудал дээр хамтарч ажиллах нь бэлэн байна. Илтгэж дууслаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Салдангийн Одонтүяа асуулт асууж, үг хэлнэ.

С.Одонтүяа: 2 асуулт байна. Өнгөрсөн жил энэ цэргийн алба хааж байхдаа амь насаа алдсан цэргүүдийн асуудал бол нэлээд бас анхаарлын төвд байсан. Тэгээд бид бол нэг

зөвхөн асуудал гарангуут нь нэг шуугиад өнгөрдөг биш, энэ дээр байнгын хяналттай үйл ажиллагаанууд явуулж байя гэсэн. Ингээд Хүний эрхийн дэд хороо хуралдаад танай байгууллагад чиглэл өгсөн байгаа. Энэ чиглэлийн дагуу сая ажлаа өгсөн Ганзориг дарга болон байгууллагынхан богино хугацаанд бол маш сайн ажилласан, надад тайлангуудаа ирүүлсэн. Та яг энэ ажлаа аваад энэ ажлууд цаашид та ажлаа аваад энэ чиглэлээр яг онцгой анхаарч яаж ажиллах вэ? Цаашидаа энэ цэргийнхэн амь насаа алдахгүй байх дээр, ялангуяа энэ ар гэрийнхэнтэй нь холбоотой байх гомдол саналыг авах, энэ чиглэлээр яг юу хийх вэ? Нэгдүгээр асуулт. Яагаад гэхээр цэргүүд бол өөрсдөө тийм гомдол гаргаад бас байдаггүй юм байна.

2 дахь асуудал бол энэ Байнгын хороон дээр бас нэлээд ярьсан байна, гишүүд. Цэрэг, эх оронч үзлийн талаар. Одоо бид энэ үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа ч гэсэн заасан байгаа. Тэгэхээр энэ ялангуяа хүүхэд, залуучуудад, иргэдэд энэ эх оронч үзэл энэ гамшигийг ослын үед яаж анхан шатны тусламж үзүүлэх вэ, бие биедээ яаж туслах вэ, энэ бол маш чухал асуудал болчихоод байна. Өнөөдөр эрин үед. Та сая мэдлээ, Солонгост бол осол болоход залуучууд бол ерөөсөө ямар ч ойлголтгүй байна шүү дээ. Цагдаагийнхан ч гэсэн сандарсан үед ямар ч арга хэмжээ авч чадсангүй. Тийм учраас та яг ажлаа аваад энэ чиглэлээр ямар ажлуудыг хийх вэ? Учир нь бусад орнуудад бол тусгай байгууллагууд ажилладаг, мэдээж манайх төсөв хөрөнгөгүй үед байгаа боломж, байгаа бааз дээрээ л

суурилж ажиллах нь ээ. Тэгэхээр та энэ 2 асуултад хариулна уу.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхтайваны Бат-Амгалан нарын урилгаар БЗД-ийн 28 дугаар хорооны иргэд, мөн Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын ЕБС-ийн 1982 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Асуултад бригадын генерал Сүнрэвийн Ганбямба хариулна, 84.

С.Ганбямба: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбарууд дээр хугацаат цэргийн алба хааж байгаа залуучууд эрүүл мэндээр хохирох, мөн амь насаа алдах асуудлууд байгаа. Энэ чиглэлээр бас Хүний эрхийн дэд хороо, мөн ХЭҮК-оос тодорхой судалгаа ажлууд явуулаад бид нарт бас тодорхой зөвлөмж, чиглэлүүдийг өгсөн байгаа. Үүнийг бол ЗХЖШ хэрэгжүүлж ажиллаж байгаа. Тухайлах юм бол БХЯ, ЗХЖШ дээр ард иргэдийн гомдол саналыг хүлээж авах тусгай дугаар ажиллуулж байгаа. Өмнө нь яам дээр байсан бол энэ жил бид нар бас Зэвсэгт хүчний Жанжин штаб дээрээ бас тийм тусгай дугаар нээсэн. Түүнчлэн хугацаат цэргийн алба хаагчдын амьдарч ажилладаг, суралцдаг бүх объектууд дээр камерын хяналтын системийг зохион байгуулж ажиллаж байгаа.

Мөн хугацаат цэргийн алба хааж байгаа залуучуудыг ар гэртэй нь холбох анги дээр бас тусгай утас ажиллуулах, ялангуяа тухайн алба хаагчдыг хариуцаж байгаа дарга нарын утсаар холбох энэ асуудлыг бол бид нар 2021 оны цэрэг татлагаас эхлээд ажиллуулсан байгаа. Цаашидаа энэ цэргийн албаны осол гэмтлээс хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй, санамсаргүй байдлаар амиа алдах гэх мэтчилэн ийм асуудлуудын хувь хэмжээг багасгах чиглэлээр бол зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд дээр нэлээдгүй ажил арга хэмжээг хийж хэрэгжүүлэе гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

2 дугаар асуултад хариулъя. Цэрэг эх оронч үзэл, хүмүүжлийг өсвөр насны хүүхдүүдэд олгох бол хамгийн чухал асуудал байгаа. Тэгээд ЗГ-ын түвшинд хүүхэд, залуучууд, цэрэг эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөр БШУЯ, БХЯ хамтраад гаргасан. Мөн түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар БХЯ, Зэвсэгт хүчний Жанжин штабын хамтарсан ажлын хэсэг байгуулаад яг таны хэлж байгаа энэ хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгох сургалт, сурталчилгаа, тэгээд бодитой арга хэмжээнүүдийг хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Энэ дээр Зэвсэгт хүчний Жанжин штаб өөрийн анги салбар алба хаагчдаа оролцуулахаар ажиллаж байгаа. Илтгэж дууслаа.

Г.Занданшатар:

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Туваан: Өнөөдөр оруулж ирж байгаа асуудлыг дэмжиж байна. Тэгээд хэдэн зүйл хэлээд тодорхой нэг

3 асуулт байна. Тэгээд цэргийнхэн бол бас тушаалаар явдаг, миний аав бас цэргийн хурандаа Цэвэгдорж гэж буурал хурандаа бий. Тэгээд артиллерч мэргэжилтэй. Тэгэхээр энэ цэргийн тэтгэвэртээ гарсан ахмадуудын асуудал байгаа. Цэргийнхэн маань бас тусгай чиг үүргийн улсууд эрт тэтгэвэрт гардаг, тийм ээ. Тэгээд тэтгэвэрт гарсан хойноо бас ажиллах, тэд нарын нийгмийн асуудал дээр бас та БХЯ-тайгаа хамтарч ямар ажил хийх вэ, хэрэгжүүлэх вэ гэдэг ийм асуултыг асууя.

Манай Төв аймгийн хувьд бол зэвсэгт хүчний 3 анги нэгтгэлтэй. Туул голын хойно, урд тал, Таван толгойн гэж бид нар ярьж заншсан, дээрээс нь Алтанбулаг суманд тийм, энэ бас Алтанбулаг сумын нутагт голынхоо урд хойно хоёр 016 гээд аймгийн төв дээр. Тэгэхээр энэ дээр энэ цэргийн ангиуд хоорондоо бас уулзах мөн цэргийн янз бүрийн үйл ажиллагаанууд явуулахад бас хоорондоо уулзах ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр энэ Туул гол гээд нэг том байгалийн барьер байгаа, тийм ээ, Туул голыг гаргах гээд. Тэгээд ингээд явахаар, бас бүр Улаанбаатараар ингээд дамжиж явдаг нэг ийм асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр та бас санал гаргаад бас яамтай хамтраад, орон нутагтай хамтраад энэ нэг асуудлыг шийдчихвэл цэрэг гэлтгүй бас ард иргэдийн түүгээр дамжиж тойрч явахгүй, чирэгдэлгүй явах энэ асуудал бас шийдэгдэх юм болов уу гэж. Өнгөрсөн жилийн төсөв дээр Алтанбулагийн тэр гүүр тавигдаад ороод ирсэн боловч чиг харамсалтай нь төсвийн тодотголоор хасагдсан. Тэгэхээр энэ дээр ажиллах хүч болон юу талаасаа цэргийнхэнд маань бас

хөвдөг гүүр ч гэдэг юм уу, түр тавьдаг гүүр гээд бас асуудлууд байдаг. Энэ дээр боломж нь ямар байдаг юм бол оо гэсэн нэг ийм асуултыг асууя.

Тэр Монгол Улс бол би түүхэндээ ер нь ганцаараа, дангаараа хийсэн бүтээн байгуулалтууд дундаас бол энэ хамгийн том нь энэ төмөр замын бүтээн байгуулалт гэж хардаг. Үүнийг цэргийнхэн маань бол маш сайн гүйцэтгэсэн гэж ингэж боддог. Тэгэхээр энэ дээр таны бодол, цаашидаа ийм бүтээн байгуулалтад оролцох тал дээр ямар бодлого гаргаж ажиллах вэ гэдэг ийм бодол байгаа.

Тэгээд сүүлд нь бол энэ тэгээд энэ дотроо энэ цэргүүд нь ажиллангаа орлого олох, нэгэнтээ тэнд хөдөлмөр эрхэлж байгаа юм чинь данстай дансандаа мөнгөтэй ингээд эцэг эхдээ очвол зүгээр байгаа юм. Өөрсдийнх нь амьдралд ч гэсэн бас хэрэгтэй. Тэгэхээр энэ дээр нэгтгээд тэр саяын бодлогоо хариулчхаарай.

Дараагаар нь энэ эдийн засаг хүндэрч байна, инфляц өсчихсөн байна, тээвэр ложистикийн хүндрэл, хүнсний бүтээгдэхүүний хангамж, эд материалын үнийн өсөлт гээд ингээд хүндрэлүүд гарч ирж байна. Энэ дээр энэ цэргийн албан хаагчид, офицер, ахлагч нар цэргүүдийнхээ энэ хоол, хүнс, хангамжийн асуудал чинь ер нь хүрч байгаа юу? Сургуулийн хүүхдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоол, цэцэрлэгийн хүүхдийн хоолонд хүрэхээ больчихсон. Тэгэхээр энэ дээр бол цэргүүдийнх мэдээж нас биед хүрсэн ийм хүмүүсийн хоолны хангамжид бол энэ энергийн асуудал нэлээн чухал байгаа. Тэгэхээр энэ дээр

хүрч байгаа юу? Энэ жилийн төсөв хэлэлцэгдэж байгаатай холбогдуулаад төсөв дээр тодорхой нэмэгдлүүд, хэрвээ нууц биш бол орж ирж байгаа юу гэсэн ийм асуултуудад хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ, 84, Сүнрэвийн Ганбямба бригадын генерал хариулъя.

С.Ганбямба: Туваан гишүүний асуултад хариулъя. Тэтгэвэрт гарсан ахмадууд бас манай зэвсэгт хүчинд нэлээдгүй байдаг, тэгээд алба хаах онцлогоосоо шалтгаалаад бас нэлээдгүй олон анги салбараар явж ажилладаг учраас бас нөгөө ахмадын хорооны харьяаллын асуудал тодорхой биш, ийм асуудлууд тулгамддаг. Тэгэхээр эхний ээлжид БХЯ, Зэвсэгт хүчний Жанжин штабынхаа Ахмадын хороотой хамтраад харьяалал нь тодорхой бус ахмадуудаа харьяалалтай болгоё оо, тухайн ангид нь харьяалуулаад, тэгээд тэр ахмадуудад хэрэгжүүлж байгаа халамжийн асуудлууд, тодорхой арга хэмжээнүүд бас оролцуулаад явъя гэсэн бодолтой байгаа.

Зэвсэгт хүчний 3 анги Төв аймгийн нутаг дэвсгэр дээр байрлаж байгаа. Гүүрний хувьд бол би Батлан хамгаалахын яам мөн Зам, тээврийн хөгжлийн яамтай санал солилцож байгаад бас танд тодорхой хариулт өгье гэж бодож байна.

Зэвсэгт хүчин сүүлийн жилүүдэд бүтээн байгуулалтын ажлуудад улс орны стратегийн бүтээн байгуулалтын ажлуудад оролцож байгаа. Тухайлах юм бол Таван толгой Зүүн баян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад

оролцсон. Энэ 2022 онд Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын үндсэндээ дөрөвний нэгийн доод бүтцийн ажил, мөн 35 километр дээд бүтцийн ажлыг тодорхой чанарын түвшинд гүйцэтгээд захиалагчид хүлээлгэж өгсөн байгаа. Цаашидаа Зэвсэгт хүчний барилга, инженерийн цэргийн бие бүрэлдэхүүнийг энэ бүтээн байгуулалтын ажлуудад оролцуулна гэсэн бодолтой байгаа. Төр засгаас үүрэг чиглэл өгсөн тохиолдолд бол энд ямар нэгэн татгалзах зүйл байхгүй, боломж байгаа.

Цэргийн алба хаагчийн хоол хүнсний, хувцасны хангалтын хувьд бол хүнд байгаа. Сүүлийн жилүүдэд төсөв батлагдахдаа бол ихэвчлэн хоол хүнсний төсөв бол багасгаж танаж батлагдаж байгаа. Ялангуяа энэ 2022 онд 2 удаа тодотгол хийсэн, автоматаар хасагдсан. 2023 оны төсөв дээр ч гэсэн хүнсний нормативд зардал 21 хувиар, хувцасны зардал 50 хувиар буурч өмнөх онд батлагдсантайгаа, түүнээс бол яг хэрэгцээт зардлын дөнгөж 7-10 хувийг хангаж байгаа ийм төсөв батлагдаж байгаа. Тэгээд цаашидаа ЗГ, Улсын Их Хурлын эрхэм гишүүдтэйгээ хамтраад, бас зэвсэгт хүчний төсвийг, цэргийн алба хаагчдынхаа ажил ажиллаж амьдрах орчин нөхцөл, нийгмийн хамгааллын асуудал, хангалтын асуудлыг бас сайжруулах тал дээр цаашид дээшлүүлэх талаар ажиллана гэсэн бодолтой байна. Илтгэж дууслаа.

Г.Занданшатар:

Цэвэгдөржийн Туваан гишүүн тодруулъя, 1 минут.

Ц.Туваан: Улс орны нүүр, сүр жавхаа цэрэгтээ байдаг. Ялангуяа

манай Монгол шиг ийм төрт ёсны агуу уламжлалтай ийм улсын хувьд. Тэгэхээр энэ дээр энэ хасагдаж байгаа тоонуудыг сонсоод бол харамсаж байна. Энэ дээр Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Ерөнхийлөгч, тэгээд Тамгын газар нь зөвлөхийнх нь зүгээс энэ хасагдал дээр ямар бодлого барих юм бэ. Одоо яг төсөв хэлэлцэж байгаа энэ үед л ярихгүй бол эргээд 24 он хүртэл энэ асуудал бол орхигдоно гэж ингэж бодож байна. Тэгэхээр нэгэнт ажлын хэсэг ороод ирчихсэн энэ боломжтой байгаа, төсөв хэлэлцэж байгаа энэ хугацаан дээр энэ өмнөх жилүүдээс ингээд хасаад байдаг. Ялангуяа дэлхий нийтэд энэ дайн байлдааны цэргийн мөргөлдөөний ийм цаг үед бол хасаж болмооргүй байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар асуудлыг яаж оруулж ирж байгаа вэ гэсэн асуу ... /минут дуусав/

Г.Занданшатар: Тогоо генерал хариулах уу, Содбаатар. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар дарга хариулъя.

Я.Содбаатар: Туваан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол нийт улсын төсөв хэлэлцэж байгаатай холбогдуулж УИХ-аас баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар, ялангуяа урсгал зардлууд дээр бол нэлээн хасалтууд ирж байгаа. Энэ ганцхан ЗХЖШ дээр ч биш, ерөөсөө энэ төрийн цэргийн бүх байгууллагууд төдийгүй төрийн байгууллагууд дээр ярьж байгаа. Энэ хүрээнд бас манай зэвсэгт хүчний, ялангуяа анги нэгтгэлүүд дээр яг газар дээр нь очиход бол хүндрэл гарч байгаа зүйлүүд бий. Тэгээд мэдээж улс орны хэмжээнд амаргүй нөхцөл байдалд эдийн засгийн нөхцөл байдалд байгаа учраас энэ дээр бол бид нар нийтлэг

бусад төрийн байгууллагуудтай нь адилхан авч үзэж байгаа хүрээнд л авч үзэж байгаа юм онцгойлж, Улсын Их Хуралд Зэвсэгт хүчний ерөнхий командлагчаас чиглэл өгч байгаа зүйл байхгүй байгаа.

Г.Занданшатар: 1 гишүүний асуулт, үг хэлсний дараа санал хураалт явуулах тул гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Баярсайхан: Юуны өмнө ЗХЖШ-ын даргад нэр дэвшиж орж ирж байгаа бригадын генерал Ганбямба танд баяр хүргэе. Миний асуух байсан нэгдүгээр асуултыг Одонтүяа гишүүн асуусан, та хариулсан учраас би УИХ дахь Хүчирхийллийн эсрэг лобби бүлгийг санаачлаад аваад явж байгаа. Энэ улс оронд байгаа бүх төрлийн хүчирхийллийн эсрэг бас үр дүн гаргах гэж ажиллаж байгаа гишүүний хувьд өнөөдөр манай зэвсэгт хүчний салбарт цэргийн алба хааж байгаа хүүхдүүдийн, залуучуудын дунд ямар нэгэн байдалд бусдаар хүчирхийлэгдэж гэмтэж бэртэх, амь насаа алдах асуудал бол цаашид байж болохгүй юм гэдгийг бол өнөөдөр бол онцгойлон хэлэхийг хүсэж байна.

Мөн сая өмнөх гишүүдийн хэлсэн энэ цэргийн алба хааж байгаа залуучуудын хоолны шим тэжээлийн асуудал, хувцасны асуудал бол үнэхээр дээд түвшинд байх ёстой. Тэгээд энэ жилийн төсөвт энэ төсвийг хасуулахгүй байх тал дээр бас та Батлан хамгаалахын сайдтай, энэ Сангийн сайдтай хамтарч яаралтай ажиллаж энэ ажлын хэсгийн гишүүд

бас байж байна. Энэ төсөв хасуулахгүй байхад бас та ажиллаарай гэж ингэж хүсэж байна.

Хоёрдугаарт, 2014 оноос хойш Монгол Улсад “оюутан цэрэг” гэдэг маш сайхан төсөл хэрэгжсэн, өнөөдрийн байдлаар 7000 гаруй хүүхэд энэ “оюутан цэрэг”-ийн албыг хаагаад байгаа. Энэ төсвийн хувьд ч гэсэн хэмнэлттэй байдаг. 1 жил цэргийн алба хаахад 5 сая төгрөгийн төсөв зарцуулагддаг бол “оюутан цэрэг”-ийн алба хаахад 1 сая төгрөг зарцуулагддаг байгаа. Одоо энэ ганцхан төсөв мөнгө биш, оюутан залуучуудад эх орондоо хайртай байх, яг амьдралд гарч байгаа залуучуудыг эр хүнийх нь хувьд бэлтгэх, хүчтэй хүн болгох, өрсөлдөх чадвартай, амьдралд тэмцэх чадвартай, эх орноо хайрлах ийм сэтгэлтэй ийм залуучуудыг бэлддэг байсан энэ төсөл энэ оны төсөв дээр 1000 оюутан цэрэг жил болгон бэлддэг байсныг 100 болгож бууруулж орж ирсэн байна Тэгэхээр та маш яаралтай, бас Батлан хамгаалахын сайдтай, энэ Сангийн сайдтай, төсвийн ажлын хэсэгтэй уулзаж ярилцаж энд байгаа гишүүд маань ч гэсэн энэ төсвийг хасуулахгүй байх тал дээр бас дэмжиж өгнө гэж итгэж байна. Тэгээд оюутан цэргийг жилд мянгаар нь бэлтгэдэг энэ ажлаа цаашид нь бид нар үргэлжлүүлээд явмаар байна. Энэ бол маш үр дүнтэй, 2014 оноос хойш хэрэгжсэн ийм төсөл байгаа. Тэгээд та энэ дээр мэдсэн үү. Энэ сүүлийн асуулт дээр нэг ер нь базаад танаас нэг хариулт авчихъя. Баярлалаа.

Г.Занданшатар: 84. Нэр дэвшигч Сүнрэвийн Ганбямба.

С.Ганбямба: Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

“оюутан цэрэг” хөтөлбөр 2014 оноос хэрэгжээд, 2016 онд Цэргийн албаны тухай хуульд хуульчлан оруулаад, жил бүр тасралтгүй хэрэгжиж явж байгаа. Энэ асуудал бол оюутан цэргийн сургалтын асуудал цэвэр БХЯ-ны эрхлэх асуудал байдаг. Үүнийг би бас анхааран үзэж Батлан хамгаалахын сайдтай санал солилцъя. Таны саналыг хүлээж авч байна. Илтгэж дууслаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Асуулт асуух, үг хэлэх 2 хамт явж дуусчихсан шүү дээ. Дэмжсэн, дэмжээгүй үг байхгүй, энэ зөвшилцөж байгаа учраас. Хэлэлцэх эсэх асуудал биш.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 107.2-т нэгдсэн хуралдаан, Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсон, нууц санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ гэж заасны дагуу Байнгын хорооны саналаар нууц санал хураалт явуулна. Нууц санал хураалтад бэлдэнэ үү.

Байнгын хорооны саналаар ЗХЖШ-ын даргаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Сүнрэвийн Ганбямбыг томилох саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураана. Санал хураалт явуулна, санал хураалт.

Санал хураалтад 62 гишүүн оролцож, 42 гишүүн дэмжиж, 67,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүдийн хэлсэн цэргийн дэг журам, цэргийн хангамж олон асуудлын талаар хөндлөө. Түүнийг сайн анхаарч ажиллахыг хүсье.

Тэгээд санал хураалтын дүнг Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

Зочид танилцуулъя.

Орон сууц, нийтийн аж ахуй үйлчилгээний ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооны ажлын алба болон гишүүн байгууллагуудын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрхэм хүндэт ахмадууд болон үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтнүүд та бүхэндээ ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

11.06 цаг

Дараагийн асуудалд орно.

Хоёр. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 23 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025

оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024 оноос 2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя.

Чимэдийн Хүрэлбаатар Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого,

төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү төсвийн судалгааны газрын дарга, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Төлбөрийн тэнцлийн хэлтсийн дарга.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Сангийн сайд аа, энэ Батлан хамгаалахын сайд байгаа юм болов уу? Байхгүй юм шиг байна. Жавхлан сайд аа, 1 зүйл асууж тодруулах гэсэн юм. Батлан хамгаалах салбараас энэ 2014 оноос хойш хэрэгжүүлж байгаа “оюутан цэрэг”-ийг жилд 1000

оюутан цэрэг цэргийн алба хаадаг байсныг 100 болгочихсон байна гээд ингээд ярих юм. Тэгээд энэ оюутан цэргийн тоог яагаад хассан юм бол оо? Уул нь энэ нь залуучуудаа төлөвшүүлэхийн тулд Монгол хүн хүнээ хөгжүүлэхийн тулд, бэлтгэхийн тулд хийж байгаа нэлээн том ажил, бас эх орноо батлан хамгаалах, цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дээрээс нь хугацаат цэргийн албанаас хамаагүй бага төсөвтэй, 5 дахин бага төсөвтэй, ийм үр дүнтэй ийм сайн төсөл хэрэгжиж байсан. Тэгээд энэ 1000 гэдэг тоо чинь л 100 болж буух гээд байна гэж ярих юм. Энэ дээр нэг хариулт тодруулга авах гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Мижиддоржийн Санжаадорж 80.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр “оюутан цэрэг” хөтөлбөр бол ковидын цар тахал гарсантай холбоотойгоор 2020, 21 онуудад бол нэлээд бол тоо нь буурсан байсан. Тэгээд хөл хорио тогтоосонтой холбоотой буурсан, 21 оноос бол буцаж сэргэж эхэлсэн. 21 оны гүйцэтгэлтэй нь уялдуулж 22 он дээр бол тоо нь бол буурсан байгаа. Одоо бол 245,8 сая төгрөг “оюутан цэрэг” хөтөлбөрт бол зарцуулагдахаар энэ жилийн төсөв дээр бол батлагдсан байгаа. Ирэх жил бол бас энэ дүнгээр байгаа.

Г.Занданшатар: Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотойгоор энэ уг нь ХХААХҮ-ийн сайд энд байвал би бас асууя гэж бодож байсан. Өнөөдөр энэ дээр орж ирж байгаагаар бид ямар ч байсан нэг төсвөө аль болохоор алдагдалгүй баталчих гэсэн зорилго Улсын Их Хурлын зүгээс ч тавьж байгаа, ЗГ-аас ч гэсэн төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд, өмнөх жилүүдтэй харьцуулахад бас тодорхой хэмжээгээр ингээд бууруулж орж ирж байна. Ер нь цаашидаа бид нар ер нь төсвийг алдагдалгүй батлах нь өөрөө энэ улс орны эдийн засаг, тэр дундаа ДНБ-д эзлэх хувь хэмжээ энэ тэр их чухал ач холбогдолтой гэдэг талаас нь бол хандаж байгаа. Жишээлбэл 2023 онд шинэ объектууд нэмэхгүй, харин хуучныг бүгдийг нь дуусгана гэж орж ирж байгаа үүнтэй уялдаад санхүүжилтийн тоо 430 орчим тэрбум төгрөгөөр чинь нэмэгдэж байгаа гэж байгаа юм.

Одоо бид нар 2023 онд төсвийн хүрээний мэдэгдлээс харж байхад ЗГ-ын нийт өрийн хэмжээ өнөөгийн үнэ цэнээр харьцуулаад үзэхэд маш өндөр дүнтэй байгаад байгаа. Бид нөгөө Самурай бонд, Чингис бонд, гэрэгэ гээд л баахан өвөг дээдсийнхээ нэрээр авсан энэ их зээлүүдийг эргэж төлөх ажил 2023 оноос бол эрчимтэй явагдана. Тэгэхээр одоогийн байдлаар манай улсын гадаад зээлжих зэрэглэл бас гаднаас таатай нөхцөлөөр зээл босгох хэмжээ нь хувийн хэвшил ч, ЗГ-ын түвшинд ч нэлээд хомсдол байгаа. Тэгэхээр би бас Сангийн сайдаас бид энэ төсвийн хүрээний мэдэгдэл хийж байхдаа яг энэ 23 онд эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад энэ Монгол Улсынхаа зээлжих зэрэглэл үүнийг өсгөх тал дээр жишээлбэл, бид яг ямар бодлого

барьж, юу хийж байна вэ. Сая ОУВС-ийн хурал Вашингтон хотод болсон, энэ дээр ч гэсэн Монгол Улсын нэр хүнд, эдийн засгийн тал дээрээ бас асуудлууд яригдаж байсан. Ялангуяа ТӨХК-уудын үр ашгийг нэмэгдүүлэх асуудлууд манайтай харьцдаг ажлын хэсгийн дүгнэлтэд ч орсон байсан л даа.

Тэгэхээр энд зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэхдээ нэгдүгээрт барьж байгаа бодлогыг асууя.

2-т нь, жишээлбэл, өчигдөр ЗГ-ын хуралдааны дараа тэр Эрдэнэс таван толгой дээрээ онцгой Ганбат дарга ярьж байна лээ л дээ. Энэ богинохон хугацаанд гарч байгаа нүүрсний экспорт эрс нэмэгдлээ гээд ярьж байна л даа. Тэгвэл 2023 оны 11 сард ингэж овоо огцом нэмэгдэж байгаа бол он гартал илүү эндээс олж ирэх ашиг нэмэгдэнэ гэсэн тооцоог 23 онд жишээлбэл энэ тооцоолол дээр зарлага, орлого тал дээрээ та нар бас үүнтэй уялдуулж өөрчлөлт орох, яг батлахаас өмнө тийм дүр зураг байгаа юу. Одоо экспортод өчигдөр ярьж байна шүү дээ, нүүрсний экспорт эрс нэмэгдлээ, гарч байгаа автомашины тоо хэд дахин нэмэгдлээ гээд өчигдөр Ганбат дарга ярьж байна лээ л дээ. Тэгвэл ингэж богинохон 14 хоногийн хугацаанд ингэж эрс нэмэгдэж байгаа юм чинь 2 сарын хугацаанд орж ирэх экспортын орлого, нүүрснээс илүү нэмэгдэх дүр зураг хэрвээ энэ маягаараа бол харагдаж байна л даа. Тэгвэл үүнтэй холбоотойгоор орлогын талаасаа нэмэгдэх ийм тооцоо та нар маань зүгээр хийж үзэж байгаа юу. Энэ нэгдүгээр асуулт байна.

2 дахь нь, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу бид хүүхдийнхээ мөнгийг ингээд 91 хувьд нь өгөхөөр ингээд орж ирж байна, энэ бол бас сайн хэрэг ээ. Сая өглөө Пүрэвдорж гишүүн маань ингээд амар ажил биш, яг бичиг хэргээрээ ажил хийж сурах хэрэгтэй байна. Нийгмийн бодлогын байнгын хорооны бүр 4 сард Улсын Их Хурлын гишүүн Чинзоригоор ахлуулсан ажлын хэсэг гараад ажлын хэсэгт нь Ганбаатар, Идэрбат, Сандаг-Очир, Оюунчимэг, Туваан гэсэн гишүүд гараад ажиллаж байгаа. Тэгэхээр амаар ажил хийх биш, Байнгын хорооноос нь албан ингээд бичгийг нь аваад бодит юмыг бас ярьж байх хэрэгтэй байна. Бүр ажлын хэсэг байгуулах тухай тогтоол гарчихсан, 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр гэж байгаа юм. Тэгэхээр үүнийг бас бодитоор харж байгаарай гэдгийг хэлье. Энд бас хариултаа өгөх байх. Ингээд асуултдаа хариулт авъя.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ? Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Оюунчимэг чиний асуултад хариулъя. Ер нь тулгамдсан ойрын хугацааны бидний ер нь гол асуудлуудыг хөндөж асуулаа, баярлалаа. Энэ удаагийн оруулж ирж байгаа төсөв маань ерөөсөө бүхэлдээ яг саяын, таны 3 зүйл дурдлаа, эхнийх нь тэр манай гадаад өрийн байдал, зээлжих зэрэглэл гээд үүнтэй холбоотой олон асуудлуудыг ЗГ-аас авч хэрэгжүүлж байгаа, үр дүн ч гарч байгаа. Яг хамгийн гол асуудал, үр дүн харагдах зүйл нь бол яг таны хэлж байгаа зөв, энэ бол зээлжих зэрэглэл. Ер нь манайтай ижил зээлжих зэрэглэлтэй олон улсууд нэлээн хүнд байдалд орж байгаа, нэлээн хүнд

байдалд орж байна. Зэрэглэлүүд нь буурч байна. Ийм үед бидэнд том шалгуур тулж байгаа юм. Гэсэн хэдий ч өнгөрсөн 3 жилийн бид гадаад өрнийхөө стратегийг маш сайн сахилга баттай нарийн чанд барьж ирсний үр дүнд, мөн ирэх жилийнхээ бид 3 жилийн стратегиа их зөв баталсан. Үүний үр дүнд, бид Хөгжлийн банкаа мөн сүүлийн жилийн хугацаанд муу зээлүүдийг нь төлүүлж, мөн энэ жил 2 ч удаа тодотгол хийж, төсвийн хэмнэлтийн горимд бид маш үр дүнтэй сайн ажиллаж чадаж байна.

Мөн сүүлийн 2 улирал дараалан бид экспортоо тодорхой хэмжээгээр сайн нэмж чадлаа. Эдгээрийн үр дүнд, мөн, бид төсвийнхөө алдагдлыг бууруулах тал дээр зохих арга хэмжээнүүдийг авч байна. Мөн шат дараатай, сүүлийн 3 жилд бид төсвийнхөө алдагдлыг сайн бууруулж ирж чадаж байгаа юм. Ийм олон ажлуудын үр дүнд бид энэ жил 3 зээлжих зэрэглэл тогтоодог агентлагаас үнэлгээгээ тогтвортой хамгаалж чадсан. Энэ бол маш сайн. 6 сард бид нар эс эн би пикчерс тогтвортой хэвээр үлдээж чадлаа. Сая Мудис мөн манай үнэлгээг хэвээр нь үлдээгээд явлаа. Ингэснээр ЗГ-ын төдийгүй хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт гадаад өрөн дээр дахин санхүүжилт хийх зохицуулалт хийх ийм боломжуудыг бас хангаж байгаа гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, зээлжих зэрэглэлийг тогтвортой байлгана, чанаржуулна гэдэг маань үндсэндээ ЗГ, төрийн бүтээмж, шинэ сэргэлтийн бодлогын төрийн бүтээмжийн нэг том ажлуудын нэг юм байгаа юм. Энэ чиглэлээр ингэж ажиллаж байна.

Мөн дээрээс нь бид 23 оныхоо төсвийг өргөн барихдаа хэд хэдэн реформ шинэчлэлтүүдийг шингээсэн байгаа. Үүнийг Их Хурал маань дэмжиж төсвийг хэлэлцэж байгаад бид талархалтай байгаа.

Нүүрсний хувьд үнэн. Сүүлийн 2, 3 дугаар улирлын хувьд бол бид үндсэндээ 19 оныхоо түвшинд очиж чадсан, Ковидын өмнөх. Энэ эрчээ алдахгүй, бид нар 23 онд нүүрсээ гаргах зорилго тавьж ажиллаж байгаа. Энэ бол зорилгоос гадна бид нарын бол үүрэг хариуцлага, ЗГ-ын хувьд. Олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг юм байгаа юм. Сайн л экспорт гаргах ёстой, тэгэх юм бол богино хугацаанд бидний одоо тулчгаад байгаа энэ хүндрэлүүд арилах бүрэн боломжтой потенциалны бид нар экспортлогч орон юм.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя, 1 минут.

М.Оюунчимэг: Сангийн сайд бол тодорхой хариулт өглөө, баярлалаа. Энэ дээр бас нэг зүйл байгаа юм.

Хэрэглээний үнийн өсөлтийн түвшинг 2023 оны энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр 8 хувьтай гэж орж ирж байна л даа. Одоо бол 13, 14 хувь бараг инфляц байгаа шүү дээ. Тэгэхээр 8 хувь дээр барих чадах уу? Ялангуяа би Болорчулуун сайдаас асуух гэсэн юм. Сая иргэдтэйгээ ингээд уулзалтууд хийгээд явж байхад гурилын үнийн 30 хувийн өсөлт, айл өрхүүдийн орлогод дэндүү том дарамт болж байна. Одоо жишээлбэл гэр хорооллын айл өрхүүд, энэ манай энэ ЧД-ийн энэ 1, 2 дугаар хороод гээд л ингээд л хараад үзэхэд 8

нэрийн барааны дэлгүүрт хамгийн их борлогддог зүйл нь гурилан бүтээгдэхүүн байсан. Одоо иргэд маань гурилан бүтээгдэхүүнээ авч чадахгүйд хүрч байна, бараг зарим айл өрхүүд талхыг таллаж авах гэж байна. Яагаад гэхээр гурилын үнийн энэ их өсөлт маш огцом, цочроо өгч байна гэж байгаа юм. Тэгэхээр бид нар цаашидаа яах вэ, ингээд гурилаа өсгөөд байх уу. Уг нь бол бид нар татаас маягаар газрын тосонд, нефть бүтээгдэхүүн дээр, гурилан бүтээгдэхүүн дээр, будаа гээд ... /минут дуусав/

Г.Занданишатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсье.

Хаянгаагийн Болорчулуун сайд ХХААХҮ-ийн сайд асуултад хариулна.

Х.Болорчулуун: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ гурил, будааны үнэ өсөөд мэдээж энэ чинь хамгийн өргөн хэрэглээний бараа болохоор хүмүүсийн амьдралд шууд нөлөөлж байгаа. Тэгэхдээ энэ гурил, будааны үнэ сүүлийн 4, 5 жил бол өсөөгүй ийм тогтвортой байсан гол хүнс бол гурил юм. Түүнээс гадна үнэ гэнэт 30 хувиар өслөө гэж байна. Үүнийг үнэ тогтворжуулах хөтөлбөр гэж өөрийн чинь хэлснээр хууль хавар баталсан. Тэгэхдээ энэ бол нэр нь бол

буруу хууль байсан юм гэдгийг бас хэлмээр байна. Яагаад гэвэл үнэ тогтворжуулах хөтөлбөрөөр бол зөвхөн 10 хувийн инфляцын өсөлтийг л хязгаарлаж чадна. Гэтэл гурил, будаанд орох зардал чинь өөрөө 50-60 хувь болчихоод байна. Би зүгээр газар тариалангийн гол бүтээгдэхүүн, улаан буудай гэхэд түлш энэ жил ноднингийнхоос 40 хувь өслөө, ургамал хамгааллын бодис 80 хувь өслөө, бордоо нь 100 хувь өсчхөөд байна.

Г.Занданишатар: Болорчулуун сайд гүйцээгээд хариулчих, товч тодорхой хариулъя.

Х.Болорчулуун: Тэгэхээр үнэд ЗГ-аас шууд оролцоод үнэ тогтворжуулъя гэвэл энэ 50 хувийн зардлын өсөлтийг эс үгүй бол ЗГ-аас төсөв дээр тавьж олгоно, ингэж байж үүнийг тогтворжуулахаас биш ингээгүй 10 хувийн өсөлтийн зардлын өсөлтийг тогтворжуулчихаад бүх үнийг тогтвортой байлгана, өсгөхгүй гэж хэлж болохгүй юм. Тэгэхээр бол ер нь тэгээд зах зээлийн жамаараа үлдсэн хэсэг нь явахаас өөр аргагүй болж байгаа юм. Хэрвээ хэт хатуу үнэ бариад улсаас дэмжлэг үзүүлэхгүйгээр хэт хатуу юм баривал угаасаа энэ салбар чинь өөрөөр хэлэхэд богино хугацаанд дампуурна шүү дээ гэж хэлэх байна.

Г.Занданишатар: Орцууд, шатахуун энэ тэр өссөн л дөө, бас тийм ээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын хуулийн хүрээнд төсвийн хүрээний мэдэгдлийг ирэх 3 жилээр хуульчлан баталдаг. Тэгэхээр энэ бол төсвийг тогтворжуулах гэж, төсвийн бодлогыг тогтвортой байлгах гэж

хийж байгаа ажлын нэг хэсэг. Гэтэл яг энэ төсвийн тогтвортой байдлын хууль гэдэг зүйл чинь бараг төсвийн тогтворгүй байдлын хууль гэдэг зүйл болж хувирч байна. Жил бүхэн өөрчилдөг, тодотгол бүхнээрээ өөрчилдөг, жилдээ хэд өөрчилдөг, яг үнэндээ энэ хуулийн хэрэгцээ шаардлага, утга агуулга, зорилго гэдэг зүйл бүр байхгүй болж хувирлаа.

Тэгээд гол зүйл ЗГ, УИХ-д мөн дараа жилийн төсвийг өмнөх жилийн 10 сарын 01-ний дотор өргөн барьдаг. Өргөн барихдаа тухайн үеийн хүчин төгөлдөр хуулийн хүрээнд өргөн барих ёстой. Яг өнөөдөр 22 оны 5 сарын 27-нд баталсан Төсвийн хүрээний мэдэгдэл чинь өнөөдөр хүчин төгөлдөр хэвээрээ байгаа. Гэтэл та нар хүчин төгөлдөр хуулийн хүрээнд биш, энэ хуулийг дагуулж явж байгаад өөрчилчихнө гээд, одоо ингээд төсөвтэйгөө цуг төсвийн хүрээний мэдэгдэл нь цуг явж байна. Энэ чинь яг төсөвтэй холбоотой болоод Монгол Улсын хуулиудыг зөрчсөн асар том зөрчил энд чинь яваад байгаа юм биш үү. Хуучин хууль чинь хүчин төгөлдөр үйлчилж байхад шинэ хуулийн хүрээнд төсвөө өргөн барьчихсан, үүнийгээ хэлэлцээд явж байдаг. Хэрвээ энэ чинь Үндсэн хуулийн зөрчил болоод олон зүйл бол юу болж хувирах юм. Төсвөө татаж аваад УИХ Төсвийн хүрээний мэдэгдлээ эхэлж батлаад, батлагдсан төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд нийцсэн төсөв орж ирэх ёстой биз дээ. Хэрвээ энэ Үндсэн хуулийн зөрчил болох юм бол 11 сарын 15, олон зүйл цаана нь яригдах ёстой байх. Тэгэхээр энэ дээр яагаад энэ ер нь энэ төсвийн хүрээний мэдэгдэл гэдэг, одоо сая ингээд харахаар 9 үзүүлэлттэйгээр баталдаг юм байна. 9 үзүүлэлтийн бараг 9

үзүүлэлтийн 7 гол үзүүлэлт нь 7-уулаа өөрчлөгдсөн. Энэ жил 3 дахиа өөрчлөгдөж байна. Төсвийн тогтвортой байдлын хуулийн дагуу дагаж гардаг, хуулийн үйлчлэлтэй зүйл. Тэгээд тэр энэ хариуцсан хүмүүс нь тэр төсөв өргөн барихдаа яагаад хүчин төгөлдөр хуулийн хүрээнд биш өргөн барьсан, одоо дагаж явж байгаа энэ төсвийн хүрээний мэдэгдлийг өнөөдөр хэлэлцээд явж байгаа, батлагдаагүй байгаа төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд төсвийг өргөн барьчихаад байгаа юм бэ. Энэ чинь өөрөө асар том үр дагавар дагуулах нь ээ, энэ дээр гол нь хариулт өгөөч.

Г.Занданшатар: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь гишүүний тавьж байгаа шүүмжлэл, агуулгатай бол би ерөнхийдөө бол санал нийлж байна. Сүүлийн ер нь нэг 10 гаран арваад жил бид яг ийм зүйлтэй тулж ирсэн байна. Энэ бол харамсалтай зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, түүнд заасан тусгай шаардлагууд, саяын таны дурдсан төсвийн хүрээний мэдэгдэл, энэ бүгдийгээ бид маш сайн төлөвлөөд, дунд, урт хугацаанд нь төлөвлөөд, яг түүнийхээ дагуу, төлөвлөснийхөө дагуу ингээд явах нь бол өөрөө энэ урт хугацааны хөгжлийн тогтвортой байдлыг хангах хамгийн зөв зарчим юм байгаа юм. Харамсалтай нь бид энэ байдал руу санасан хэмжээгээр явж чадахгүй хэмжээнд олон жилийн хуримтлагдаж ирсэн макро түвшинд сахилга батгүй, ялангуяа гадаад өрөн дээр, ялангуяа гадаад өрөн дээр, мөн дотоод талдаа ч гэсэн хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө

оруулалтын бодлогоосоо үүдсэн жил бүрийн энэ урсгал зардлын хүчтэй тэлэлтүүд гээд эдгээр зүйлүүд дээр алдсан, оносон зүйлүүд байгаа.

Харин бид сүүлийн жилүүдэд шүү, сүүлийн жилүүдэд төсвийн шинэчлэл, реформыг хүчтэй хийх гэж ингэж зорьж байгаа. 1 жил, хагас жилийн дотор нэг төсвөөр энэ бүхнийг шийдэж бол чадахгүй. Бид шат дараатай үүнийг шийдэж явна. Яг таны хэлж байгаа сая тэр хуулийн зөрчлийн хувьд бол цаг хугацааны хувьд бол тийм зөрчил байхгүй ээ. Бид төсвөө өргөн барьсан, төсөвтэй цуг төсвийн хүрээний мэдэгдлийн энэ өөрчлөлтүүд батлагдаад, цаашаагаа ингээд ямар нэг зөрчилгүй ингээд үргэлжлээд явах юм, тийм. Тэгэхээр одоо бидний том зорьж байгаа, харин төсвийн реформ, энэ шинэчлэлүүд, ирэх жилийн өргөн барьсан 23 оны төсөвт тусгагдсан олон шинэчлэлүүдийг Их Хурал дээрээ бид дэмжээд энэ төсвийн шинэчлэлүүдийг ЗГ дээр дэмжээд ингээд явуулна гэдэгт бид итгэлтэй хүлээж байгаа.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя, 1 минут.

О.Цогтгэрэл: Хамгийн гол нь тэр одоо хүчин төгөлдөр байгаа төсвийн хүрээний мэдэгдэл хуульчлан гарсан төсвийн хүрээний мэдэгдлийг зөрчөөд төсөв өргөн барьчхаад байна шүү дээ. Тэгээд хэлэлцээд яваад байдаг. Сүүлд нь дарааллын хувьд төсвийн хүрээний мэдэгдлээ батлангуутаа төсвөө маргааш нь баталчих гээд байна л даа. Гэтэл энэ чинь өргөн барихаасаа эхлээд хүчин төгөлдөр төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд өргөн баригдах ёстой биз дээ. 10 сарын 01 гэхэд энэ

төсвийн хүрээ чинь энэ төсөвтөө нийцээд батлагдчихсан байх ёстой биз биз дээ гэдэг тодорхой цаг хугацааны тийм огноо, хугацааг л яриад байна л даа, би.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний санаа зовоод байгаа зүйл зөв өө, зөв. Энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид нар 9 тоо л байдаг шүү дээ, 9 макро тоо. Энд өөрчилж байгаа ганц л тоо байгаа юм, тэр нь алдагдал юм байгаа юм. Өөрөөр хэлбэл бид ирэх жил 3,6 хувь байх ийм боломжтой, тусгай шаардлагаараа. Үүнийгээ бид нар 2,8 болгож нааш нь татаж байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл сайжруулж байгаа нэг л ийм л тоо байгаа юм. Үүнийг өөрчлөөд өгөөч ээ, бид нар ингээд сайжруулж байгаа юм. Энэ чинь төсвийн хүрээний мэдэгдэл дээр ийм 3,6 хувь гээд өндөр алдагдал байгаа, үүнийг 2,8 болгоод өгөөч ээ, бид нар ирэх жил эндээ багтаагаад сайжруулъя л гэсэн юм байгаа юм.

Тэгэхээр төсвөө ч батална, төсвийн хүрээнийхээ мэдэгдлээ ч баталчихаар ингээд төсөв нь ч сайжраад, өсвөрийн мэдэгдэл дээр байгаа макро тоо нь нэг тоо нь ядаж сайжраад ингээд л явчих юм байгаа юм. Алдагдлаа сайжруулж байгаа тоо л өөрчлөгдөж байгаа шүү.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Одонтуяа: Сангийн сайдаас асууя. Ер нь энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль гэж ер нь батлахгүй, Төсвийн тогтворгүй

байдлын тухай хууль гээд баталж болох уу? Ер нь тийм жишиг байна уу? Манай хууль чинь яг тийм л болчхоод байна л даа. Яагаад гэхээр 2010 он одоо энэ бид нарын яриад байгаа төсөвт чинь хамгийн чухал үр нөлөө үзүүлдэг хууль бол Төсвийн тогтвортой байдлын тухай хууль. 2010 оноос хойш энэ хуулийг нийт 13 удаа өөрчилсөн байна шүү дээ. Тэгэхээр үүнийг чинь ямар тогтвортой байдлын хууль гэх вэ. Тийм болохоор би тэр тогтворгүй байдлын хууль гэж байдаг бол ер нь баталбал бараг эсрэгээрээ энэ ажил чинь сайн явах юм биш үү гэж хэлэх гээд байгаа юм.

Бид нар энэ төсвийн хүрээний мэдэгдлээ 3 жилээр, ер нь ингээд хөдлөхгүй тооцоод ингээд явъя гэсэн хэр нь байнга л өөрчилж байна шүү дээ. Одоо бараг жилд 4 удаа тодотгож байна. Тийм болохоор энэ олон гишүүдээс ч бас тийм санал гараад байгаа. Ер нь энэ төсийн хүрээний мэдэгдэл энэ тэр гээд ийм нэг ямар ч шаардлагагүй цаг үрсэн ийм зүйлээ ер нь больчихвол яасан юм. Нэгэнтээ л биелдэггүй юм чинь, нэгэнтээ л худлаа юм чинь ерөөсөө зүгээр бүгдээрээ амьдралд яг ойрхон, илүү практикт илүү, ийм зүйлүүд дээрээ ажиллавал яасан юм бэ.

Ер нь бол энэ бид нар, дэлхий даяараа л олон улсын байгууллагууд бид нарт нэг л зүйлийг анхааруулаад байгаа юм. Төсвийн хатуу сахилга баттай бай л гэж байгаа юм. Тэгэхээр төсвийн энэ хатуу сахилга батыг бид нар мөрдөхгүйгээр ерөөсөө явахгүй. Би энэ төсвийн сүүлийн 15 жилийн хугацаанд хийсэн судалгаа гээд энэ Булгантуяагаар ахлуулсан судалгааг бүр нэг бүрчлэн бүр үзлээ. Тэр Төсвийн тогтвортой байдлын

зөвлөл гээд бас манай хуучин эдийн засагчид байгаа, бас нэг бүрчлэн үзлээ, ерөөсөө л нэг л зүйлийг хэлээд байгаа байхгүй юу, ерөөсөө л төсвийн сахилга батгүй байна гээд л. Хэн дуртай нь өнөөдөр өөрчилж байна шүү дээ. Бид нар чинь нэг муу ч, сайн ч нэг Монгол Улсын Их Хурал шүү дээ. Тэгээд энэ Их Хурал нь ямар ч мэдэл байхгүй, тэгээд хэдэн хүмүүс нэг юм оруулаад л ирдэг, түүнийг нь гар өргөөд л баталдаг, ийм баймааргүй байна. Ер нь энэ урт хугацаандаа л тогтвортой байх асуудлыг хэлэлцэхээс биш, дандаа нэг ийм цаг зуурын юм болчхоод байна л даа. Тэгээд одоо бүр сайхан, нөгөө ковид руугаа бүр чихдэг ийм болоод байгаа юм.

Нөгөөтээгүүр бас энэ, бид нар энэ төсвөө хийхдээ бас нийт ард иргэдэд бас илүү хүртээмжтэй, тэгш боломжтой ийм зүйлүүдийг батлах ёстой. Гэтэл өнөөдөр яаж байна гэхээр ерөөсөө зарим аймаг нь нэг хүнд оногдох улсын хөрөнгө оруулалтаараа бүр хэчнээн тэрбум гарчихсан, зарим аймаг нь бараг юу ч байхгүй, иймэрхүү л байж болохгүй. Үүнийг бол зохицуулах хамгийн чухал арга юу вэ гэхээр би санаж байна, Бат-Үүл хотын дарга байхдаа нийслэлийн бүх хороод дээр эрүүл ахуй, аюулгүй байдлын индекс гэж гаргаж байсан юм. Тэгээд өөрөөр хэлбэл аль хороон дээр энэ асуудал нь ноцтой байна, тэр хороон дээр нь илүү хөрөнгө оруулалтуудыг нь ингэж тавьж өгч байсан. Тийм учраас бид нар нэг ийм жоохон судалгаатай, бас нэг нийт ард иргэдээ бодсон ийм төслүүдийг хийж баймаар байна.

Та нар Аргентины жишээ бол бид нар нэлээд л ярьдаг шүү дээ, ерөөсөө Аргентин улс бол энэ төсвийн

тогтвортой байдал, төсвийн хүрээгээ л өөрчлөхгүй, маш сайн, сахилга баттай барьж чадсанаар энэ нь бол эерэг нөлөө үзүүлсэн гээд л дэлхийд, тэгэхээр юмны нэг сайныг нь сурчихмаар байна л даа. Юмнуудын сайныг нь. Одоо Хятад улс гэхэд л 30 жилээр юмаа төлөвлөж байна. Бараг манайд ирээд индэр дээр хэлэхдээ юу гэлээ. Бид нар ойрын жил 100 жилийн төлөвлөгөө гээд л ингээд ярьж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар 5, 6 сар ч гэсэн үүнийгээ барихгүй байдаг, үүнийгээ л нэг больчихмоор байна, бүгдээрээ.

Тийм учраас би энэ бараг тогтворгүй байдлын хууль гээд, яагаад үүнийгээ алдаагаа засах чиглэлээр явбал яасан юм бэ л гэсэн ийм саналтай байна.

Г.Занданишатар: Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар Ментора коллежийн багш, суралцагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ментора багийн хамт олондоо хамгийн сайн сайхан сурлагын өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Би тантай бас заримтай нь санал нийлж байна. Энэ тогтвортой байдлын тухай хуулийг бид нар маш чанд сахиж ирэх хэрэгтэй. Харамсалтай нь сүүлийн 12 оноос хойш нийтдээ 13 удаа өөрчлөлт орсон гэж байгаа,

Таны хэлж байгаа үнэн. Түүхийг нь харах юм бол 2012-16 оны хооронд 8 удаа өөрчлөлт орсон байдаг юм, 2012-16 оны хооронд. 16 оноос хойш ингээд 5 удаа өөрчлөлт орж байна. Ингээд харах юм бол яг хямралын үед 2 удаа, одоо энэ 8 өөрчлөлтийн 4 нь тусгай шаардлагын өөрчлөлт байдаг шүү, бусад нь өөр одоо хуулийнх нь өөр бусад заалтууд. Энэ тусгай шаардлагуудын өөрчлөлтийг сая ковидын үед 1 удаа л өөрчилсөн, 1 удаа өөрчилсөн. 11 онд 1 удаа, 15, 16 онд тус бүр 1, 1 удаа тусгай шаардлагуудыг өөрчилсөн байдаг юм.

Харин энэ удаа бид тусгай шаардлагыг өөрчлөөгүй, 23 оных дээр өөрчлөөгүй. Өөрөөр хэлбэл тантай таны хэлж байгаа тэр зорьж байгаа зүйлтэй бид санал нийлж байна гэсэн үг. Ингээд төсвийнхөө сахилга батыг бид нар барихын тулд бүр хууль гаргалаа. Төрийн хэмнэлтийн тухай хууль гаргалаа, төсвийн тусгай шаардлага бид өөрчилсөнгүй, дараагийн 3 жилийнхээ гадаад өрийн стратегийнхаа төлөвлөгөөг бид 3 жилээр Их Хурлаараа батлуулж авлаа. Ингээд энэ дүрмээрээ энэ хүрээн дотроо явъя гэдэг дээрээ л Их Хуралдаа бид тайлагнаж байна гэсэн үг. Түрүүн Цогтгэрэл гишүүн асууж байна, 3,6 хувь гээд бид нар төсвийн хүрээний мэдэгдлээрээ хязгаараа заачихсан байгаа байхгүй юу, алдагдлаа. Бид нар тэр хүрээн дотроо ажиллах ёстой, өөрөөр хэлбэл өргөн барьж байгаа хууль маань 2,8 хувийн алдагдал гээд тэр хүрээн дотроо байгаа юм. Гэхдээ үүнийг нааш нь бүр татчихъя, 3,6 биш 2,8 болгоод бүр татаад хуульчилчихъя гэж бид нар илүү ажил хийж орж ирж байгаа юм. Тэрийг өөрчлөхгүй ч бас байсан болно. 3,6 дотроо цаашаа явчхаж болох байхгүй юу.

Уг нь сайн ажиллаж, сайжруулж байгаа ажил хийж оруулж ирээд байгаа санаатай юм. Тэгэхдээ Одонтуяа гишүүний хэлж байгаа агуулгатай бид санал нийлж байна. Ер нь бол төсвийн тогтвортой байдлын хууль тусгай шаардлагуудаа цаашаа бол чанд сахиад явахыг бид нэгдүгээр зорилго болгож ингэж ажиллана. Та хэд маань ч гэсэн дэмжээрэй.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Түүний дараа санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Б.Баттөмөр: Энэ төсвийн хүрээний мэдэгдэл дээр яах вэ, 23 онд эдийн засгийн өсөлт 5 хувь, төсвийн орлого 18,9 их наяд төгрөг гэж байгаа. Одоо ингээд зарим хүмүүс их төсөв тэлчихлээ гээд л ингээд гаслаад байгаа юм. Тэлсэн юм ерөөсөө байхгүй шүү дээ. Монгол төгрөгөөр 3,5 их наяд төгрөгөөр тэлж байгаа юм шиг мөртөө нэг америк долларт шилжүүлэхээр нөгөө нэг 5,4 тэрбум доллар хэвээрээ л байж байгаа шүү дээ. Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг чинь тэр америк доллароор хэмжиж байгаа шүү дээ, Монгол төгрөгөөр хэмжихгүй, Монголчууд дотроо бол дэмждэг. тэгээд энэ нэг үг байдаг шүү дээ. Нөгөө нэг гутранги хүмүүсээр тоо бүү бодуул гэж. Энэ гаднын байгууллагууд бол бид нарыг шоолж байгаа байх л даа, энэ Монголчууд дэндүү гутранги юм гэж. Асар их потенциалтай. Мендлеевын үелэх системийн 106 элементийн 80 нь Монголын хөрсөнд байдаг, хөрсөн дээр болон дээр байгаа баялгаараа дэлхийд эхний нэг 10 хэдэд ордог, ийм

их потенциалтай, 30 жил, өнөөдөр 33,3 тэрбум долларын өртэй болчихсон, ийм л сууж байна шүү дээ. Тэгээд энэ би бол үүнтэй бол санал нэгдэхгүй байгаа, энэ болж байгаа үйл явдлуудтай. Тэгээд би энд ажлын хэсэгт хэд хэдэн санал бичиж өгсөн юм.

Монгол Улсын 2023 оны төсвийг тэр зардлыг нь хасахаа больё, орлогоо нэмээд тэр алдагдалгүй баталчих боломж байна гээд, алдагдалгүй батлах юм бол юу гэхээр зэрэг валютын хани тогтворжино, инфляц буурах гээд олон олон асуудлууд байгаа шүү дээ. Тэгээд энэ болгоныг ингэж тооцсон юм.

Энд бол юу юу байна гэхээр нэгдүгээрт нь энэ далд эдийн засаг 200 тэрбум төгрөгийг далд эдийн засгаас олно гэж байгаа юм. Энэ чинь ДНБ-ий 0,37 хувьтай тэнцэж байгаа байхгүй юу. Далд эдийн засгийн нэг хувийг ил болгооч гээд ингээд үзэхээр 345 тэрбум төгрөг олох боломж байгаа байхгүй юу. Энэ үл хөдлөх хөрөнгийн татвар газрын төлбөрийг 22 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээс бууруулаад тооцчихсон. Энэ дээр 134 тэрбум төгрөг нэмээд олчих боломж байна гээд ингэж.

Нүүрсний зах зээл дээр бөөн хулгай байгаа, сүүлийн үед болж байгаа үйл явдлуудыг та бүгд мэдэж байгаа, энэ хулгайгаа багасгая, тэр дэлхийн зах зээлийнх нь үнэд хүргэж худалдъя гээд ингээд үзэхээр бол 700-аад тэрбум төгрөг нэмээд олчих боломж байгаа.

Монголбанкны Ерөнхийлөгч, Монголбанкныхан 24 тонн алт авна гээд байгаа юм. Гэтэл 17 тонн алт

авна гээд ороод ирсэн байгаа юм. Үгүй ээ, 20 тонн болоод ирэхэд л энэ дундаас нь 54 тэрбум төгрөг, 24 болгочих юм бол 100 тэрбум төгрөг олчих боломж байгаа. Төрийн өмчит ААН-үүдээс 568 тэрбум төгрөг төсөвт төвлөрүүлнэ гэж байгаа юм. Асар их хэмжээний энд үргүй зардал гаргаж байна шүү дээ. Зарим улсууд 3, 4 удаа том том жийн уначихсан, асар өндөр цалинтай, маш их тансаг ийм байж байна шүү дээ, маш их хулгай байна, энэ болгоныг засах юм бол дахиад 100 тэрбум төгрөг эндээс төрийн өмчийн ААН-үүдээс олох боломж байгаа байхгүй юу.

Орлогыг нь тодорхойлох боломжгүй, ажил үйлчилгээнээс бас зөндөө их боломжууд байна.

Оюутолгойтой холбоотой асуудлууд. Оюутолгой дээр 1,9 тэрбум төгрөгийн зэсийн баяжмал гаргаад Монголд орж ирж байгаа нь 680 сая доллар. 3 доллар тутмын 1 нь орж ирж байгаа байхгүй юу. Тэгээд үүнтэйгээ ажиллаач ээ, үүнээсээ нэмэлт олох боломжууд байна.

Тэр Эрдэнэтийн овоолго гээд би тав дахь өдөр яриад байсан юм. Үүнийг худалдъя л даа, үнэгүй юм гэж хаана ч байдаггүй шүү дээ.

Энэ нууц гэрээнүүд байж байна, тэр урьдчилаа хийчихсэн гэрээнүүд байж байна, энэ болгоныгоо яагаад дайчлахгүй байгаа юм бэ? Яагаад ийм алдагдалтай, ийм гутранги ийм төсөв оруулж ирээд байгаа юм бэ? Үүнийгээ засаач гээд ингээд одоо нэгэнт Сангийн яамнаас ингээд л ороод ирчихсэн учраас энд ажлын хэсэг дээр ингээж засах боломж байдаггүй юм байна, төвөгтэй юм байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Болдын Жавхлан Сангийн сайд хариулъя.

Б.Жавхлан: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Асуулт, санал шүүмжлэл хэллээ гэж ойлголоо. Ер нь далд эдийн засгийг ил болгох, үүнийг дагасан, орлогоо дайчлах тал дээр манай ЗГ бол бүх чадлаараа л ажиллаж байгаа, бүх чадлаараа л ажиллаж байгаа. Ялангуяа манай гол орлогыг бүрдүүлж байгаа экспортын, ялангуяа уул уурхайн экспортын тээвэр ложистик, энэ хил, хилийн боомтын асуудлууд дээр бид маш хатуу ч гэсэн зарим талаар нэлээн хүнд тусч, зарим үед бүр хилээ хаалгах хүртэл ийм хүнд байдалд ордог. Гэсэн хэдий ч бид энэ дээр ухралгүй маш сайн арга хэмжээнүүдийг авч байгаа. Түүний үр дүнд харин ч далд байсан зүйлүүд ил болж, ялангуяа тээвэр ложистикийн татварын асуудлууд дээр бас багагүй хэмжээний бид орлого олж, орлогоосоо илүүтэйгээр тэр том эдийн засаг өөрөө аажмаар ил болж, зөв зарчим руугаа явж байгаа нь өөрөө их сайн хэрэг юм байгаа юм. Тухайлбал зөвхөн тээвэр ложистикт байна шүү дээ, нүүрсний, одоо би ганц урсгалыг нь хэлье. Гашиун сухайт, Цагаан хадны хооронд жилдээ үндсэндээ бараг тэрбумаас тэрбум 500 сая долларын ийм далд мөнгөний урсгал хилийн цаана явсан. Ажил нь манай талд хийгдсэн байдаг юм. Үүнийг бид том хуулийн зохицуулалтуудаар ил болгоно, ил болгож байгаа.

Улсын Их Хуралд өргөн барьчихсан байгаа энэ Уул уурхайн биржийн тухай хууль байгаа. Үүнийг Их Хурал маань дэмжиж бушуухан баталж өгнө гэж ингээж бодож

байна. Тэгэх юм бол хувийн, хувьсгалын бүх энэ Монгол Улсын экспортолж байгаа баялгууд арилжаа нь ил болно оо, ил болно. Зөвхөн тэнд арилжаалагдсан нүүрс хилээр гарна, ийм тогтолцоотой болно. Үүнийг бас нэг дор, нэг улиралд хийж болдоггүй юм байна. Хуулиа өргөн барьсан, хил дээр болж байгаа уурхайгаас хил хүртэл зөвөрлөж байгаа энэ тээвэр ложистикуудыг бид хилийн үнээр худалдаж эхэлсэн байгаа, хилийн үнээр тээврийн үнэ нь шингээд гэрээгээ бид татвар дээр Таван толгойгоос аваачиж өгөөд, тэнд шалгуулаад гардаг ийм систем рүү аажим аажмаар явж байгаа юм. Энэ ч зорилгоор мөн бусад ийм зорилготой ЗГ энэ хамгийн том экспортлогч нүүрсний энэ компани дээрээ онцгой дэглэм тогтоогоод ажиллаж эхлээд байна. Ойрын хугацаанд тодорхой мэдэгдэхүйц үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна.

Төсөв дээр орлого төлөвлөлт дээр бид нар их болгоомжтой байх ёстой, өмнө нь бол 12-16 онд ч гэдэг юм уу, ер нь төсөв төлөвлөхдөө эхлээд орлогоо тавьчихдаг байсан, зардлаа баримжаалж байгаад зарлагадаа зориулж орлого тавьдаг, эндээс болоод дараа дараагийн төсөв тэлэлт, буруу төлөвлөлт, төсвийн зөрүү алдагдал нэмэгдэх, үүсэх, дараа дараагийнхаа алдагдлыг цасан нуранги шиг бий болгох ийм процесс явдаг. Бид нар энэ буруу хандлага, энэ алдааг давтаж болохгүй ээ.

Тийм учраас орлогоо маш бодитойгоор төсөвлөх нь чухал юм байгаа юм. Их, бага хэмжээндээ чухал биш, бодитой байх ёстой орлого өөрөө. Энэ их чухал юм байгаа юм. Ингээд том зардлуудаа шингээх гээд юм уу, эсвэл алдагдалгүй болгох гээд

орлогоо хий хоосон бид нар төлөвлөж огт болохгүй, огт болохгүй. Тийм учраас сүүлийн 2 жил би яг өөрөө төсөвлөж оруулж ирж байгаа төсвөө хэлж байна шүү, өөрийнхөө мэдэж байгаа төсөв өө. Энэ дээр орж ирсэн орлого бол бид хамгийн бодитойгоор оруулж ирсэн юм байгаа юм. Сая таны хэлдэг үл хөдлөх хөрөнгийн татвар гэж байна, газрын татвар гэж байна, энэ маань улсын төсвийн орлого гэхээс бол энэ чинь шууд 100 хувь орон нутгийн орлого шүү дээ. Орон нутгийн орлого, түүнээсээ дахиад задраад цаашаагаа ингээд хуваарилагддаг ийм орлогууд юм байгаа юм.

Тэгэхээр орон нутгийн орлогыг ч гэсэн дээ, бид нар бодитойгоор төсөвлөж өгөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ИТХ-ийн өөрийнх нь ... /минут дуусав/

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн 1 минут.

Б.Баттөмөр: Жавхлан гишүүнтэй би олон асуудал дээр санал нийлдэг, сая санал нийлэхгүй ээ, өөртэй чинь. Төсвийн орлого бол бодитой болчихсон гэдэг бол, яагаад энэ Монголын ард түмний амьдралыг яаж дээшлүүлэх юм бэ, тэгвэл. Энэ их баялаг гараад байдаг, нөгөө баялгийн хараал гэдэг юм нь болчихсон байна шүү дээ энэ чинь, ийм байж болохгүй л дээ. Орлогоо нэмэгдүүлэх хэрэгтэй, үүнийг би энд сууж байх хугацаандаа бол байнга ярих болно. Далд эдийн засгийн талаар яах вэ дээ, одоо хожуу ч гэсэн ийм арга хэмжээ авч л байгаа юм байна, уг нь эрт авах ёстой юм л даа.

Эрдэнэтийн овоолго гээд бид нар тав дахь өдөр ярьсан шүү дээ,

үнэгүй юм нөгөө хавхан дээр байдаг гэдэг шүү дээ. Яагаад энэ компаниуд үнэгүй тэр овоолгыг авч ашиглаад байгаа юм. Яагаад тодорхой үнэлээд худалдаж болдоггүй юм, Жавхлан сайд аа. Яагаад тэр овоолгыг тэр чинь хөдөлмөр шингэчихсэн байгаа шүү дээ энэ чинь бас, өртөг шингэчихсэн байгаа. Яагаад тэр 2 компани 2, 3 компани яагаад тэгж үнэгүй аваад байгаа юм ... /минут дуусав/

Г.Занданишатар: Хариулах уу. Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Энэ оптек гэрээнүүд дээр бид ажиллаж байна. Онцгой дэглэм тогтоосон энэ жишээ нь тэнд хийгдсэн гэж байгаа энэ оптек гэрээнүүдийг эхнээс нь компанийн хэмжээнд ямар ч байсан судалгаа, эндээс гарах үр дүн, энэ дээр хийх шинжилгээ хийх ямар ч байсан боломжтой болж ирж байна. Энэ бол олон улсын гэрээнүүд байна, нийт гэрээний ер нь 30 хувь нь Бүгд найрамдах Хятад улсын, манай хамгийн том импортлогч улсын томоохон, улсын оролцоотой, төрийн өмчийн ийм компаниудын худалдан авалтууд байгаа. Оптек гэрээнүүд бол ерөнхийдөө тэр тойрог дотор байна, ер нь 70 хувь нь бол бусад жижиг зуу гаран ийм гэрээнүүд байна. Одоогоор өгч чадах ерөнхий мэдээлэл нь бол энэ байна, ингээд алхам алхмаар энэ бүх зүйлүүд бол олон нийтэд ил болох ёстой. Энэ дээр бол бид нар хатуу /минут дуусав/

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-25 оны төсвийн төсөөллийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийн урилгаар МУБИС-ийн харьяа ЕБС-ийн 12а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сур сур бас дахин сур гэдгийг санаж, улам их сурч, мэдэж, мэдлэгийн оргилд хүрэхийг хүсэн ерөөе.

11.49 цаг

Дараагийн асуудалд орно.

Гурав.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн 101 хууль, 6 Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 22 оны 10 дугаар сарын 13, 14-ний өдрийн нэгдсэн

хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хуулийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Монгол Улсын Их Хурлын даргын 2022 оны 151 дүгээр захирамжаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгээс хууль, тогтоолын төслүүдийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргасан бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус бүрээр нь санал хураалгаж шийдвэрлэсэн болно.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39-ийн 10 дахь хэсгийг үндэслэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцэн, төслийн тухайн зүйлтэй холбогдуулан гишүүн, бусад Байнгын хороо, ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллыг тус бүрээр санал хураалгасан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын

төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн нэгдүгээр зүйлийн Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 онд 25, 2025 онд 45, 2026 оноос 65 байна гэснийг Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 он 0, 2024 онд 65 байна гэж өөрчлөх саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

2. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр хүргүүлж, АМНАТ-ийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж тайлагнана гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

3. Гүйцэтгэх засаглалын хяналтын тухай хуулийн төслийн нэрийг “ЗГ дахь хяналтын тухай” гэж өөрчлөх, мөн төсөлд улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн бол төсвийн хяналтын сонсгол явуулна гэсэн

саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

4. “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь заалтын нэг дэх заалтыг улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр Төсвийн тухай хуульд тусгаж, батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн төсвийн хуульд тусган шийдвэрлэх гэж өөрчлөх, мөн төслийн 2 дахь заалтад төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, экспортын гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг экспортод гаргахгүй байх, борлуулалт болон худалдан авах нууц гэрээг Улсын Их Хуралд танилцуулах, ЭМД-ын санд үүссэн өр төлбөрийг 23 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авч авах гэж нэмэх саналуудыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг олонхын дэмжлэг авсан,

аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Өмнөх хуулийн төсөлд оролцсон гишүүд нэр, ажил, албан тушаал үндсэндээ адил байна. Үүн дээр бол Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Сангийн дэд сайд Санжаагийн Мөнгөнчимэг, Сангийн яамны Болдын Жавхлан сайд нараар ахлуулсан түрүүчийн ажлын хэсэг бүрэн бүрэлдэхүүнээр оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Тэмүүлэн дарга, Төсвийн байнгын хорооныхон. Одоо танай ажлын хэсэг хуралдах уу. Ажлын хэсэг хуралдахаар танайх чинь асуултад бол та хариулах учраас одоо шууд завсарлачих уу, тэгээд. Тэгсэн дээр биз дээ.

Одоо ингээд төсвийн ажлын хэсэг хуралдаж, төсвийн хэлэлцүүлгийнхээ эцсийн хэлэлцүүлэгт бэлтгээд Төсвийн байнгын хороо

хуралдаж байж, цаашаа үргэлжлэх болж байна.

Тэгэхээр чуулган түр
завсарлалаа.14 цаг хүртэл
завсарлалаа.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн хэсгийн гишүүдийг танилцуулсан байгаа.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт хариултыг үргэлжлүүлье. Ингээд эрхэм гишүүн Тогмидын Доржханд асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Би нэг 3 тов тодорхой асуулт асуусан юм.

Нэгдүгээрт, энэ ирээдүйн өв сангийн орлогын асуудал байна, Ирээдүйн өв сангийн эх үүсвэрийг бүрдүүлдэг 2 эх үүсвэр байдаг, нэг нь болохоороо төрийн өмчийн компаниудын ногдол ашгийг 100 хувь татдаг, тэгээд нөгөөдөх нь болохоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тодорхой хэсгийг нь татаж авдаг, ингээд сан бүрддэг. Тэгээд гол агуулга нь бол бид нар өнөөдөр уул уурхайн баялгийнхаа орлогыг татаж аваад, хадгалаад дараагийн үедээ өвлүүлнэ ээ гэсэн ийм концепцоор энэ хуулийг хийсэн юм. Энэ хуулийн техникийн ажлын хэсгийг би Сангийн яаманд байхдаа ахлаад явж байсан юм. Энд сууж байгаа маш олон гишүүдийг, бас Баялгийн сан сайн хөгжсөн, хэрэгжсэн улсуудаар бас танилцах аяллыг нь хийгээд очоод туршилагыг нь судлаад үнэхээр хэрэгтэй юм байна гээд л явж байсан. Гэтэл өнөөдөр юу болж байна гээд

тэгэхээр энэ системээ эвдээд эхэлчихлээ. Шулуухан хэлэхэд энэ жилийн төсөв дээр бол эвдчихсэн, ирээдүйн өв сангийн орлогыг ашиглана, ашиглахдаа бол хүүхдүүддээ ашиглана, хүүхдэдээ мөнгө олгоно оо гээд ингээд эвдчихсэн. Ирэх жилийн төсөв дээр яаж орж ирж байна гээд тэгэхээ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн эх үүсвэрийг нь төсөв дотроо оруулж ирээд тэндээсээ санхүүжүүлнэ ээ, өөрөөр хэлэх юм бол ирээдүйн өв сангийн зохицуулалтыг нь байхгүй болгоод эх үүсвэрийг нь шууд төсөв дээрээ татаж авч байна. Энэ чинь бол буруу. Тэгээд ийм тогтоолын төсөл орж ирж байгаад тайлбар өгөх хэрэгтэй байна. Үгүй ээ, тэгээд зөвхөн өнөөдөр л байгаа иргэд нь ашигт малтмалынхаа үр өгөөжийг хүртэж авчхаад 20 жилийн дараа, 50 жилийн дараа, 100 жилийн дараа төрөх Монгол хүмүүс үүнийг хүртэх эрхгүй ийм зохицуулалтыг та нар хийж байгаа юм уу? Дэлхийд 200 улсын нэг дөчөөд улс нь л байгалийн баялагтай байдаг. Амжилттай явж байгаа улсуудын сайн туршилага нь бол ирээдүй хойч үедээ мөнгөө хадгалдаг, тэр нь хөрөнгө оруулалт болж явдаг. Гэтэл бид нар ингээд л төсвийн энэ замбараагүй тэлэлтийг ингэж алга ташиж ингэж өөгшүүлээд л, тэгээд л эх үүсвэр байхгүй нэрийдлээр ингээд хуримтлал руугаа гар дүрээд байгаа нь зөв юм уу? Үүнийг би ингээд нэгдүгээрт тов тодорхой асууж байна. Хоёрдугаарт, ер нь тогтоолын төсөл дээр чинь ороод ирчихсэн байна.

Хоёрдугаарт, энэ Сангийн сайд байсан бол асуух байлаа, юу вэ тэгэхээр өнөөдөр бас энэ Даваасүрэн гишүүн бас асуугаад байх шиг байна. Хөгжлийн банкны хулгайн асуудал

байна, гэтэл УИХ-ын тогтоолоор дахиж ЗГ-аар баталгаа гаргаж, энэ мөнгийг татвар төлөгчдийн эх үүсвэрээр шийдэх гээд байна гэдэг ийм тодорхой мэдэгдлийг бол хийж байна. Тэгээд яах вэ, би ингээд тогтоолын төслийг нь харахад бол ойлгомжгүй байна. Даваасүрэн гишүүний хэлж байгаагаар хэрвээ ингээд мөнгөө төлж чадахгүй байгаа, мөнгөө өгөхгүй байгаа, зориулалт бусаар ашиглачихсан, зориудаар хулгай хийчихсэн ийм нөхдийн мөнгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ ээ гэх юм бол үүнийг бол ёстой 100, 200 хувь эсэргүүцнэ ээ. Харин талбай дээрээ гараад жагссан ч болно. Харин дахин санхүүжилтийн зорилгоор ЗГ-ын баталгаа гаргах байдлаар үүнийг шийднэ ээ гэх юм бол энэ нь өөр юм. Тэгэхээр энэ дээр тодорхой хариулт өгөх хэрэгтэй юм байна.

Гуравт нь бол, Монголын хамгийн том хулгайн пирамид одоо задарч байна. Энэ бол нүүрсний пирамид. Өмнө нь 49 Эрдэнэтийн зэс, түүн дээр овоорсон пирамид бол нурж унасан. Одоо дараагийн бүр том пирамид бол нүүрсний пирамид байна. Тэгээд энэ нүүрсний пирамидын үндсэн хулгай хийдэг арга хэрэгсэл нь болохоор орлогоо татвар байдлаар төвлөрүүлээд парламентаар ярихын оронд тэнд нэг дарга чиглэл аваад тэгээд төсвийн шинж чанартай зарцуулалт хийгээд байдаг. Түүнийгээ нууцад оруулдаг, ийм хулгай өнөөдөр ингээд ил болж байгаа нь сайн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол асууна. Хүрэлбаатар Эдийн засаг, хөгжлийн сайд, УИХ-ын гишүүн асуултад хариулна.

Ч.Хүрэлбаатар: Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа, тэгээд би энд орж ирж таны асуултад хариулъя. Нэгдүгээрт нь энэ Ирээдүйн өв сантай холбоотой зүйлийг зөвхөн энэ 23 онд л хэрэгжихээр 1 жилээр хойшлуулж байгаа юм. Төсвийн эдийн засгийн нөхцөл байдал бас амаргүй ийм үед хуримтлалын сан дээр мөнгө хуримтлуулаад явж байснаас илүүтэйгээр тулгамдаад байгаа эдийн засгийн өмнө тулгамдаад байгаа, нийгмийн өмнө тулгамдаад байгаа асуудлуудаа шийдвэрлэе гэж үзээд энэ ирээдүйн өв сантай холбоотой хууль тогтоолыг нэг, зөвхөн 23 онд үйлчлэхээр өөрчилж байгаа. Ирээдүй өв сангийн үлдэгдэл мөнгө 2,4 их наяд төгрөг бол байдгаараа байгаа. Үүнийг зарчихсан юм шиг, хэрэглэчихсэн юм шиг, тэгтэл таныг хэлээгүй шүү, өөр хүмүүс ярьж байна лээ, тэр бол улс төржиж байна гэж ойлгож болно оо.

Хөгжлийн банктэй холбоотой асуудлууд их явсан. Хөгжлийн банк бол 2020 оны 4 дүгээр сард Сангийн яаманд шилжиж ирсэн. Тухайн үед Сангийн яам, Төрийн банкнаас хамтарсан баг орж ажлыг эхлүүлж, энэ бүх булхайтай холбоотой зүйлүүдийг гаргаж тавьж явж ирсэн. Тэгээд одоо энэ 2023 онд бол Хөгжлийн банктэй 2 төлбөр төлөгдөх ёстой, 2 бондын. Нэгдүгээрт нь Самурай бонд, хоёрдугаарт нь нөгөө Евро бонд. Самурай бондыг бол 2023 оны 12 дугаар сард төлнө, үүнийг бол нөгөө Хөгжлийн банкны муу зээлүүдийг эргүүлж төлүүлэх замаар энэ мөнгөө бол хуримтлуулчихсан байгаа. Дээр нь иений хани нэлээд доошоо уначихсан байж байгаа шүү дээ. Тэгээд энэ үедээ ингээд мөнгөө цуглуулаад

авчхаж байгаа нь энэ бас зөв, арга тактикийн хувьд бол зөв өө гэж бодож байгаа.

Үлдэж байгаа нөгөө евро бондын асуудал байгаа юм. Евро бонд дээр ЗГ-аас оруулж ирсэн материал дотор Сангийн яам бол боловсруулж оруулж ирсэн. Гэхдээ нэг л эцсийн шийдвэр бол Их Хурал дээрээ гарна. 2 сонголт байгаа юм, ямар сонголт вэ гэхээр нэгдүгээрт нь, хэрвээ энэ Хөгжлийн банкны евро бондыг яах вэ гэдэг үүнийг депольт болгоод хаявал болох уу гэвэл болно. Гэхдээ үүний дараагаар олон улсын үнэт цаасны зах зээл дээр Монголын ямар нэгэн бонд эргэж тийм үр өгөөжтэй, хямдхан хүүтэйгээр босно гэдэг магадлал бол алга болчихож байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өөрөө манай зах зээл дээр аягүй сөрөг мэдээнүүд ирнэ. Хөгжлийн банк нь Төрийн банк энэ депольдсон, авсан, бондоо төлөөгүй, авсан зээлээ эргүүлж төлөөгүй, ийм учраас Монголын ямар нэгэн бондыг битгий ав гэж хэлнэ. Яагаад гэвэл энэ бондыг чинь дандаа хөрөнгө оруулагч нар худалдаад авчихсан байж байгаа. Ингээд бондын зах зээл дээр маш сөрөг үр дүн явчих ийм юутай. Гэхдээ энэ бонд бол 23 оны дахиад хэлье, 23 оны 10 дугаар сар, 23 оны 10 дугаар сар. Тэгэхээр ЗГ-аас оруулж ирсэн тогтоол дотроо бол шаардлагатай бол гэж байгаа юм, шаардлагатай бол. Өөрөөр хэлбэл энэ арга хэмжээг авахгүй ч байж болно гэсэн үг. Тийм учраас ЗГ мэдээж наана нь бүхий л арга чадлаараа ажиллаж байгаа, ер нь. Болохгүй, бүтэхгүй зүйлийг засах оролдлогуудыг ээлж дараатайгаар авч байна, зөв болгох гээд оролдож байна. Тэгэхээр шаардлагатай бол гэдэг үгийг нь бол харамсалтай нь хүмүүс ярихгүй байгаад байгаа,

тэгэхээр үүнийг бол шаардлагатай бол гэдэг ийм бас боломжийг нь нээгээд үлдээчихвэл ЗГ-т ажиллах бас боломжтой, ийм болчихож байгаа юм. тэгээд мэдээж энэ аргыг хэрэглэх үедээ Их Хурлаас бол ярилцаж л таарна шүү дээ гэсэн ийм л хариулт өгмөөр байна.

Нүүрсний бол асуулт сонсоогүй, тодруулгын дараа хариулъя.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна.

Т.Доржханд: Тэгэхээр нүүрсний орлогоо бид нар авч чадаагүй, 10 жил болсон нь үнэн. Авах үндэслэл нь бол татвараараа авах ёстой. Гэтэл татвараар авах боломжийг нь өгөхгүйгээр тэнд зарлага санхүүжилт гаргаад байна шүү дээ. Янз янзын төмөр зам энэ тэр гээд нууцын гэрээ байгуулж байгаад бүгдийг нь ингээд нэг захирал гарын үсэг зураад тэгээд сайхан хулгай болоод байна шүү дээ. Ерөнхий сайд чинь ч үүнийгээ зарлаад байна шүү дээ. Үгүй ээ тэгээд энэ чинь яаж авах ёстой юм бэ гээд тэгэхээр татвараа тавиад, татвараараа өнөөдөр бид нар аваад, иргэддээ нээлттэйгээр улсын төсвөө эндээ хэлэлцээд юунд зарцуулах юм бэ? Төмөр замаар зарцуулах юм бол эх үүсвэрийг нь эндээ баталж өгөөд нээлттэй тендер шалгаруулалт яваад ингээд хууль номынхоо дагуу явах ёстой. Энэ процесс чинь алдагдчихаад байгаа биз дээ. Гэтэл та нарын энэ УИХ-ын тогтоолын 7 дээр чинь дахиад нэг ийм юм ороод ирчихсэн байх юм. Төрийн өмчийн компаниудын 50 хувь, аль эсвэл нэг хувь ч гэнэ үү, аль нь их байх юм бол тэрийг нь

төвлөрүүлье, бусад нь бол хэрэггүй ээ гэсэн ийм агуулга ... /минут дуусав/

Г.Занданишатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Оптек дээр бол ЗГ-ын байр суурь аягүй тодорхой байгаа, үүнтэй холбоотойгоор ЗГ тогтоол гаргасан. Эрдэнэс Таван толгой дээр онцгой дэглэм тогтоогоод тэнд ажиллаж байгаа. Ер нь энэ буруу зүйлүүдийг ер нь засах ийм оролдлогууд ажлуудыг бол хийгээд явж байгаа шүү дээ. Оптек гэрээнүүдийг хийгдэхээр ямар аюул байна вэ гэдгийг л би зүгээр товчхондоо нэг үгээр хэлчихмээр байгаа юм. Тооцоо хийе, макро эдийн засгийн ямар нэгэн тооцоо судалгаа хийх боломжгүй болсон. Оптек ямар, хэчнээн хэмжээтэй нүүрс гадагшаа гарахыг нь мэдэгдэхгүй. Энэ гэрээтэй холбоотойгоор хэчнээн импорт орж ирэхийг мэдэхгүй, ямар тоног төхөөрөмж орж ирэхийг мэдэхгүй, нууц. Импорт яаж нэмэгдэх юм мэдэхгүй, тооцоолох боломж байгаа юу, байхгүй. Тэгэхээр энэ оптекийн нууц байхын аюул бол энд байгаад байгаа байхгүй юу. Эдийн засаг, макро эдийн засгийн бодлогыг авч хэрэгжүүлэхэд төвөгтэй. Ийм учраас бид нар энэ оптекийг .../минут дуусав/

Г.Занданишатар: Хүрэлбаатар сайд гүйцээж хариулъя.

Ч.Хүрэлбаатар: Эдийн засгийн сайд гээд энэ орж ирж байгаа валютынхаа урсгалыг, гарч байгаа валютынхаа урсгалыг тооцож үзэх гээд л ингэнгүүт хад мөргөж эхэлж байгаа юм. Ер нь 23 онд валютын урсгал ямар байх юм, орж ирэх нь хэд юм, гарах нь хэд юм гэдэг энэ тооцоог

хийгээд эхлэх гэхээр бүх юмнууд оптек дээр очоод гацаж эхэлж байгаа. Тэр нь тийм бага дүнтэй биш, их дүнтэй учраас макро эдийн засгийн тооцоо судалгаа хийхэд түвэгтэй болж байгаа учраас бид нар энэ нүүрстэй холбоотой ил тод болгох, орлогыг гүйцэд авах чиглэлийн ийм оролдлогуудыг ЗГ-ын тэмдэглэлээрээ нэг удаа, ЗГ-ын тогтоолоороо нэг удаа, дахиад үргэлжлүүлээд онцгой дэглэм тогтоох замаар үүнийг шийдэж байгаа юм. Би бол үр дүн гарна гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байгаа.

Хэсэг хүмүүс, харин бойкотолж тэнд саад болох гэж оролдож байгаа нь үнэн, тэгээд булхай буруу зүйл удахгүй илрээд, эзэн, эзэн байр байран дээрээ оччих болов уу гэсэн ийм бодолтой байгаа гэдгийг бол би онцолж хэлмээр байна. Цаашидаа энэ Эрдэнэс Таван толгойн ухсан нүүрснээс хилээр гарч байгаа нүүрс хүртэл бүгд цахимжиж бүртгэгдэх ёстой. Энэ хооронд цахим биш хэн нь ямар нүүрс хаана явж байгаа нь ойлгомжгүй учраас хулгай гэдэг зүйл хулгай хийх боломжийг олгож өгч байгаа юм. Өлөн нүдтэй, шуналтай хүмүүс төр рүү гараа хуруугаа хумсаа хийх ийм боломжийг нь бүрдүүлж өгч байгаа. Тийм учраас энэ л бүх боломжуудыг нь хаах ийм зорилготой.

Хоёрдугаарт, нүүрс зарах асуудал. Энэ өөрөө дэлхийн тэр Австрали ч бай, Канад ч бай, Индонез ч бай бүгдийг нь аваад үзэхээр энэ уул уурхайн бүтээгдэхүүний биржээр буюу комод тексжэнт дээр арилжаалагддаг, тэгж байж худалдан авч байгаа хүмүүс нь өрсөлддөг, тэгж байж энэ Монголын баялаг үнэд хүрнэ ээ гэж үзэж, энэ

бүх бэлтгэл ажлыг хангаад 23 оны 01 сарын 01-нээс энэ бирж дээр энэ бараа бүтээгдэхүүнүүдээ зар аа гэдэг ийм чиглэлийн ажлууд бол ЗГ-ын зүгээс бол хийгдэж байгаа. Энэ ажлын үр дүнд бид нарын хувьд бол энэ валютынхаа урсгалыг нэмэгдүүлэх, валютын нөөцийг нэмэгдүүлэх, энэ нь эргээд бас ханидаа эерэг нөлөө үзүүлэх ийм алхмуудыг ЗГ бол бие дараатай аваад явж байгаа гэдгийг бол хэлье.

Тэр төрийн өмчит ААН-үүдийн ашигийн талаар бол энэ урьд нь Сангийн яамны орлогын хэлтсийн дарга, тэнд орлогын газрын дарга сууж байна, тэнд хариулах байх, ажлын хэсэг.

Г.Занданшатар: 95, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Орлогын хэлтсийн дарга.

Б.Тэлмүүн: Асуултад хариулъя. Төрийн болон төрийн өмчит компанийн ноогдол ашигтай холбоотойгоор бол ТӨК-ийн шинэчлэлийн багц реформын хүрээн дэх нэг чухал зорилт нь бол ногдол ашигтай холбоотой асуудал байгаа. Энэ асуудлыг бид 2022 оны төсөв өргөн барихдаа 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой УИХ-ын тогтоолд бол анх оруулж ирсэн. Энэ 2021 оны УИХ-ын 88 дугаар тогтоолд бол яг энэ агуулгаар ороод энэ жилээс хэрэгжиж байгаа заалт. Ямар агуулгатай, учиртай заалт вэ гэхээр бид нар олон жил ТӨК-ууд зөвхөн ашигтай ажилласан тохиолдолд компани нь ашигтай ажиллаад, ногдол ашиг хуваарилаад цаашаагаа санхүүгийн хувьд явах боломжтой тохиолдолд ногдол ашиг хуваарилна гэдэг энэ зарчмаар олон жил явж

ирсэн. Үүнээс үзэхэд бол бид өнгөрсөн хугацаанд ТӨК-уудаас маш олон компани ашиггүй, маш бага ашигтайгаар ажиллаад ногдол ашиг олон жил хуваарилаагүй явж ... /минут дуусав/

Г.Занданшатар: 95 Тэлмүүн гүйцээж хариулъя, товч тодорхой харуулъя.

Б.Тэлмүүн: Тэгэхээр бид нар олон улсад байдаг ногдол ашигийн бодлогын жишигийн дагуу зөвхөн ашигтай ажилласан тохиолдолд ногдол ашиг хуваарилдаг биш, төр оруулсан хөрөнгийнхөө тодорхой хувиар жил болгон хөрөнгө оруулалтын өгөөж хэлбэрээр ноогдол ашгаа авдаг ийм хэлбэр лүү шилжье ээ гэсэн агуулгаараа энэ ашигтай ажилласан хэсгээс үл хамаараад төрийн оруулсан хөрөнгийн нэг хувийн өгөөжийг жил болгон улсын төсөвтөө ноогдол ашиг хэлбэрээр авдаг байх энэ бодлогыг оруулаад энэ 2 дахь жилдээ өргөн баримттай явж байгаа.

Уул уурхайн буюу стратегийн ордод үйл ажиллагаа явуулдаг томоохон төрийн өмчит компаниудын хувьд бол бид их хэмжээний өндөр ашигтай рентийн орлоготой байдаг тул жил болгон санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашигийн 50 хувийг нь бид нар бас энэ ирээдүйн өв сан дээр ногдол ашиг хэлбэрээр төвлөрүүлж байх энэ зарчмыг бол УИХ-ын тогтоолоор үүрэг болгож оруулж байгаа. ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлээд байгаа төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хууль дээр энэ асуудлыг илүү дэлгэрэнгүй нарийвчилж зохицуулж өргөн барьсан байгаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл.

О.Цогтгэрэл: Ирээдүйн өв сангийн тухай хуулийг хэлэлцэж байна. 23 онд орж ирэх ёстой 1,5 их наядыг өв санд хадгалахгүйгээр хэрэглэхье ээ, цаашид тэгээд 65 хүртлээ дахиад хэдэн жил багаар төлж явах юм байна гэдэг л хуулийн төсөл. Тэгээд энэ хууль чинь өөрчлөгдөөд 16 оноос яг энэ хуулийн утга агуулгад ороод явж байгаа. Ер нь бол байгалийн баялгийг үе хооронд бас эн тэнцүү хэрэглэе ээ, хамгийн гол утга агуулга нь бүр эд нараасаа ч илүү түүхий эдэд суурилсан эдийн засагтай орон, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс тэр их хэмжээний үнийн хэлбэлзэл байдгаас сэргийлэх зорилготой л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр яг 16 оноос хэрэгжиж байгаа хууль Ирээдүйн өв сан дансанд яг хэдэн төгрөг байгаа вэ? Миний санаж байгаагаар энэ жилийн 1,5-ыг авах юм байна, 22 онд бас тодорхой хэмжээний дүнг бас 1 их наяд ч билүү Ирээдүйн өв санд орох мөнгөнөөс авсан санагдаж байна. Тэгэхээр энэ бас яг л нэг тодорхой хэмжээгээр, хуулийн хүрээнд мөртөө яг яригдаад байгаа тэр нүүрс дээр яригдаад байгаа оптик гэрээний л нэг хэлбэр шүү дээ. Урьдчилж ирээдүйд хуримтлагдсан мөнгөө урьдчилж авч хэрэглэе ээ л гэж байгаа юм, хэрэглэе л гэж байгаа. Утга санаанаасаа өөр, тэр тусмаа яг бол төсвийн тэлэлттэй ийм үед төсөв 2 их наядар тэлчихсэн, дахиад цаана нь нуугдмал болоод ил далд алдагдалтай үед тэрийг санхүүжүүлэх ийм л утга санаа цаана нь харагдаад байна. Тэгэхээр яг одоо Ирээдүйн өв санд 16 оны хууль хэрэгжсэнээс нааш, ер нь хэчнээн мөнгө хуримтлагдсан байх

ёстой байсан юм бол, одоо яг хэд байгаа юм бол оо? Энэ талаар эхлээд мэдээлэл өгөөч ээ.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, УИХ-ын гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ирээдүйн өв санд бол 2021 оны эцсийн байдлаар 2,5 их наяд төгрөг хуримтлагдчихсан байгаа, 22 онд бол харин мөнгө хуримтлагдаагүй, хуримтлагдахгүй ийм байгаа. 2,5 их наяд төгрөг.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Үгүй ээ, гол нь байгаа нь хэдээсээ гадна яг 16 оноос нааш хуулийн хүрээнд хуримтлагдаад явсан бол хэд байх ёстой байсан бэ гэдэг л чухал байгаад байна л даа. 22 онд бас хэрэглэхсэн шүү дээ. Тэгэхээр энэ 16 оноос нааш хэрвээ хуримтлагдсан бол нийтдээ хэд байх ёстойгоос одоо 2,4 тав орчим байгаад байгаа юм бол.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: Ирээдүйн өв сангийн тухай хууль бол 2016 оноос хэрэгжиж эхэлсэн. 2017 оны 10 дугаар сард Сангийн сайд болж томилогдож байсан, тэгээд очоод тооцоо хийгээд үзэхэд бол Ирээдүйн өв сан буюу тэр 12-16 оны хооронд бол тэд хүүхдийн мөнгийг тавихдаа нөгөө хүний хөгжил сан дээр 1,2 их наяд төгрөгийн өр төлбөр үүсчихсэн байсан. Ингээд 17-20 оны хооронд урьд өмнө нь хуримтлагдчихсан байсан тэр Хүний хөгжил сангийн 1,2

их наяд төгрөгийн өрийг төлж дуусгаад тэгээд 2,4 их наяд төгрөгийг яг тэр 2,4 их наяд төгрөгийг хуримтлуулаад өгсөн. Тэр мөнгө яг хэвээрээ байгаа. Одоо ингээд 2,5 их наяд төгрөгийн ирээд ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Дагаж мөрдөх хуулиуд орж ирж байна. Хэд гуравхан зүйл тодруулж асууя. Энэ 3 дотор Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл дээр төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно оо гэсэн заалт дэмжигдээгүй саналаар орж ирсэн. Энэ ер нь яг юу болчхов оо, төсвийг дагаад энэ дагаж оруулж ирж байгаа хуулиуд дотор энэ Төрийн албаны тухай хууль ингээд ороод ирсэн. Үүнтэй зэрэгцээд Чинзориг нарын гишүүд хууль өргөн бариад ингээд цуг явж байгаа. Байнгын хороогоор ороод ингээд дэмжигдээд ингээд явж байгаа. Тэгээд энэ дээр энэ бас төсөв дээр яг энэ төрийн захиргааны албан хаагчдын 20 хувийн нэмэгдэл орж ирж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Дагаад бас орон нутгийн нэмэгдлийн тухай хууль тэр Чинзориг нарын гишүүдийн хуулиар орж ирж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ ТҮ-ийн ажилчдын асуудал ер нь юу болсон бэ? Төрийн үйлчилгээний албан хаагчдын яг, ялангуяа тэр орон нутагт ТЗ-г дагаад орон нутгийн захиргаанд ажиллаж байгаа тэр үйлчлэгч, галч, сантехникч гээд энэ улсуудын юм ер нь энэ дагаж мөрдөх хууль дотор яаж орж ирж байгаа вэ гэсэн зүйлийг тодруулъя.

Дараагаар нь энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд бас өөрчлөлт орж ирж байгаа. Энэ нөгөө дагаж хуулиудын дотор нэр нь байна лээ, тэгэхээр энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 550000-аар тогтоосон байгаа. Энэ доод хэмжээ дахин өөрчлөгдөх тухай асуудал энэ дотор яригдаж байгаа юу? Аль эс үгүй бол бүр дараа нь тусдаа орж ирэх үү?

Дараагаар нь нэг асуулт, энэ юун дотор “Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулж авах зарим арга хэмжээний тухай” Их Хурлын тогтоолын төсөл гарна. Энэ дотор тэр эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой нэг асуудал байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр өнгөрсөн 2022 оны төсвийн өнгөрсөн ч яах вэ, энэ жилийн төсвийн жил эхлэнгүүт энэ ЭМД-ын сангаас 250 гаруй одоо бол нэг 267 орчим тэрбум төгрөг болж байх шиг байна, энэ мөнгө ингээд шууд 21 оны ЭМД-ын санд төлөгдөх ёстой мөнгө 22 оны төсвөөс авагдчихсан. Тэгээд одоогоороо ингээд энэ Улаанбаатар хотод, ялангуяа бас хөдөө орон нутаг, сумдад дээр энэ эрүүл мэндийн сангийн мөнгө олголт тасалдаад ингээд явж байгаа. Тэгээд бүр сүүлдээ аргаа бараад энэ ЭМДЕГ дээр бараг л нэг хасалт хийдэг байгууллага юм шиг болгож ингэж асуудал яваад байна л даа. Тэгэхээр энэ дотор энэ ЭМД-ын санд үүссэн өр төлбөрийг 2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах гээд ингээд заалт болоод орж ирсэн. Энэ яг энэ ондоо буюу яг ингээд маш яаралтай байдлаар шийдэгдэх үү гэсэн ийм 3 асуулт асууя.

Г.Занданшатар: Эхний асуултыг Цэндийн Сандаг-Очир гишүүн, ажлын хэсгийн гишүүн, Төсвийн байнгын хорооны гишүүн.

Ц.Сандаг-Очир: Туваан гишүүний эхний асуулт төрийн албаны хуультай холбоотой асуудлыг асууж байна. Энэ төрийн албаны хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулаад нэр бүхий гишүүд бас төрийн захиргааны сумдын, тэр дундаа аймгийн төвөөс алагдсан сумдын төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор 5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал өгч болно оо гэдэг хуулийн төслийг өргөн барьсан. Тэгээд ингээд төсвийн хуулийг дагаад энэ хуулийг хэлэлцсэн. Өчигдөр Төсвийн байнгын хороон дээр энэ асуудлыг яриад эх үүсвэр байхгүй, ерөнхийдөө энэ хуульд төрийн захиргааны сумдад нэг, 2400 гаруй төрийн захиргааны албан хаагчид хамааралтай ажиллаж байна, өнөөдөр. Яг энэ хууль хэрвээ хэрэгжиж эхэлбэл 5 жилээс дээш хугацаанд ажиллаж байгаа 1400 орчим мянга гаруй албан хаагчид энд нэмэгдэлд хамрагдах юм байна, төсөвт өртөг нь нэг, ойролцоогоор 5 орчим тэрбум төгрөг болох юм байна. Энэ эх үүсвэрийг 2023 оны төсөвт тусгая гэдэг энэ асуудлаар ярьж байгаад эх үүсвэр байхгүй гэдэг үүднээс 23 оны хугацааг нь 24 он руу болох энэ асуудлыг ярьж байгаа. Үүнтэй зэрэгцээд бас нэр бүхий гишүүдээс төрийн захиргааны албан хаагчдаас гадна төрийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс бас адилхан нэмэгдүүлэх шаардлагатай байна гэдэг асуудлыг ярьж байгаа. Хэрвээ төрийн

захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчид буюу жижүүр, манаач үйлчлэх слесарь, жолоочоос авхуулаад энэ нийтдээ 34000 төрийн албан хаагчдын асуудал буюу үүнд шаардлагатай дунджаар нэг 60 гаруй 70 орчим тэрбум төгрөгийн асуудал хөндөгдөхөөр байгаа юм. Эх үүсвэр хэрэгтэй болж байгаа юм. Тийм учраас энэ жилийн ирэх жилийн төсөв дээр энэ хэмжээний орлого юмнууд дутагдалтай байгаа учраас энэ асуудлыг ер нь бол 24 он руу хэрэгжих хугацааг нь хойш нь тавиад, төсвийн эх үүсвэр байхгүй учраас хуулиа бол цаашид хэлэлцээд явъя гэдэг ийм байдлаар Төсвийн байнгын хороон дээр ярьсан шүү гэдгийг Туваан гишүүнд мэдээлэл өгье.

Г.Занданшатар: Чимэдийн Хүрэлбаатар сайд хариулна.

Ч.Хүрэлбаатар: ЭМД-ын сангийн өртэй холбоотой асуултад хариулт өгье. Ер нь бид нар бас эргээд санах юм бол арваад сарын өмнө бид нар бүгдээрээ л масктайгаа байсан, энэ өвчин хэвэндээ л байсан. Тэгээд үүнтэй холбоотойгоор бас эрүүл мэндийн салбар дээр ковидтой холбоотой зардлууд гараад сая Туваан гишүүний хэлдэг 243 тэрбум төгрөгийн өр үүссэн байсан. Ингээд 2 хоногийн өмнө болсон, биш өчигдөр болсон, өчигдөр боссон ЗГ-ын хуралдаанаар Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд 2 орж ирээд энэ 243 тэрбум төгрөгийн өрийг энэ ондоо шийдэх тэр зохицуулалтыг оруулж ирж ЗГ-т танилцуулж шийдүүлсэн байгаа гэдгийг би хэлмээр байна.

Тэгэхээр 23 он руу өр давж орохгүй, 23 онд эрүүл мэндийн салбарынхан бол энэ асуудал өр

авлага үүсгэхгүйгээр ажиллачих боломжтой болов уу гэж бодож байгаа. Ковид арай гайгүй байх байх, тэр хөл хорио тогтоож, бас амаргүй л юмны ард гарцаасан шүү дээ. Тэгэхээр тэр зүйл эрүүл мэндийн салбарын өмнө зүгээр, 23 онд бий болохгүй учраас ерөнхийдөө гайгүй өр авлагагүй явчих болов уу гэж бодож байна.

Г.Занданшатар: 95
Мижиддоржийн Санжаадорж
Сангийн яамны Төсвийн бодлого
төлөвлөлтийн газрын дарга.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу 3 талтаар бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоодог. Энэ дагуу бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 сарын 01-нээс 550000 төгрөг болгохоор тогтоохоор шийдвэр бол гарсан байгаа. Одоо бол 420000 төгрөг байгаа. Тэгэхээр 130000 төгрөг бол нэмэгдэж байгаа гэсэн үг. Үүнтэй холбоотойгоор бол төсвийн төсөл дээр бол хэд хэдэн зардлууд дээр өөрчлөлт ордог. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож олгодог ЭМД-ын шимтгэл, жишээ нь 0-18 насны хүүхдийн ЭМД-ын шимтгэлийг төр хариуцан даадаг. Мөн төрийн одоогоор төрийн захиргааны албан хаагчийн цалингийн сүлжээний ТЗ-ийн нэг ангилал бол өөрөө хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байгаа. Өөрөөр хэлбэл 460000 төгрөг байгаа. Тэгэхээр энэ хэмжээг бол бид нар нэмэх шаардлагатай болж байгаа.

Мөн ТҮ ангиллын ТҮ-ийн нэг ангилал болоод хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 550000 төгрөг болох дүнгээс 23000 төгрөгөөр л доор байгаа. Үүнийг бол нэмэх шаардлага гарч ирж байгаа. Мөн нийгмийн даатгалын санд бол бид нар хүүхдээ харж байгаа 0-3 нас хүртэл хүүхдээ харж байгаа эхчүүдийн шимтгэлийг 50 хувийг мөн цаатан иргэдийн шимтгэлийг бол төлдөг. Үүнтэй холбоотойгоор холбогдох зохицуулалтууд орж ирж байгаа. Түрүүний хэлсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож олгодог шимтгэлүүд дээр нийтдээ 51 тэрбум төгрөг төсвийн төсөл дээр бол нэмэгдэж орж ирж байгаа. Энэ мөнгө бол ЭМД-ын сан, нийгмийн даатгалын сан дээр орлого болж орно. Цалин хөлстэй холбоотойгоор бол өөрчлөлтүүд нь цалингийн тогтолцооны өөрчлөлтийг ЗГ-аас танилцуулж байгаа энэ багц арга хэмжээндээ бол шингээд тэгээд орж ирж байгаа.

Г.Занданшатар:
Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн
асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын 23 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хууль, тэр дотор мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг чиг үүргийнх нь дагуу яамдад нь өгье гэдэг энэ бодлогыг бол дэмжиж байгаа. Энэ хуулийн төсөл дотор нэг зүйл бид бас анзаарахгүй орхигдуулж болохгүй нэг зүйл байна. Үүнийг зайлшгүй хэлье. Энэ бол МХЕГ байдаг нийслэлийн болон МХГ-ын бүрэлдэхүүнд ажиллаж байдаг нөгөө Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газар, хэлтэс

байгаа. Тэгэхээр энэ цацрагийн аюулгүй байдалтай холбоотой энэ хяналтыг шалгалт хийх, зөрчлийг арилгуулах, хариуцлага хүлээлгэх, цацрагийн үүсгэвэр шалгах, хадгалах, тээвэрлэх, импортлох зөвшөөрөл хүртэл олгох ийм чиг үүрэг бүхий ийм 2 субъект маань БШУЯ руу оччих ийм хуулийн төсөл орж ирээд байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг бас дахин харж үзэж, тэгээд үүнийгээ цөмийн энергийн комиссын баталсан аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны дүрэм, стандарт хэрэгжилтийн үр дүнтэй хангуулах зорилгоор юу яачихмаар байгаа юм. Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнд оруулчихмаар байгаа юм. Тэгээд энэ дээр байр сууриа бас ЗГ-аас тайлбарлаж хэлнэ үү.

Г.Занданшатар: 92
Баасандорж.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулъя, Баасандорж. Цөмийн болон цацрагийн хяналттай холбоотой асуудлыг хөндөж байна. Ер нь Цөмийн энергийн газар бол өөрөө хуучин агентлаг байсан, 2008 онд байгуулагдаад 2015 онд Цөмийн энергийн агентлаг татан буугдаад, МХЕГ энэ чиг үүрэг шилжиж ирсэн. 2015 оноос хойш өнөөдөр цөмийн энергийн хяналтыг хийж байгаа. МХЕГ-ын дарга өөрөө Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүнд орж явдаг комиссын бүрэлдэхүүнд. Цөмийн энергийн комисст ажлын алба ажилладаг. Гишүүний санал бол энэ мэргэжлийн хяналтын цөм болон цацрагийн чиг үүргийн хяналтыг энэ ажлын албанд нь өгье гэж байх шиг байна тийм ээ, гишүүн ээ. Тэгэхээр энэ бол нөгөө ЗГ-аас өргөн барьсан хуулийн төслийн үзэл баримтлалтай зөрчилдөнө л дөө. Яагаад гэхээр

Монгол Улсын ЗГ-ын тухай хуулийн Хорьдугаар зүйлийн тав дахь хэсэг дээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудалд энэ цөм болон цацрагийн асуудал байдаг. Цөмийн болон энергийн комиссын дарга нь өөрөө Боловсрол, шинжлэх ухааны сайд байдаг. Тэгэхээр яг энэ ЗГ-аас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлал маань өөрөө 13 яаманд чиг үүргээрээ салбарын ерөнхий байцаагч хяналттайгаа шилжиж очиж байгаа юм. Тэгэхээр энэ БШУЯ-ндаа байсан нь өөрөө давхар нөгөө комиссын дарга, боловсролын сайд, тэгээд салбарын ерөнхий байцаагч нь бүрэлдэхүүндээ ороод явах нь зүйтэй гэж Монгол Улсын ЗГ-аас үзсэн юм, гишүүн ээ. Тэр комиссын ажлын алба бол зөвхөн тэр комиссын бүрэлдэхүүний өдөр тутмын үйл ажиллагааг нь хангах, хуралдааны бэлтгэлийг хангах л чиг үүрэгтэй, ийм ажлын алба байгаа. Тэгэхээр энэ болохгүй л гэж үзээд байгаа юм, ЗГ-аас.

Г.Занданшатар:
Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн нэмэлт 1 минут.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр энэ их нарийн ийм шалгалт хийдэг юм л даа, цацрагийн доз нь хэр байна, нөгөө ирж байгаа юмнууд нь аюулгүй ажиллагаа нь хэр байна гээд маш олон тийм нарийн багажууд ашиглаад хийдэг учраас ийм олон газар тарж байрлахаар, энэ логикийн хувьд бол их олон төрлийн нарийн багажуудыг хадгалах, авах, түүнийгээ ажиллуулах гээд. Тэгэхээр уг нь бол энэ цөмийн энергийн комиссынхоо бүрэлдэхүүнд ороод явчихвал, шинжлэх ухааны асуудал хариуцсан ЗГ-ын гишүүн бол Цөмийн нэрийн комиссын дарга гэж байгаа, тэр ойлгомжтой. Тэр даргаа

хийгээд явж болно. Тэгэхээр бид 2009-2015 онд энэ агентлаг байгаад тэр дотроо энэ хяналтаа хийгээд болоод байсан. Тэгэхээр одоо бол харин үндсэн үзэл санаа өөрчлөгдөнө гэдэг утгаараа биш, үйл ажиллагаа нь нэг дор зангигдан, нэг ийм нарийн үйл ажиллагааг явуулдаг ийм цөм байх нь зүйтэй гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр би бас ийм зарчмын зөрүүтэй санал бас оруулъя гэсэн ийм бодолтой байна.

Г.Занданшатар: Санал хэлчихлээ. Хариулах уу? Барсүрэнгийн Баасандорж хариулах уу. 92 МХГ-ын дарга Барсүрэнгийн Баасандорж.

Б.Баасандорж: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Сая бол нөгөө санал хэллээ гэж ойлголоо. Гэхдээ Цөмийн энергийн тухай хууль дээр яг Чинбүрэн гишүүнтэй бол санал нэг байна. Энэ бол маш олон салбарт хөндөгддөг, өөрөө салбар дундын хяналт байх ёстой, эрүүл мэндийн салбарт ч байна, боловсролын салбарт ч байна, уул уурхайн салбарт ч байна, дэд бүтцэд ч байна, цацраг нь. Цөм нь мөн адил маш олон салбаруудад байдаг ийм салбар дундынх. Тэр үүднээсээ цөмийн энергийн энэ цөм болон цацрагийн асуудал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудалд ЗГ-ын тухай хуулийн 20 дугаар зүйлийн таваар өгөөд энэ комиссыг ахалж байгаа нь өөрөө маш олон байгууллагын төлөөллүүдэд комисс байдаг, Та гишүүн мэдэж байгаа тийм ээ. Энэ яг комисс дээрээ энэ салбар салбарынхаа асуудлууд дээр, тэнд бодлогын уялдаа холбоог нь хангаад явдаг комисс бол өөрөө. Тэгэхээр энэ ажлын алба руу шилжүүлснээрээ энэ хяналтыг шилжүүлбэл тэр төрийн захиргааны төв байгууллага дээрээ байх нь

зүйтэй. Хэрвээ ажлын алба руу шилжүүлэх юм бол тэр ажлын албаны чиг үүрэг маань өөрөө тэр комиссын хэвийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэл хангах энэ чиг үүрэгтэй л бай... /минут дуусав/

Г.Занданшатар:

Баттөмөрийн Энхбаяр гишүүн больчихсон уу. Буланы Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ төсөвтэй холбоотой асуудал ярьж байгаа болохоор нэг асуулт асууя гэж бодож байна. Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэрлэлт болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг хянан шалгах түр хороо 10 сарын 08-наас 12-нд Ховд аймаг, Баян-Өлгий аймгийн хилийн боомт дээр ажилласан. Энэ Ховд аймгийн Хөшөөтийн уурхайгаас БНХАУ руу 1,8 тонн нүүрс гарлаа гэсэн мэдээллийг Засаг дарга хилийн боомтод өгсөн. Гэтэл БНХАУ-ын Шиньжан уйгурын ӨЗО-ны Алтай аймгийн телевизийн мэдээгээр Монгол Улсаас 2 сая 100000 тонн нүүрс импортлож авсан мэдээ гарсан. Энэхүү мэдээлэл 2 эх үүсвэр нь 2 ондоо мэдээлэл өгч байгаа. БНХАУ-ын хэвлэл мэдээлэл цензуртэй учраас хатуу цензуртэй учраас буруу мэдээлэл өгдөггүй. Эндээс үзэхэд Ховд аймгийн Булган Ярантын бомтоор ямар ч хяналт бүртгэлгүй 400000 тонн нүүрс гарсан харагдаад байгаа юм л даа. Энэ 1 тонн нүүрс 150 доллар гэхэд манай улсад ороход 60 сая доллар алга болсон байгаа юм. Мөн төсвийн орлого, татвар нэрээр орох ёстой байсан хөрөнгө алга болсон байна. Тийм учраас энэ Монгол Улсын ЗГ, Сангийн яам, Эдийн засгийн яам энэ дээр нэг анхаарал тавиад шалгаад нэг зөв мэдээлэл өгөх нь зөв

байх гэж бодож байна. Нөгөө талаар Хятад тал арай нь ийм, буруу мэдээлэл өгөхгүй л байх гэж бодож байна, бүр телевизороор цацаад сая ярьчихсан шүү дээ, энэ талаар асууя.

2 дахь нь энэ МХГ-ын даргаас асуух асуудал байна. Энэ эм, эмнэлгийн хэрэгслийг хянан шалгах төв лаборатори байна л даа, энэ Монгол Улсын аюулгүй байдал нь бол сайн ажиллах ёстой, бүх гадаадаас импортлоор орж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг шалгах ёстой. Гэтэл энэ лабораторийн хүчин чадал муу, зарим аппаратууд нь ажиллахгүй байна, нөгөө талаар мэргэжилтнүүд ч хангалтгүй байна. Энэ талаар төсөв дээр юм тавиулсан уу, энэ хуулийн юун дээр өөрчлөлт оруулсан уу гээд асууя.

Г.Занданшатар: 92
Барсүрэнгийн Баасандорж МХГ-ын дарга.

Б.Баасандорж: Гишүүний асуултад хариулъя. 2 асуулт асуулаа. Би 2 дугаар асуудлын хүрээнд асуултад хариулъя, Баасандорж. Лабораторитой холбоотой асуудал хөндөж байна, гишүүн. Ер нь бол яг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт өөрөө бас мөн МХЕГ-ын харьяанд байсан. 2019 оны хуулийн өөрчлөлтөөр МХЕГ-ын энэ эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, чиг үүргээрээ салбартаа буюу эрүүл мэндийн салбарт ЭМЯ-ны харьяанд очсон байгаа, 19 оны хуулиар. Тэгэхээр энэ лабораторийн асуудал нь бол манай мэргэжлийн хяналтын байгууллагууд бол харьяанд бол байдаггүй, ЭМЯ дээр харьяалагддаг. Гэхдээ Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 6 дугаар сарын хуралдаанаараа энэ ер нь лабораторийн асуудал дахь

асуудлаар шийдвэр гаргасан байгаа. Тэр нь өнөөдөр яг энэ төрийн байгууллагуудын лабораториудыг харахаар яг ингээд тус тусдаа, жишээ нь, МХЕГ Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори нь, Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа мал эмнэлгийн чиглэлийн лаборатори нь, ЭМЯ-д эрүүл мэндийн лаборатори нь, ГЕГ-т хилийн хорио цээртэй холбоотой ингээд лабораториуд өөр өөр байгууллагуудад ингэж шилжсэн. Яг лабораторийн нэгдсэн тогтолцоо байдаггүй. Үүнээсээ болоод нөгөө төсөв мөнгөтэй холбоотой шинэчлэлтэй холбоотой асуудлууд нь өөр өөр бодлого, шийдвэрээр өөрөөр ингэж их тарамдаж хэрэгждэг юм байна лээ. Тэгэхээр энэ ЗГ-аас 6 дугаар сард гарсан шийдвэрээр ямар шийдвэр гарсан гэхээр энэ лабораторийн нэгдсэн тогтолцоонд шийдэх нь зөв юм байна. Энэ лабораторийн нэгдсэн тогтолцоонд шилжих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, энэ нэгдсэн тогтолцоо руу түргэн шуурхай шийдвэрлэе ээ гэсэн шийдвэр гарсан байгаа гишүүн ээ. Ер нь лабораторийн асуудал өөрөө тоног төхөөрөмжийн хувьд, хүний нөөцийн хувьд хүндрэлтэй байгаа юу гэвэл хүндрэлтэй байгаа. Энэ Мэргэжлийн хяналтын хуультай холбоотой өөрчлөлтөөр МХЕГ-ын харьяанд байсан лаборатори бол Стандартчилал хэмжил зүйн газар луу шилжиж байгаа. Өмнө нь 12 он хүртэл бол Стандартчилал хэмжил зүйн газар энэ лабораторийн асуудлаа хариуцдаг байсан байгаа. Өөрөөр хэлбэл Шадар сайдын харьяа руу шилжиж байгаа.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Сая нөгөө манай Монгол Улсын талаас 1800000 тонн гэсэн гарч байгаа нүүрс, Хятад тал болохоор чинь 2100000 тонн гээд ярьж байгаа Хүрэлбаатар сайдаа, би энэ ЗГ-т мэдээлэл хүргүүлсэн, ийм хулгайгаар нүүрс гарч байна уу, энэ талаар мэдээлэл авсан уу гээд л асуух гээд байна.

Г.Занданишатар: Дашизэвэгийн Амарбаясгалан ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд хариулна.

Д.Амарбаясгалан: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энэ мэдээллийг аваад ГЕГ нягталж байгаа. Яг хилийн боомтоор гарсан дүн мэдээ яг тэр цаад талдаа хэвлэлээр нь гарсан дүн мэдээтэй зөрж байгаа гэсэн ийм зүйл яригдсан. Гэхдээ яг Хятадын талд гарсан тэр мэдээлэл нь хэзээ гарсан, хэдний өдөр хэвлэл мэдээлэлээр гарсан бэ гэдэг нь бас тодорхойгүй байгаа учраас яг тэр дүн мэдээтэй Монголын гаалийн мэдээг тулгаж үзэх боломж бол одоохондоо байхгүй. Гэхдээ ГЕГ-аас Хятадын талд дүн мэдээгээ ирүүлэх хүсэлтийг тавьсан байгаа. Тэр дүн мэдээ хариу ирсний дараа тулгаж эргэж мэдээлье.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулах ёстой. 87 зарчмын зөрүүтэй санал байгаа. Төсвийн хуультай хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолуудын төслүүдийн талаар нийт 87 саналаар санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо хуралдаж байгаа учраас санал хураалт зэрэгцүүлэн явуулах

бололцоогүй байна. Төсвийн байнгын хороон дээр бол санал хураалт явагдаж байгаа.

Ийм учраас Төсвийн байнгын хороо хуралдаж дуустал 30 минутын хугацаатай завсарлуулаа.

15. 30-аас чуулган үргэлжлүүлж хуралдана.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН

Г.Занданишатар: Эрхэм гишүүд Төсвийн байнгын хорооны хуралдаан дууссан тул нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд цуглацгаана уу.

УИХ-ын намрын чуулганы 11 дүгээр сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдааны үдээс хойших хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Төсвийн байнгын хороо хуралдаж дуусаагүй байсан учраас түр завсарласан.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Монгол Улсын 2023 оны төсвийн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эхний хэлэлцүүлгийг явуулна.

УИХ-ын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд, Цэвэгдоржийн Туваан нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ахмадуудын төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нэгдүгээрт, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

Зарчмын зөрүүтэй 87 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслүүдийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нэгдүгээрт, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 онд 25, 2025 онд 45, 2026 оноос 65 байна” гэснийг “Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2023 онд 0, 2024 оноос 65 байна” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ширнэнбаньдын Адьшаа, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал,

Дамбын Батлут, Баагаагийн Баттөмөр, Энхбаярын Батшугар, Жадамбын Бат-Эрдэнэ, Гочоогийн Ганболд, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтайн Ганибал, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жамъянгийн Мөнхбат, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Саранчимэг, Цэвэгдоржийн Туваан, Чинбатын Ундрам, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Содномын Чинзориг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Төмөртоогоогийн Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэнэ ээ. Санал хураалт явуулна.

Санал хураалт. 29 гишүүн дэмжиж 51,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2-т, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Төслийн 4 дүгээр зүйлээс “11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэж,” гэснийг хасаж, төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“1/10 дугаар зүйлийн 10.1.19 дэх заалт:

“10.1.19.Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал

эрэл хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гүйцэтгэнэ.”” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 29 гишүүн дэмжиж, 55,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 31 гишүүн дэмжиж 56,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 31 гишүүн дэмжиж 56,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Төслийн 4 дүгээр зүйлээс “47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг,” гэснийг хасаж, хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“2/47 дугаар зүйлийн 47.9 дэх хэсэг:

“47.9.Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болох бөгөөд бүртгүүлсэн мэдээллийг татварын байгууллагад тухай бүр бүртгүүлнэ. Энэ тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгэн адил төлж, тайлагнана.”” Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Баттөмөрийн Энхбаяр үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ одоо санал хураах гэж байгаа юугаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо хэмжээг яамандаа зөв бүртгүүлж, зөвшөөрөл авна гэсэн томъёололтой явж байна л даа. Манай ашигт малтмалын хуулиар чинь болохоор Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар нь үүнийг бүртгэж явдаг. Тэгэхээр энэ 2 хуулийн зөрчил үүсчих үү, үгүй юу? Яам бол яг энэ юу руу ордоггүй шүү дээ, бодлого руу л ордог болохоос биш энэ тусгай зөвшөөрөл рүү нь бол ордоггүй шүү дээ. Тэр байтугай тусгай зөвшөөрлийг нь бол бид нар чинь нөгөө ашигт малтмалын хуулиа хийхдээ бүр тэр кадастрынх нь нэгжийг нь тусад нь бас хуульчилчихсан байдаг шүү дээ. Тэгэхээр энэ хууль хоорондын зөрчил үүсчих юм биш байгаа даа гэсэн ийм үг байна.

Г.Занданшатар: Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Яам бүртгээд зөвшөөрөл олгохоор энэ бас нэг Ашигт малтмалын хуультайгаа зөрчилдөж болохгүй байх заалтууд уялдах ёстой шүү дээ, нөгөө заалтаа 47-гийн 9 дээр яг зүйлд гарчихаар юу болох юм. 47-гийн 9 дээрээ тэгж юу яасныг хасчхаж байгаа юм биш үү.

Зочид танилцуулъя.

УИХ-ын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг, Төмөрбаатарын Аюурсайхан, Жамъянхорлоогийн Сүхбаатар нарын урилгаар ЧД-ийн иргэдийн төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг ерөөе.

4. Төслийн 5 дугаар зүйлийн “Ашигт малтмалын тухай хуулийн” гэсний дараах “26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “, мэргэжлийн хяналтын албанд” гэснийг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 32 гишүүн дэмжиж 56,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гурав.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“57.17.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон

нутгийн нэмэгдэл олгож болно.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Хишгээгийн Нямбаатар. ТББХ дэмжээгүй санал байна.

Дэмжээгүйг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Содномын Чинзориг, Төмөртоогоогийн Энхтүвшин нарын гишүүд үг хэлнэ.

Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орох гэж байгаа хууль нэлээн ярих ёстой юм уу гэж бодоод байгаа юм даа. Тэгээд л яваад л байгаа юм, 2 юм байгаа юм.

Нэг дэх асуудал нь энэ Төрийн албан тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа хуулиар төслөөр чинь бол орон нутгийн нэмэгдэл олгож болно гээд байгаа юм. Тэгээд тэр орон нутгийн нэмэгдэл нь хэдэн хувь байх юм, яаж олгох юм гэдэг нь тодорхойгүй. Тийм учраас бол энэ төрийн албаны хуульд өөрчлөлт оруулахдаа тэр орон нутгийн нэмэгдэл нь ЗГ-ын Сангийн сайдын ярьж байгаагаар 20 хувь байна гээд байгаа юм. Хэрвээ 20 хувь байх юм уу, тэрийг нь тодорхой зааж өгмөөр.

Хоёрдугаарт, энэ орон нутгийн нэмэгдэл олгох тэр журмыг нь ЗГ батална гэсэн бас ийм нэг зохицуулалт уг нь баймаар байгаа юм. Хэрвээ энэ хууль энэ чигээр ингээд батлагдвал орон нутгуудад чинь тийм ялгамжтай байдал үүсчих гээд байгаа юм л даа, Төрийн албан хаагчдад. 20 хувийн нэмэгдэл олгох юм шиг ярьж байгаа юм, Сангийн сайд.

Тэгээд дээшээ орон нутгууд хэдэн хувиар ч нэмж болно оо гээд байгаа юм. Гэтэл манай 21 аймгийн чинь зургаахан аймаг нь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжилт авдаггүй, орлогоороо санхүүжилтээ нөхдөг. Бусад аймгууд нь бүгд улсын төвлөрсөн төсвөөсөө татаас авдаг, тэгээд ийм байтал ингээд орон нутгийн нэмэгдлийг орон нутаг өөрсдөө орлогынхоо боломжоос хамаараад өгч болно оо гээд явчих юм болбол энэ чинь нэлээн тийм бас ялгамжтай байдал үүсчхээд орон нутгийн улсын төсвөөс санхүүжилт авдаг аймгууд нь нэмэлт орон нутгийн нэмэгдэл өгч чадахгүй ийм байдал руу орчих гээд байгаа юм.

Хоёрдугаарт, энэ ЗГ-ын орж ирсэн саналаар болбол зөвхөн төрийн захиргааны албан хаагчдад нь олгоно оо гээд байгаа юм. Тэгэхээр төрийн үйлчилгээний албан хаагчид нь бас яах юм бэ гэж. Эрүүл мэнд, боловсролынхныг гүйцэтгэлийн санхүүжилтээр явж байгаа боловсрол болохоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилт авч байгаа учраас төрийн үйлчилгээнийхэнд орон нутгийн нэмэгдэл өгөхгүй, өөрсдөө санхүүжилтийнхээ зарчмаараа орон нутгийн нэмэгдэл өгөх боломжтой болно оо гэж яриад байгаа юм.

Эрүүл мэндийн байгууллага дээр тийм боломж бол үүсэж байж магадгүй, гэхдээ одоогийн энэ эрүүл мэндийн гүйцэтгэлийн санхүүжилт чинь нэг их тийм сайн үр дүнтэй ч болохгүй л байгаа юм л даа. Боловсрол дээр болбол тэр чанар, үр дүнд суурилсан санхүүжилт чинь багш нар дээрээ л хамаарах байх, тэр төрийн үйлчилгээний албан тушаалтан, бага албан тушаалтнуудад тэр чанар, үр дүнгийн санхүүжилт чинь хамаарах

уу, үгүй юу гээд. Тэгэхээр энэ орон нутагт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад энэ орон нутгийн нэмэгдэл чинь олгогдохгүй л болчихоод байгаа юм л даа. Тийм учраас болбол үүнийг бас гишүүд нэлээн бас эргэж бас харах ёстой байх. Шаардлагатай болбол санал хураахгүйгээр гүйцээн боловсруулах чиглэл өгөөд Байнгын хороонд ирээд дахиж бас ярихад бас болохгүй бас шаардлага, дахиж ярих шаардлага бас гарах болов уу гэж л бодоод байгаа юм. Үүнийг бас гишүүд бас анзаарна биз дээ.

Г.Занданшатар:

Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн үг хэлнэ.

Т.Энхтүвшин:

Энэ улсын төвлөрсөн төсөвт нөлөөлөөд байх юм биш л дээ, энэ. Ямар ч нөлөө байхгүй, энэ бол. Үгүй ээ, энэ орон нутагт чинь ажиллах хүнгүй болчихоод байна шүү дээ. Тэгээд орон нутагт ядаж энэ нэмэгдлийг нь олгох ийм бололцоо боломжийг нь нээгээд өгчих хэрэгтэй шүү дээ. Энэ сумын ИТХ, аймгийн ИТХ-аараа хуралдаад л энэ алслагдсан нэг сумдад байж байгаа төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан тушаалтнууддаа л нэг жсоохон нэмэгдэл өгдөг л юм байгаа юм. Энэ бол улсын төвлөрсөн төсөвт ямар ч хамааралгүй зүйл, орон нутаг өөрийнхөө нөөц бололцоо дээр тулгуурлаад өөрийнхөө орлого дээр тулгуурлаж, ИТХ-аараа л шийддэг л мөнгө шүү дээ. Тэгээд олгоод л явж байгаа юм. Өмнөговь, Дорноговь аймгийн алслагдсан бүс нутгуудад энэ 20 хувийн нэмэгдлийг олгоод явж байгаа шүү дээ. Олгоод явж байгаа юмыг хаана гэдэг бол байж боломгүй л зүйл, энэ алслагдсан бүс нутагт энэ хүн ажиллахгүй байгаа шүү. Тийм учраас энэ дээр гишүүд маань бас

кнопоо дарахгүй, үүнийг бас дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Үгүй ээ, үгүй энэ бол үгүй ээ, үгүй, үүнийг нээгээд л өгчих л дөө. Бусад аймгүй ч гэсэн бие дааж орлогоо нээгээд л бүрдүүлээд л явах хэрэгтэй шүү дээ. Бололцоо боломжтой аймгууд нь өгөөд л явж байгаа юмыг хаах гээд байх хэрэг байхгүй байхгүй юу. Тэгээд өөрөө өөрийгөө санхүүжүүлж байгаа аймгийг дэмжье гээд... /минут дуусав/

Г.Занданшатар: Төсвийн байнгын хорооны дэмжээгүйг дэмжинэ. Ингээд санал хураалт явуулна.

Санал хураалт явуулъя. Бүлгийн саналаар Байнгын хорооны саналаар дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Энэ байна шүү дээ, дэг зөрчиж байна шүү. Ийм санал гаргахад ер нь бас ЗГ-ын саналыг авсан, төсвийн зарлагыг нэмэгдүүлэх санал дээр ЗГ-ын саналыг авсан байх ёстой гэсэн тийм дэгтэй шүү.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Энэ тэгэхээр ийм байгаа юм. Гишүүд ээ, нэг юм ойлго. Одоо төсөв боогдсон энэ төсөв дагасан хууль бол яг төсвийн боогдсоноор яваа. Энэ төрийн захиргааныхан нь бол ЗГ оруулж ирэхдээ хууль дээр нь тусчихсан байгаа, юу, төсөвт нь тусчихсан байгаа. ТҮ гэдгээр ороод ирэхдээ зэрэг 46 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардаж байгаа юм. Зарим нь жаран хэд гэж байгаа юм. Энэ болбол

юунаас яах вэ гэхээр үүнийг бол хэрэв бид нар энэ өгүүлбэрийг оруулах юм бол тэгвэл дараагийн юу төсөв чинь ахиад задраад явах байхгүй юу. Тийм учраас ийм хариуцлагатай асуудлуудаар гишүүд ээ, хэрэв дараа нь нэмэргүй, ЗГ ахиад л улсын төсвийнхөө бодлого дээр ахиад л оруулаад ирэх боломжтой шүү дээ. Яагаад вэ гэхээр боловсрол, эрүүл мэнд чинь улсын төсвийн дээр явдаг ийм албан хаагчид байхгүй юу. Одоо тэр төрийн захиргаа нээгээд байгаа чинь зөвхөн орон нутгийн албан хаагчидтай холбоотой юм байхгүй юу. Тийм учраас болбол үүнийг дэмжмээргүй байгаа юм, гишүүд ээ. Би тийм учраас саяын саналыг төсөв мөнгөтэй холбоотой учраас хүчингүй болгох санал хураалт явуулаад дахин санал хурааж явуулж өгөөч ээ гэж хэлэх гэж байна.

Эсвэл тэр Нямбаатар нөхрийг дууд, Жавхлан сайд аа, энэ ЗГ-ынхаа оруулж ирсэн бодлогын эсрэг санал гаргадаг сайд хэрхэвч байж болохгүй. Нөхөр Нямбаатар энэ ТББХ дээр ЗГ-ынхаа саналын эсрэг санал гаргасан байхгүй юу. Эс үгүй бол Нямбаатараар нь татуул үүнийг. Ийм л 2 арга байгаа.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан саяын санал хураалтыг хүчингүйд тооцох саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай. Санал хураалт 30 гишүүн дэмжиж 51,7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Саяын санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас дахин

санал хураалт явуулна. Төсөв задрах гээд байна гэж байна.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя, дэмжье.

58,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хууль дээр нөгөө болно гэж ялгавартай тогтоож бас болохгүй л дээ, бас. Төрийн албан хаагчдын.

Дөрөв. ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар, 120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж тооцон албан татвар оногдуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Үг өөр байхгүй байна, тасаллаа.

Ц.Даваасүрэн: Энэ хүн амын орлогын албан татвар руу орж байгаа асуудлууд бас нэг тийм сайн зүйл биш харагдаад байгаа юм. Ер нь нөгөө дундаж орлоготой иргэн, тэгээд хуримтлал гэдэг юмыг бид нар ингээд бодохгүй, улам доош нь оруулах л юм хийж байгаа байхгүй юу. Би болбол нийгэмд хэт энэ ядуурал, нийгмийн ялгаа бий болоод байгааг болбол би ялангуяа уул уурхайгаас өндөр орлого олж байгаа компаниудын татвар энгийн компанийн татвартай ижилхэн шахуу байна шүү дээ, үүнийг л харах ёстой байхгүй юу. Энэ чинь л баян хоосны ялгаа, нийгмийн энэ ялгаварлыг бий болгож байгаа. Ер нь тэгээд социал демократ нам гэдэг бол энэ дээр л ажилладаг намыг хэлдэг шүү дээ. Нийгмийн тэгий байдлыг бий болгохын төлөө зорьдог, том компаниудын татварыг өндөр байлгадаг, дундаж давхаргыг орлоготой байлгадаг, түүнээс биш яах вэ дээ, нэг хуримтлалтай болж ядах гэж явж байгаа дундаж орлоготой иргэдийгээ ингээд орлогын албан татвар нэмэх нэрээр ядуурлын эгнээ рүү доошоо оруулах юм руу ингэж оруулдаг ийм арга хэмжээг бол уг нь авдаггүй юм.

Энэ бол яг зүгээр зарчимтай, бидний яриад байгаа тэр социал демократ гээд байгаа зарчимтай бол нийцэхгүй л юм харагдаж байгаа юм. Цаашидаа бол бид нар бас энэ манайд энэ баян, хоосны ялгаа их болсон юм болбол том татвар төлөгч жижиг татвар төлөгч бараг ялгаагүй шахуу болсонтой холбоотой байхгүй юу. Тийм учраас өнөөдөр ядуурал нийгэмд ийм гүнзгий болсон. Нэг хэсэг нь байшин барьдаг болсон, гоё гоё байшин барьдаг болсон, нөгөө хэсэг нь килограмм төмс авч чадахгүй

ширхгээр нь төмс авдаг болсон, ийм л юм шүү дээ.

Г.Занданишатар: Шаталсан татварыг дэмжиж үг хэллээ.

Санал хураалт явуулна, гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт. Сэргэлэн гишүүн, Ганболд гишүүн 2 саналаа өгөөрэй.

31 гишүүн дэмжиж, 55,4 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1, 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн санал хураалт.

37 гишүүн дэмжиж 66,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал дэмжигдчихээд байхад тэр хуулийг буцаана гэсэн санал хураалт яаж болох юм. Агар-Эрдэнэ хаачсан.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явъя.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин. Дэмжээгүйг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

40 гишүүн дэмжиж 70,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зургаа.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт. 41 гишүүн дэмжиж 71,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул “хуулийн төсөл буцаах тухай” УИХ-ын тогтоолын төсөл батлагдсанд тооцлоо.

Уншиж танилцуулъя. Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41-ийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1. Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-д Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу, алга байна. Эцсийн найруулга дээр энэ үг үсгийг жоохон өөрчлөх юм байна шүү, он сар, өдөр чинь дараа нь ордог шүү дээ.

Ингээд үүнийг батлагдсанд тооцлоо.

Долоо. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн нэгдүгээр зүйлийн 18 дугаар зүйлийн 18.19 дэх хэсгийн Төслийн 1 дүгээр зүйлийн 18 дугаар зүйлийн 18.19 дэх хэсгийн “түүний дэд бүтцийг сайжруулах, хэвийн үйл ажиллагааг хангах зориулалтаар зарцуулна.” гэснийг “хэвийн үйл ажиллагааг хангахад зориулан төсвөөс санхүүжүүлнэ.” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганибалын Амартүвшин, Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн санал хураалтад оролцоорой. Содномын Чинзориг гишүүн санал хураалттай оролцоорой.

73,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.5} дахь хэсгийн “тус байгууллагад” гэсний өмнө “энэ хуулийн 32^{1.4} дэх хэсэгт заасны дагуу баталсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан” гэж нэмэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганибалын Амартүвшин, Инновац, цахим

бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт. 73,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.9} дэх хэсгийн “32^{1.1}” гэснийг “32^{1.1.1}, 32^{1.1.6}, 32^{1.1.8}” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганибалын Амартүвшин, Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт. 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4. Төслийн 1 дүгээр зүйлийн 32¹ дүгээр зүйлийн 32^{1.1} дэх хэсгийн 32^{1.1.1} дэх заалтын “түргэн,” гэснийг хасаж, мөн хэсгийн 32^{1.1.6} дахь заалтын “тасралтгүй, найдвартай” гэснийг “хэвийн” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганибалын Амартүвшин, Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

Санал хураалт. 73,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм. Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн “ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛ ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ” гэсэн хуулийн нэрийг “ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ” гэж өөрчлөх. Үүнтэй уялдуулан төсөлд тусгагдсан “Гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай” гэснийг “Засгийн газар дахь хяналтын тухай” гэж тохиолдол

бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Үг. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Зарчмын хувьд бол энэ гүйцэтгэх засаглал дахь хяналтын тухай гэдгийг нь бол ЗГ-т хяналт гэдгийг нь бол дэмжиж байгаа юм. Тэгэхдээ ЗГ дахь хяналтын тухай гэгчхээр УИХ-ын хяналтын хууль маань бол ер нь бол гүйцэтгэх эрх мэдлээ л хянах л хууль байгаад байгаа юм. Яагаад гэхээр парламентын хяналт гэдэг чинь нөгөө шүүх эрх мэдлийг хянах хууль, хөндлөнгөөс оролцдоггүй, юу хянадаг вэ гэхээр ерөөсөө л ЗГ-ын үйл ажиллагааг хянадаг. Тэгэхээр ЗГ дахь хяналтын хууль гэдэг бол хэрэг дээрээ парламентын хяналтын тухай хууль гээд энэ 2 хуулийн маань нэр агуулга дээр бас зөрчил үүсэх вий. ЗГ-ын хяналтын хууль гэгчхвэл яадаг юм бол, шууд. ЗГ-ын нөгөө дотооддоо байж байгаа хяналт шалгалт учраас. ЗГ дахь хяналт гэгчхээр УИХ-ын хяналтын хууль юм шиг логик бас уншигдаад байх шиг байх юм. Тэгэхээр ЗГ-ын хяналтын хууль байгаад байгаа байхгүй юу. Энэ чинь нөгөө ЗГ-ын дотооддоо хийж байгаа хяналтын дотоод хяналтынх нь хууль байгаа байхгүй юу. ЗГ дахь хяналтын гэхээр ЗГ-ыг чинь хэн хянадаг вэ гэхээр УИХ л хянадаг байхгүй юу, парламент. Тэгэхээр нөгөө парламентынхаа хяналтын хуультай гарчиг нь юу яагаад байх юм шиг санагдаад байна.

Г.Занданшатар: Дотоод хяналт, ЗГ-ын дотоод хяналтын тухай хууль биш гүйцэтгэх засаглал дахь гэх юм бол Ерөнхийлөгчийн зарим

эрх мэдэл ч гэсэн гүйцэтгэх засаглалд хамаарна. ЗГ дахь гэхээр. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ л дээ, одоо. Тэгэхдээ.

Санал хураалт явуулъя. ЗГ дахь гэдэг нь арай хумьж байгаа л гэсэн үг. ЗГ-ын дотоод хяналтын тухай хууль ЗГ дахь гэвэл арай илүү юм даа.

Санал хураалт явуулъя. 66,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

ЗГ-ын дотоод хяналтын тухай хууль гэвэл илүү л юм шиг байгаа юм. Дахь гэдэг үг чинь их олон утгатай шүү дээ, тийм ээ.

Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараарай.

2. Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.4 дэх хэсэг нэмэх:

“11.4.Улсын төсвийн санхүүжилттэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн бол төсвийн хяналтын сонсголыг явуулна.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, ТББХ дэмжсэн санал.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ. Санал гаргасан гишүүн.

Б.Энхбаяр: Энэ нөгөө ЗГ-ын байгуулж байгаа дотоод хяналтын байгууллага маань улсын төсвийнхөө бид нарын УИХ-аас баталсан улсын төсвийн санхүүжилтийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд бол тогтмол хяналт шалгалт хийх байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр болохоор нөгөө

төсвийн хяналтын сонсгол явуулна гээд УИХ дээр би бол ийм байх нь зүйтэй гээд тэгчихсэн чинь яах вэ, Хэрэг эрхлэхийн сайдтай бас ярьсан, энэ нөгөө нэг улсын төсвийн маш хэдэн зуу, мянган арга хэмжээ болгон дээр УИХ сонсгол хийх болчихоод хүндрэл гарах юм байна. Тийм учраас энэ саналаа би татаад авъя гэж байгаа юм. Нэгдүгээрт нь.

Ингэж татаж авсантай холбоотойгоор тэр Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал гээд дээр доор байгаад байгаа юм. Гүйцэтгэх засаглалын хяналт шалгалтын ажлын ерөнхий үр дүнг жил бүр УИХ-д танилцуулах гэж үүнийг дэмжээгүйг нь болохоор унагаад та бүхэн босгоод ирчихээч ээ. Өөрөөр хэлбэл, ерөнхий энэ хяналт шалгалтынх нь бол ерөнхий нэг дүнг бол УИХ дээрээ сонсдог байя. Жишээлбэл, УИХ бол гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар УЕП-ын танилцуулгыг жил болгон сонсдог. Монгол Улсын бас Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны тайланг сонсдог, ХЭҮК-ын тайланг жил болгон сонсдог, яг энэ нөгөө зүйлүүдтэй адилхан УИХ бол ерөнхий, ер нь ЗГ-ын энэ хяналт шалгалтынхаа хүрээнд бас юу байна, ямар үр мөрөөр арга хэмжээ авч байна, ямар зөрчил дутагдал илрэв, юу хийж байна гэдэг дээр нь тэр мэдээллийг нь бол ямар ч байсан сонсдог байя, байх нь зүйтэй байгаад байгаа юм. Тийм учраас энэ тэр дэмжигдээгүй саналыг нь бол дэмжихгүй байж байгаад босгоод ирчихмээр байгаад байгаа юм, харин. Үүнтэй холбоотойгоор яах гээд байна вэ гэхээр УИХ-ын хяналт шалгалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гээд байгаа юм. Одоо гүйцэтгэх эрх мэдлийн хяналтын хууль гээд явчхангуут энэ дээр бас УИХ-ын хяналтын чиглэлээр энэ чиглэлээр

санал гаргах гээд бэлдчихсэн байгаа юм бэлдчихсэн. Өөрөөр хэлбэл, УИХ-ын, бас чөлөөт цагт УИХ маань энэ тогтмол хяналт шалгалтыг бас хийдэг байх ёстой, УИХ-ын маань хууль батлахаас гадна энэ хуулийнхаа хэрэгжилт дээр бас байнга тогтмол араас нь ард иргэдийнхээ дуу хоолой болж, тэр нөгөө төлөөллийн байгууллагынхаа ажлыг бас хийх ёстой байгаад байгаа юм. Түүнийх нь нэг чухал чиглэл нь бол энэ хяналт, шалгалт байгаа. Тийм учраас энэ УИХ-ын хяналт шалгалтын хуульд өөрчлөлт оруулахын тулд тэр дэмжээгүй саналыг босгож ирж байгаад үүнийхээ дагуу Их Хурлын хяналтын хуульд өөрчлөлт оруулах ёстой болчихоод байгаа юм гэдгийг гишүүддээ хэлье.

Г.Занданшатар: Тийм, үүнийгээ татаж авсантай холбогдуулаад Төсвийн байнгын хороо дэмжээгүй тэр 10 дугаар зүйлийн 10.2-ыг нэмэх заалтыг босгоё оо гэж байгаа юм байна. Тэгээд энэ бол зарчмын хувьд, агуулгын хувьд байх, Амарбаясгалан дарга, ЗГХЭГ-ын дарга ч гэсэн тэр зүйл, заалт болгон дээр бол УИХ оролцоод байх нь зохисгүй, бүхэлд нь багцлаад түүн дээр хяналт тавьдаг энэ олон улсын жишиг тэр тийм юм байна лээ. Сонсголын хяналт тавьдаг тэр, төсвийн хяналтын нийтлэг зарчим нь. Энэ ч бас юундаа байгаа. Одоогийн энэ хянан шалгалт, сонсголын хуулийн агуулга нь бас байгаа, агуулга энэ дээр илүү тодорхой болгох юм байна. Тэгэхээр үүнийг ингээд нийлүүлээд татаж аваад гүйцээн боловсруулах чиглэл өгчих үү, аль эсвэл унагаагаад татаж аваад түүнийгээ босгох зарчмаар явах уу. Тогтох оо дарга аа. 10-ын 2-ыг. Үүнтэй яах вэ, нөгөө холбоотой л татаж байна л даа,

нөхцөлтэйгөөр татаад байна л даа. Тэгэхээр нөхцөлийг нь 12-ыг босгоно гэвэл ингээд татсанд тооцлоо. Босгохгүй гэвэл гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Баттөмөрийн Энхбаяр гишүүний саналыг хүлээж авлаа. Татаад 12-ыг босгохоор тохирлоо гэж үзэж байна.

2. Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан байгуулахдаа 11-ийн 4 дэх хэсгийг нэмэх. Үгүй ээ, энэ чинь шууд алгасаад явчихлаа.

3. 2 дугаар саналыг татан авсанд тооцсон.

3. Төслийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “асуудлаар урьдчилан мэдэгдэх асуудлаар” гэснийг “асуудлын хүрээнд урьдчилан мэдэгдэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 39 гишүүн дэмжиж 67,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Ер нь энэ хууль маань бол хуулийн хэрэгжилтийг хангах том дэвшил гаргана л гэж үзэж байгаа шүү дээ.

4. Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагч байна.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ угаасаа гишүүдээ дэмжихэд асуудал байхгүй санал. Яагаад гэхээр төсөл дээр орж ирэхдээ ингээд ороод ирсэн байхгүй юу, ЗГ-ын хяналтын агентлагийн дарга нь Хэрэг эрхлэх газрын дэд дарга байна гэж ороод ирсэн юм, тэгээд энэ чинь зөв уншигдахгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу гэж хэлээд байгаа вэ гэхээр Хэрэг эрхлэх газрын дэд дарга нь энэ байгууллагынхаа дарга байна гээд үг зүйн хувьд аминдаа нэгдүгээрт найруулж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ гол асуудал миний нөгөө яриад байсан асуудал нь юу вэ гэхээр харин дэд дарга нь агентлагийн дарга байж болохгүй байгаад байгаа юм, агентлагийн дарга. Энэ бол байгууллагын дарга учраас болж байгаа юм, өөрөөр хэлбэл агентлаг биш байгууллагын дарга болчхож байгаа юм. Энэ санал дэмжигдсэнтэй холбоотойгоор хойно байгаа ЗГ-ын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчилсөн УИХ-ын тогтоолд энэ байгууллагыг агентлагийн бүдүүвч дотор биччихсэн байгаад байгаа юм. Тэр агентлагийн бүдүүвчээс нь хасах хэрэгтэй байгаад байгаа юм. Энэ санал дэмжигдсэн тохиолдолд.

Ингээд агентлагийн бүдүүвчээс нь хасъя гэдэг зүйлийг бол бас ЗГ-ын нөхдүүдтэй бол ойлгогччихсон, чиглэл өгч байж тэндээс нь хасахгүй болохоор бас санал гаргагдаагүй болохгүй байгаад байгаа. Зарчмын хувьд бол Хэрэг эрхлэх газрын дэд дарга нь агентлагийн дарга бол байж болохгүй байгаад байгаа юм. Тэр бол зарчим нь бол болохгүй байгаа юм. Яагаад гэхээр бид нар чинь ЗГ-ын

бүтэц бүрэлдэхүүн маань яам, агентлаг гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ЗГ-ын өөрийнх нь, ажлын албаных нь дэд дарга нь, агентлагийнх нь дарга байж болохгүй байгаад байгаа юм. Байгууллага бол толгойлж бол болно, агентлаг биш байгууллага бол зөндөө байдаг байхгүй юу. Тийм байгууллага бол зөндөө байдаг юм. Агентлаг болчихоор агентлагийн хуулиар яваад байгаа байхгүй юу. Тэгээд агентлагийнх нь бүдүүвчээс нь бол авчих ёстой байгаад байгаа юм.

Г.Занданишатар:

Амарбаясгалан дарга бол үүнийг сайд бол зөвшөөрчихсөн юм уу, тийм ээ. Тэгээд ер нь ЗГХЭГ-т дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний газар гэж байдаг. Энэ маань бас үүнтэйгээ уялдах байх. Мэргэжлийн хяналтын газар маань дахин зохион байгуулагдана, тэгээд үүнийгээ бас уялдуулах шаардлага нь илүү зөв байх, тэр. Агентлагийн дарга бөгөөд дэд дарга гэж байж болохгүй л дээ. 2 статус.

Ингээд санал хураалт явуулна.

Баянхонгор аймгийн Баянговь сумын ИТХ-ын төлөөлөгчид УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Санал хураалт явуулна, гишүүд анхаараарай, санал хураалт.

45 гишүүн дэмжиж 77,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэр хөндөөгүй саналыг шууд, тэр чинь бүтэн хууль шүү дээ, тийм

ээ. Чиглэл өгөх тийм, чиглэл өгч байна.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Гүйцэтгэх засаглалын хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг жил бүр Улсын Их Хуралд танилцуулах.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Дэмжихгүй юм байна, санал хураалт. Кноподоо хүрэхгүй гэсэн үг.

Дэмжээгүйг дэмжээгүй учраас энэ санал босож байна гэсэн үг.

Дараагийн асуудалд оръё.

Ес. ТХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 5³ дугаар зүйлийн гарчгийн “Урьдчилан сэргийлэх” гэсний дараа “хяналт шалгалт” гэж нэмж, мөн заалтын 5^{3.2} дахь хэсгийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий хэд хэдэн байгууллага” гэснийг “хяналт шалгалтын байгууллагууд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, 70,7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 8.1.3 дахь заалтын “27.1-д заасны дагуу” гэснийг “27

дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт 42 гишүүн дэмжиж, 72,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2 Төслийн нэгдүгээр зүйлийн 3 дахь заалт буюу наймын нэгийн 3 дахь заалтын 27-гийн нэгд заасны дагуу гэснийг 27 дугаар зүйлд заасны дагуу гэж өөрчлөх.

3. төслийн 2 дугаар зүйлээс тавын нэг дэх хэсгийн төлөвлөгөөт бус гэсний дараа урьдчилан сэргийлэх гэж гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 40 гишүүн дэмжиж, 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмж, дугаарыг өөрчлөх:

“2/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

5.1.Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэж ангилна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн

9.1.4 дэх заалтын “нийгмийн баталгааг хангах ажлыг” гэсний дараа “хууль тогтоомжийн хүрээнд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 9.2.4, 9.2.5, 9.2.6 дахь заалтын дугаарыг “9.2.3, 9.2.4, 9.2.5” болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Хяналт” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол хяналт” гэж өөрчилж, мөн хэсгийн “, төрийн захиргааны байгууллагад тухайн байгууллагын дарга” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8. Төслийн 4 дүгээр зүйлийн “хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт” гэснийг “хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналт шалгалт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 67,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Төслийн 4 дүгээр зүйлийн “5.1 дэх хэсгийн “Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/” гэснийг “Хуулиар

хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх олгосон байгууллага /цаашид “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэх/” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 39 гишүүн дэмжиж 67,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Төслийн 4 дүгээр зүйлийн “Үндэсний лавлагаа лабораторийн” гэснийг “стандартчилал, хэмжил зүйн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 40 гишүүн дэмжиж 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 9 дүгээр зүйлийн гарчгийн, мөн 9.1 дэх хэсэг, 9.2.2 дахь заалт, 9.5 дахь хэсэг, мөн зүйлийн 4 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсгийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “хяналт шалгалтын” гэж, мөн хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн “хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “хяналт шалгалтын” гэж тохиолдол бүрд тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арав дахь хууль руу орж байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дугаар зүйлээс хэсэг 16 дугаар зүйлийн 16-гийн 3 дахь

гэснийг хасах санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван нэг дэх хууль. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “, 15.5” гэснийг, мөн зүйлийн “21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн “22 дугаар зүйлийн” гэсний өмнө “15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг,” гэж, мөн зүйлийн “22.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэсний дараа, “23.3 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын” гэсний дараа “төв” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 37 гишүүн дэмжиж 63,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гишүүд яриа хөөрөө ихсээд ирсэн учраас энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа УИХ-ын гишүүнд мэндчилгээ дэвшүүлье. 11 дүгээр сарын 3-нд буюу өнөөдөр УИХ-

ын гишүүн Батжаргал, Балингийн Жигжид, Жунайн Цэрэннадмид нарын 7 дахь хүүхэд болж эхээс мэндэлжээ. УИХ-ын гишүүн Жигжидийн Батжаргалд УИХ-ын гишүүдийн нэрийн өмнөөс төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

3. Төслийн 1 дүгээр зүйлийн “геологи, уул уурхайн асуудал” гэсний дараах “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж тохиолдолд бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 64,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван хоёр. Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг,” гэснийг хасаж, мөн зүйлийн ““асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж,” гэсний дараа “46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 64,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлээс “40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.4, 41.5, 41.8, 41.9 дэх хэсэг,” гэснийг, “, 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “улсын хяналт хэрэгжүүлэх” гэснийг” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 59,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван гурав. Хэмжил зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан” гэснийг “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.” гэж, мөн зүйлийн “хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэснийг “хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх бөгөөд дарга нь салбарын улсын ерөнхий байцаагч байна.” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван дөрөв дэх хууль. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн” гэсний дараа “6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “хяналтын байгууллага” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Хяналтын” гэснийг “Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж,” гэж, мөн зүйлийн “тус тус өөрчилсүгэй” гэсний өмнө “,

18.2 дахь хэсгийн “5⁴.3-т” гэснийг “5⁵.3-т” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 64,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Арван тав дахь хууль. Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “10.7 дахь хэсгийн” гэснийг “10.7.2 дахь заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Арван зургаа дахь хууль. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газрын асуудал эрхэлсэн сайд” гэснийг “санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж,” гэж нэмж, төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван долоо. Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “мэргэжлийн хяналтын” гэсний өмнөх “болон” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 70,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “байгууллага, мэргэжлийн хяналтын төв” гэснийг, Зургаадугаар бүлгийн гарчгийн, 15 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийн “мэргэжлийн” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 41 гишүүн дэмжиж, 70,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван найм дахь хууль. Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “17.1.4 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг” гэсний дараа ““холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 72,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Арван ес дэх хууль. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “42 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг, мөн зүйлийн 42.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын,” гэснийг “42 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 42.1 дэх хэсгийн “мэргэжлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 69 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хорь. ЭМД-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлээс “7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтын “, мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 35 гишүүн дэмжиж, 61,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин нэг дэх хууль буюу Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслийн талаар. Төсвийн байнгын хорооноос дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “мэргэжлийн хяналтын” гэсний дараа “байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 57,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин хоёр дахь хууль. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооноос дэмжсэн саналаар санал хураалт явуулна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 36 гишүүн дэмжиж 63,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хорин гурав. Эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 17.1 дэх хэсгийн “хууль, хяналтын” гэсний өмнө “холбогдох” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 36 гишүүн дэмжиж 63,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтын өмнө зочдоо танилцуулъя.

УИХ-ын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийн урилгаар Дорнод

аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын ажилчдын төлөөлөл УИХ-ын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Дорнодчууд та бүхэндээ эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Хорин дөрөв дэх хууль. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хорооноос дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, дугаарыг 14.3 болгон өөрчлөе. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 38 гишүүн дэмжиж, 67,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уул нь Булган аймгийн Баян агьт сумын төлөөлөл орж ирэх ёстой байсан юм байна.

Хорин тав. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “хүнсний,” гэсний дараа “болон” гэж нэмж, мөн зүйлийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “, албан тушаалтан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 71,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хорин зургаа. Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага,” гэсний дараа “төрийн захиргааны байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 67,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “улсын байцаагчийн” гэсний өмнө “болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 732 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

110 хэдэн хуулиас одоо 27 дээр л явж байна.

Хорин долоо дахь хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 2 дугаар зүйлийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “эрх олгосон хөдөлмөрийн” гэснийг хасах. Санал авсан ажлын хэсэг.

Санал хураалт. 67,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин найм. Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 161 дүгээр зүйлийн 161.1 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 36 гишүүн дэмжиж, 64,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хорин ес. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гуч. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх саналыг Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ саналыг бол дэмжихгүй байна. Ер нь яах вэ, нэг зарчмаар л бид яваад байна. Тэр нь энэ мэргэжлийн хяналтын байгууллагаас яамд руу шилжиж ирж байгаа чиг үүргүүдийг агентлаг дээр нь биш, яамд дээр нь бичье гэдэг агуулгаар санал хураагаад байна. Гэтэл бид нар бие даасан хуультай, яг тухайн асуудлыг нь хариуцдаг чиг үүрэгтэй агентлагийн хуультай, тийм асуудлууд бас энэ дотор яваад энэ нь хэрэгжихдээ асуудал үүсгэх нь ээ. Түрүүн ашигт малтмал дээр би жишээ болгож Их Хурлын дарга бас дахин боловсруулах чиглэл өглөө. Энэ хүн худалдаалахтай тэмцэх чиг үүрэг чинь цагдаагийн байгууллагын чиг үүрэг байхгүй юу. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй чинь цагдаагийн байгууллага тэмцэж байгаа. Тэнд тусдаа нэгжтэй. Одоо бид нар үүнийг Хууль зүйн яам дээр бичих гэж байна л даа. Тэгэхээр Хууль зүйн яам чинь өөрөө бодлого боловсруулдаг, хуулийн төсөл боловсруулдаг ийм газар байхгүй юу. Яг тийм тодорхой хүн худалдаалах төрлийн гэмт хэрэгтэй, хойноос нь хөөж явдаг тухайлсан хуульчлагдчихсан, чиг үүрэгтэй байгууллага нь цагдаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энэ цагдаагаас нь Хууль зүйн яам руу нь болгох ийм санал орж ирээд санал хураах гээд байна. Тэгээд энэ зарчмуудыг нэг яг бие даасан хуультай, тухайн агентлаг нь хуулиар бүр хүлээсэн үүрэгтэй ийм асуудлуудыг тэр агентлаг дээр нь байлгамаар байна. Яаман дээр нь. Энэ хүн худалдаалахтай Хууль зүйн яамны нэг мэргэжилтэн хөөцөлдөх гээд байна шүү дээ, наадах чинь хөөцөлддөг юу биш байхгүй юу даа.

Ийшээ цагдаа, энэ чинь гэмт хэрэг шүү дээ, хүн худалдаалах гэж бие даасан. Тэгээд ийм асуудлууд үүсэх гээд байна.

Тийм учраас би үүнийг дэмжихгүй ээ.

Г.Занданшатар: Дэмжихгүй үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Санал хураалт.

Дэмжихгүй бол төслөөрөө үлдэнэ тийм ээ.

Хүн худалдаалахтай тэмцэх чинь агентлаг дээрээ байсан, цагдаа дээр байсан нь дэр биз дээ. Тэгэхээр энэ яам руу авчирна гэж. Бодлого нь юм уу, тэгэхдээ үүнийг сайн үзээрэй.

Энэ санал дэмжигдсэнгүй, төслөөрөө үлдлээ.

Гучин нэг. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Нийгмийн халамжийн хяналт шалгалт болбол яам дээрээ байна, дотоод хяналтаа л болох юм байна даа, юмнуудад. 58,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин хоёр дахь хууль. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын

хороо дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хариуцсан төрийн захиргааны” гэснийг “эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 57,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гучин гурав. Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дүгээр зүйлийн “39.2 дахь хэсгийн “Аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын” гэснийг “Соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж тус тус” гэснийг хасаж, мөн хуульд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл. Соёлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 59,3 хувийн талаар санал дэмжигдлээ.

Гучин дөрөв дэх хууль. Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 258 дугаар зүйлийн 258.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналт,” гэсний дараа “цагдаагийн зэрэг” гэж, “холбогдох хяналтын болон” гэсний дараа “цагдаа,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 57,4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гучин тав. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “заалтыг хүчингүй болсонд тооцугай.” гэснийг “заалтын мэргэжлийн хяналтын” гэснийг “Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх” гэж өөрчилсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 59,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гучин зургаа. “ЗГ-ын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаар. Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн. Дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

51,9 хувийн саналаар энэ санал дэмжигдэн, Төсвийн байнгын хорооны санал дэмжигдлээ.

Гучин долоо. “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол УИХ-ын тогтоолын төслийн талаар. Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дэх заалтын “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар” гэснийг “27.Төрийн цахим

үйлчилгээний зохицуулалтын газар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 64,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дэх заалтын “Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар”” гэсний өмнө “Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Хөрөнгө оруулалт, худалдааны газар” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн, дэмжээгүй үгийг Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

***Б.Энхбаяр:** Би үүнийг дэмжихгүй байна. Дэмжихгүй 2 үндэслэл байна.*

Нэгдүгээрт, ЗГ-аас ийм агентлаг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын харьяанд байгуулна гэж орж ирээгүй. ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний асуудал бол Монгол Улсын Ерөнхий сайдын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн асуудал байдаг. Ерөнхий сайд энэ асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөж, УИХ-д өргөн барина гэсэн Үндсэн хуулийн заалт байгаа. Ийм агентлаг байгуулна гэж Монгол Улсын Ерөнхий сайдаас санал орж ирээгүй, нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчтэй энэ асуудал

зөвшилцөөгүй. Тэр учраас Үндсэн хууль зөрчигдөх нь ээ гэдэг нэгдүгээр үндэслэл.

2 дахь үндэслэл нь, одоо бид энэ төсвийн хуулиар дагалдуулж 2 агентлаг шинээр байгуулахаар ЗГ-аас өргөн баригдсан. Нэг нь, гүйцэтгэх эрх мэдлийн агентлаг, хяналтын агентлаг, нэг нь Цахим сайдын харьяанд, энэ цахим хөгжил, зохицуулалтын газар гэж. Одоо ЗГ өргөн баригдаагүй байхад УИХ агентлаг байгуулдаг болох гэж байна шүү дээ. Энэ УИХ бид нар чинь энэ төрийн хэмнэлтийн бодлого гээд баахан агентлагийн дэд дарга газруудыг цөөлж байна, барьж байна гээд л хэдхэн сарын өмнө яриад байсан. Одоо ерөөсөө хэдхэн сар болоод шинээр дахиад 3 агентлаг байгуулах гэж байна. Энэ агентлаг болгон чинь даргатай болно, аягүй бол дахиад машин унана. Одоо энэ Хүрэлбаатар сайд, энэ Эдийн засгийн хөгжлийн сайд, яам хэдэн хүнтэй юм, ер нь. Энэ хуулиар чинь дахиад нэмээд Шадар сайд гэсэн тэрлэг нөмрөх гэж байгаа шүү дээ. Шадар сайд болчихоод, дахиад Хөрөнгө оруулалтын агентлаг гээд дахиад шинэ агентлаг ЗГ-аас өргөн баригдаагүй байхад чинь төсвийн хууль дагуулаад ингээд оруулж ирэх юм. ТББХ-ны хуралд миний бие суусан. Яам, агентлаг, энэ ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний асуудал ТББХ-ны эрхлэх асуудалд байдаг. Энэ асуудал ТББ дээр яригдаагүй. Би өөрөө тэр хуралд суусан, ийм шинээр агентлаг байгуулж байгаа гэж огт яригдаагүй.

Тэгэнгүүт Төсвийн байнгын хороо ингээд агентлаг байгуулаад ороод ирэх юм. Энэ одоо юм хулгайлдаг, хулгайлдаг гэхэд хэтэрч байгаа юм биш үү.

Г.Занданшатар: Асуулт хариулт байхгүй. Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Сая дэмжээгүй үг хэллээ. Дэмжиж үг, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн үг хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: Энэ ийм юм байна лээ. Энэ агентлаг бол нөгөө бид нарын хэлээд байдаг Фифта, гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын худалдаа хариуцсан ийм агентлаг. Үндсэндээ Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт эрс буурсан. Энэ хэн ч гоё юм яриад яваад байж чадна л даа. Гэхдээ Монгол Улсын цаашид эдийн засгийн хөгжлийг түргэтгэхийн тулд бид нар гадаадын хөрөнгө оруулалтын агентлагийг бий болгох ёстой. Саяхан бас энэ Өнөрболоор гишүүн хэсэг Солонгосын хөрөнгө оруулагч нарыг Монгол Улсад авч ирж уулзсан. Тэд нар Монгол Улсад хөрөнгө оруулалт хиймээр байна. Яг хаашаа очих вэ, бид нар, хэнтэй уулзах вэ гэдэг үг хэлсэн. Одоо яадаг вэ гэхээр энд тэнд янз бүрийн хүмүүстэй уулзаад яваад байдаг, албан ёсны мэдээлэл авдаггүй, албан ёсны нэг цэгийн үйлчилгээ авдаггүй ийм зүйл. Тийм учраас тэр үгнээс л бод л доо, ГХО Монгол Улсад хөрөнгө оруулъя гээд хаашаа очихоо мэдэхгүй болгочихсон. Бид нар энэ гадаадын хөрөнгө оруулалтыг дэмждэг агентлаг, гадаадын худалдаатай холбоотой, гадаад худалдаатай холбоотой асуудлуудаа хариуцаж байсан агентлагаа бүгдийг нь алга болгочихсон. Тэгээд бодлого ч үгүй, хэрэгжүүлдэг ч үгүй ийм нөхцөл байдал үүсчхээд байгаад байгаа юм. Тэгээд төсөв мөнгө нь суучихсан, бүх юм нь ингээд ороод яваад байгаа юм байна лээ. Тэгээд энэ дээр бол орхигдсон юм байна гэж үзээд ажлын хэсэг дээрээ ярьж байгаад хийсэн юм. Ер нь хэдүүлээ цаашидаа Монгол

Улсынхаа хөгжлөө бодоод ер нь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийн тулд энэ асуудлыг шийдэх ёстой. Будаач будаач гэхээр Энхбаяр аа, битгий өөрийгөө юу сахлаа буд. Бас юманд хэмжээ хязгаар байх ёстой. Чиний попролт арай хэтрээд байгаа шүү, сүүлийн үед. Хувь хүний, хувь хүнд нь хандаж асуудал ярьж байгаа бол ярь, наадахаа, асуудалгүй. Гүтгэлэг тараана, хүн доромжилно, ер нь бол хэр хэмжээнээсээ хэтрээд яваад байгаа шүү. Чамд бол жоохон даруулга хэрэгтэй, чамд хүний үг сонсох чих хэрэгтэй, хүний хэлсэн үгийг боддог толгой чамд хэрэгтэй. Ер нь хэсэг хугацаандаа чи юмаа ер нь сайн бодож байж юмандаа асуудалтай хандаж бай. Ер нь тэгж байж энэ улс төрийнхөө үйл ажилдаа хандаж бай. Тэгэхгүй болбол бас ер нь бас ойрын чиний попролт, поп поп гэхэд арай хэтэрхий попроод байгаа шүү.

Г.Занданшатар: Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, худалдаа хөрөнгө оруулалтын газар болбол зайлшгүй чухал гээд энэ хуульд өөрчлөлт оруулахад үүнийг хэлэлцээд уул нь шийдвэрлэсэн. Тэгэхдээ энэ төсөв дээрээ суусан болбол яах вэ энэ нөгөө хууль зүйн процедур байгаа талаасаа хууль зүйн асуудал байгаа талаасаа Энхбаяр гишүүн үг хэллээ гэж ойлголоо.

Зарчим бүтцийн талаасаа ЗГ тайлбарлалаа. Одоо санал хураалт явуулъя.

Санал хураалт. 32 гишүүн дэмжиж 59,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Цаашаа явъя. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал санал хураалт явуулна.

1.Төслийн 1 дэх заалтын “, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “27.Төрийн үйлчилгээний нэгдсэн газар” гэж” гэснийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Баттөмөрийн Энхбаяр ТББХ дэмжээгүй санал байна.

Шатарбалын Раднаасэд гишүүнээр үг тасаллаа. Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ агентлаг байгуулах, төрийн байгууллага байгуулах, байгуулахгүй юм дээр маргаад байх юм байхгүй л дээ. Ямар хэдэн ЗГ-ын гишүүнтэй байх вэ, түүнд нь ямар ямар чиг үүргийг хариуцуулах вэ гэдэг болбол Үндсэн хуулиар олгогдсон Ерөнхий сайдын бүрэн эрх. ЗГ-ын бүдүүвч төв байгууллага ЗГ-ын төв байгууллагуудын болон бүдүүвчийг нь тогтоолоор Их Хурал баталж өгдөг. Үүнийгээ Их Хурал бол юун дээр нь тохируулагч агентлаг байлгах вэ, юун дээр нэг хэрэгжүүлэгч агентлаг байлгах вэ, алийг нь зүгээр байгууллагын статустай болох вэ гэдэг болбол Их Хурлын асуудал. Энэ дээр нэг маргаад байх юм ерөөсөө байхгүй.

Хоёрдугаарт, түрүүн тэр бас нэг мэргэжлийн хяналтын юман дээр нэг том юм өнгөрчих шиг болсон. Энэ тохируулагч агентлаг гэдэг чинь болбол араа шүдтэй агентлагууд шүү. Татвар, гааль, тагнуул, цагдаа гээд дандаа хариуцлага тооцдог, шийтгэдэг. Энэ шинээр байгуулагдаж

байгаа агентлаг маань чухам хаанаа оччихов оо. Хэрэгжүүлэгч дээрээ оччихсон болбол наад чинь жагсаалын цэрэг хурандааг очиж шалгасантай ялгаагүй юм руу очно шүү дээ.

Нөгөө анх баталсан нөгөө төрийн албаны хуулийн энэ үзэл баримтлал, бүдүүвчтэй холбоотой энэ төрөөс баримтлах юмнууд дээр чинь үүнийгээ бид нар харин яаж харчхав. Би бас тэр анхааралгүй өнгөрчихлөө. Үүнийг эрэмбэ, дарааг нь яахгүй болбол дараа нь шалгах статустай, статусгүй гэдэг юм харж үүнийг чи мэдэхгүй байгаа биш, төрд олон жил ажиллачихсан энэ хүмүүс бол бид нарыг хараад шоолж байгаа шүү. Тийм учраас тэр агентлаг байгуулах эсэх асуудал, байгууллага байгуулах эсэх асуудал болбол тэртэй тэргүй хуулиар бий болгож өөрчилж, хүчингүй болгоно гэсэн нэг л зохицуулалт байгаа шүү дээ. Заавал Ерөнхий сайд оруулах ёстой, өөр хүн оруулах ёсгүй гэдэг юм огт байхгүй юм байгаа юм.

Г.Занданшатар: Тэгээд нөгөө бас яам яамандаа очихоор яамны орон тоо, нөгөө хяналтын газар энэ тэр яах вэ энэ тэр гээд бас асуудлууд юун дээр үр дагавар нь тэр дээрээ дагаад бүх юм хэлэлцэгдэж байгаа байхгүй юу. Бүдүүвч дээр.

Ингээд санал хураалт явуулъя. 3 байсан, 5 болсон гэсэн.

33 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гучин найм. “Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн талаар.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дэх заалт болон 2.2 дахь дэд заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дахь заалтын 1 дэх дэд заалтын “2023 оны төсөвт тусгагдаагүй төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн дараа онуудын төсөвт тусган шийдвэрлэх” гэснийг “улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж батлагдсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдлийг Төрийн аудитын байгууллагын дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шаардлагатай бол төсвийн хуульд тусган шийдвэрлүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3. Төслийн 2 дахь заалтын 3 дахь дэд заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 8 дахь дэд заалт нэмэх:

“8/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт, хөрөнгө оруулалт, татвар төлөлт, өр төлбөр, хүний нөөцийн мэдээллийг тухайн хуулийн этгээдийн цахим хуудаст ил тод,

нээлттэй байршуулах;”. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9 дэх дэд заалт нэмэх:

“9/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, экспортын гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг экспортод гаргахгүй байх, борлуулалт болон худалдан авах нууц гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;” Санал гаргасан ажлын хэсэг.

Дэмжсэн, дэмжээгүй үгийг Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Б.Энхбаяр: Энэ заалтыг бол би зарчмыг нь бол дэмжиж байгаа. ЗГ ч гэсэн энэ оптек нүүрсний гэрээнүүдийг улсын нууцаас гаргах чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа юм байна гэж дэмжиж, сайшааж байгаа. Энэ дээр нэг ийм өгүүлбэр байх юм. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт, экспортын гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлэх, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг гаргахгүй байх гэж байгаа юм. Тэгэхээр энэ Монгол Улсын алт, зэс, нүүрс гээд бүгд татварын дарга Заяабалаас мэдэгдэх юм байна, тийм ээ, хэнийг нь түрүүлж гаргах вэ, хэнийг нь дараалал эвдэж урдуур нь оруулах вэ гэдгийг бол Заяабал гэдэг дарга мэддэг болох юм байна, тийм

үү. Түүнтэй хамаарал бүхий сайд. Бид нар чинь нэг нүүрсний мафийг дарах гэж байгаад дахиад нэг нүүрсний мафийг нь гаргах гэж мафитай тэмцээгүй шүү дээ. Энэ систем нь өөрөө ямар систем байдаг юм, хүний оролцоо, хүчин зүйл нь хэр байдаг юм, бид нар шүүхийн хэрэг хуваарилалтыг бол цахимаар хийнэ гээд хүний хамааралгүй болгох гэж хонгилын системийг нурааж байна гэж ярьсан. Шалгалтыг цахимаар авдаг болгосон. Тэнд Ай Ти 2 мэргэжилтэн, Монгол Улсын шүүгчид хэн хэн болохгүйг мэддэг байсан шүү дээ. Монгол Улсын шүүгч хэн хэн болохыг Монгол Улсын Ерөнхийлөгч нь ч мэддэггүй, Ай Ти ийн 2 мэргэжилтэн мэддэг байсан шүү дээ. Шалгалтыг нь янзалчихдаг. Бид нарт энэ системээ хүний хүчин зүйл, оролцооноос ангид болгоогүй тохиолдолд энд бүртгүүлээгүй юм уу, энэ дарааллыг энэ нэг Ай Ти нөхөр мэдэх бололцоотой бол энэ бол маш том эрх мэдэлтэй хүн болох нь байна шүү дээ. Үүнийг бас нэг анхаарч, одоо бол вагон ачилт дээр бол хэний вагоныг түрүүлж явуулах вэ, хэний вагоныг хойш нь татах вэ гэдэг дээр чинь хэдэн зуун сая төгрөгийн авлига байдаг гэж яригдаад байгаа шүү дээ. Одоо татварын байцаагч дээр энэ авлигыг шилжүүлэх гэж байгаа юм байна гэж шилжүүлэх гэж байгаа бол энэ асуудал шүү.

Бид нэг авлигыг нөгөө авлигач нар солих гэж хууль гаргадаггүй, нэг мафийг нөгөө мафиар дарах гэж бас хууль гаргадаггүй, аль алийг нь дарах гэж хууль гаргах ёстой. Тийм учраас би энэ татварын системийг нь бол би буруутгаагүй шүү. Энэ шууд зөвхөн татварын байцаагч хэнийг түрүүлж гарах гарахгүйг мэддэг байж байж болох болох уу, үгүй юу. Энэ нь хүний хүчин зүйлээс хэр ангид юм бэ гэдэг

асуудлыг яриад байгаа шүү. Тийм учраас энэ тогтоолын бас хэлэлцүүлэг юмыг яахад энэ томъёоллыг нь зүгээр яамаар юм бэ дээ. Тийм Тэмүүлэн дарга бас нэг тайлбар өгөх үү.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн үг хэлнэ.

Г.Тэмүүлэн: Төсвийн байнгын хороо болоод төсөв дээр ажилласан ажлын хэсгийн зүгээс бид нар энэ тогтоолын төслийн хоёрын 9 дэх заалтыг нэмье гэдэг энэ асуудлыг оруулж ирсэн. Энэ асуудал маань өөрөө юу юм бэ гэхээр гол үндсэн суурь шалтгаан болбол сүүлийн үед төрийн өмчийн компаниудтай холбоотой, хяналттай холбоотой, ил тод байдалтай холбоотой гол үндсэн асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар цаашид ерөөсөө энэ төсвийнхөө нэгдмэл байдлыг хадгалахгүй болбол, төсвөөс гадуурх санхүүжилтүүдийг хориглохгүй болбол энэ уул уурхайн компаниудын энэ үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт олборлолт, энэ тээвэрлэлттэй холбоотой асуудлуудыг ч гэсэн ил тод хяналтад оруулж байлгахгүй бол болохгүй болчихоод байгаа. Тэгэхээр ерөөсөө энэ тогтолцоог хийе гэдэг үндсэн дээр энэ асуудал орж байгаа. Тэгэхээр ерөөсөө гол үндсэн логик асуудал нь бол ашигт малтмалыг олборлож байхдаа, боловсруулж байхдаа, тээвэрлэж байхдаа бүх шат дамжлагаууд дээр хийгдэж байгаа тэр асуудлууд дээр болбол бид нар үйл ажиллагаатай холбогдож байгаа бүх гэрээнүүдийг цахимжуулалтад ороод, цахим төлбөрийнх нь системд оруулъя. Ингээд үүнтэйгээ холбогдуулж энэ гэрээнүүд нь татварынхаа нэгдсэн системдээ ороод тэндээсээ татвараа төлдөг,

бүртгэл нь харагддаг, тоо, хэмжээ нь тодорхой байдаг, энэ асуудлыг л тавьж өгнө гэж байгаа юм. Тэгэхээр энэ болгон болбол төдийлөн юу гэдэг юм, яг саяын тэр олборлож байгаа, боловсруулж байгаа, тээвэрлэж байгаа ч гэдэг юм уу, энэ шат дамжлага болгон дээр бас төдийлөн ингэж чадахгүй байна гэдэг асуудал байгаа. Тэгэхээр ерөөсөө үүнийг бүртгэлжүүлж байж, цаашидаа бид нар энэ төрийн өмчийн уул уурхайн энэ томоохон компаниудын санхүү болоод энэ үйл ажиллагааны сахилга бат, хяналтыг нь л сайжруулна гэсэн зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлийг ЗГ-т УИХ-аас тогтоолоор өгч байна гэсэн үг.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар, Чимэдийн Хүрэлбаатар, Ширнэнбаньдын Адьшаа гишүүнээр тасаллаа. Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: УИХ-ын дарга аа, энд нэг санал бас оруулмаар байна. Энэ нэгэнт төрийн өмчит ААН-үүдийн тухай асуудал яригдаж байгаа учраас 12 гишүүн санаачлаад тантай ярьж, таны дэмжлэгээр энэ УИХ-д нэг тогтоол өргөн барьсан байгаа. Энэ юу гэвэл төрийн өмчит ААН-үүдийг нэгийг ч нэмж байгуулахгүй, болж байгааг нь юу ХК болгож хөрөнгийн бирж дээр гаргах мөн түүнчлэн давхар энэ стратегийн өмч бүхий ордуудыг гадна хувьцаа гаргасан байгаа бол Монгол Улсын өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн дагуу Монголд давхар хувьцааг нь гаргах, энэ хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах гэсэн төрийн өмчийн компаниудтай холбоотой энэ тогтоол явж байгаа. Тэгээд энэ яг төсвийн хуультай энэ тогтоолын хэрэгжилт шууд

холбоотой. Тэгэхээр энэ төсвийн хуулийг батлахад энэ тогтоолыг нэгэнт УИХ-д журмын дагуу өргөн баригдчихсан байж байгаа учраас хамт хэлэлцэж өгөөд энэ төсвийн хуулийн дагуу юу батлагдаад гарах юу хуулиудын жагсаалтад энэ тогтоолыг бас оруулж баталж өгөөч ээ гэдэг саналыг тавимаар байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Тэмүүлэн гишүүн ээ, энэ Дамдины Цогтбаатар гишүүний гаргасан саналыг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаараад нэгтгэн хэлэлцэх бололцоотой болбол бас агуулга нь энэ төрийн өмч энэ тэртэй нэг болбол ингээд үзэх хамтраад саналыг нь тусгачих чиглэл өгч байна. Гуравны хоёроор байдаг юм уу. Дэгийн тухай хуулийг чиглэл өгсний дагуу гээд ч юм уу, хуульд нийцүүлээд.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: ЗГ-аас энэ нүүрсний хулгайг цэгцлэх гээд оролдож байгаа. Үүнээс орж ирж байгаа орлогыг бүрэн авдаг болох гэж оролдож байгаа. Их хэмжээний нүүрс экспортод гардаг, түүнээс орж ирж байгаа мөнгө нь дутуу орж ирж байгаа. Тэгээд үнийг цэгцэлье гэж байгаа юм. Тэгээд цэгцлэх гол арга нь бол хүний хүчин зүйлээс бага хамаарсан энэ гааль, татварыг холбосон энэ татварын цахим системийг үйл ажиллагаанд бүртгэлийг оруулья гэж үзэж байгаа. Тэгээд энэ ажил бол 19 оноос хойшоо бол хэрэгжээд явж байгаа, импортоор орж ирж байгаа бараа бүгдийг нь бүртгэдэг, тэгээд дараа нь борлуулахад тэр нь бүртгэгдээд явдаг, ингээд хоорондоо ингээд

уялдаад явчихдаг ийм систем рүү оруулж ирж байгаа юм.

Одоо үүн дээрээ экспортыг нэмж оруулж ирж байгаа юм. Экспортыг нэмээд оруулчих юм болбол яах вэ гэвэл уурхайн амнаас гарсан нүүрс хилээр гарах хүртэлх бүх шатанд хаана байршиж байна, хэний аль гэрээгээр гэрээний нүүрс нь гарч байна уу гэдэг нь ил тод мэдэгддэг болоод явж байгаа. Үүнийг хийхгүй л юм болбол бид нар энэ нүүрсний хулгай гэдэгтэй бол тэмцэж чадахгүй ээ. Тэгэхээр Төсвийн байнгын хорооноос гарч ажиллаж байгаа энэ ажлын хэсэг Тэмүүлэн даргатай энэ ажлын хэсэг, Байнгын хороо бол энэ дээр чухал ач холбогдол өгч байгаа юм. ЗГ уул уурхайгаас орж ирж байгаа орлогоо бол бүрэн гүйцэд авдаг болох ёстой гэдэг ийм зүйлийн дагуу энэ ажлууд бас хийгдэж, тэнд өчнөөн өндөр дүнтэй хийгдсэн оптик гэрээнүүд үүнтэй холбоотой хууль бус, нүүрсний хулгайнууд очоод хууль хяналтын байгууллагууд дээр очоод дарагддаг, хуульчид дардаг, гар хөл нь болдог, энэ бүх зүйлийг л ил болгоё л гэж оролдож явж байгаа. Хэсэг хуульчдын бүлэг мафи болчихсон бий болчихсон байгаа шүү дээ. Их Хурлаас үүнийг шалгаж байгаа ажлын хэсэг бас байгаа. 5 сард байна уу, 6 сард бий болчихсон. Энэ ажлууд Их Хурал дээр удахгүй сонсгол нь орж ирнэ. Хаана хэн юун дээр, юу болоод байгааг нь хэний, ямар ангийн хүүхдүүд нь бас яваад байгаа, бүгд л орж ирэх байх. Тийм учраас энэ тогтоол бол гарах учиртай шүү, гарах учиртай.

Ингэж байж бид нар энэ нүүрс тойрсон асуудлууд дээр бид нар цэг тавьж, үүнийг ил тод болгох учиртай байгаа юм. Зөндөө л олон юмнууд ил

болж байгаа. Зүгээр энүүхэндээ хэлэхэд Хөгжлийн банкны асуудал бол 8 дахь жилдээ 7 жил явж байгаа, цаашидаа үргэлжлээд энэ 6, 7 жил энэ нүүрсний асуудал яригдана шүү. 2, 3 парламент дамжигдаж энэ асуудлууд яригдана. Тийм учраас бид нар үүнийг цэгцэлж горимд нь орох ёстой. Ил далд янз бүрийн эсэргүүцэл, гоё нэрээр, гоё нүүрээр энд саад болох гэсэн аливаа оролдлогыг Их Хурал маань харин таслан зогсоох учиртай. Энэ дээр дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа Их Хурлын гишүүддээ бол нэн талархалтай байгаа, дэмжиж байгаа Их Хурал. Ингэж байж бид нар үүний ар талд гарна гэдэгт бол огтхон эргэлзээгүй ээ. Тэгэхээр энэ асуудлуудыг төсөвтэй холбогдуулаад энэ гэрээний талаар хийгдсэн асуудлуудыг Их Хурал дээр Төсвийн байнгын хороон дээр ил тод ярьж гэж байгаа энэ саналыг маань Их Хурлын гишүүд маань дэмжиж өгөөрэй.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.
Дэмжсэн 2, дэмжээгүй 1 үг хэлсэн.

Ш.Адьяа: Энэ тогтоолыг болбол зайлиггүй баталж гаргах шаардлагатай байгаа юм. Өнөөдөр улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэлэлцэж байгаа энэ цаг үед хамгийн анхаарал татсан асуудал өнөөдөр энэ ТӨК-уудын засаглалын асуудал байгаа. Засаглалын асуудал. УИХ, ЗГ хамтарч улсын төсөв хэлэлцдэг бол ТӨК-уудын энэ уул уурхайн баялгаас олсон энэ хөрөнгө мөнгийг ТУЗ гээд нэг төрийн өмчийн хэдхэн хүн хэлэлцээд шийддэг энэ гажуудлыг засах анхны алхам гэж бодож байгаа юм. Энэ маш зөв зүйтэй, үүнийг шийдэх ёстой байсан. Энд болбол яах вэ, янз бүрийн байдлаар ярьж байна, тэгэхдээ энэ татварын албаар

дамжуулж, үүнийг хянахгүй бол юугаар дамжуулах юм. УИХ-аас бид нар ажлын хэсэг гаргаж хянах юм уу, энэ дээр бас дүгнэлт хийх ёстой. Бид нар өнөөдөр компанийн засаглалыг сайжруулж байж энэ ард түмний өмч хөрөнгө болсон, уул уурхайн бүтээгдэхүүнийг үр ашгийг тэр компанийн засаглалаар дамжуулж, тэнд хуримтлагдаж байгаа уул уурхайн баялгаас олсон хөрөнгө мөнгийг жинхэнэ зөв зүйтэй зарцуулах ёстой. Одоо энэ олон асуудал энд гарч ирж байна, оптек гэрээ, энэ Эрдэнэт энэ тэр гээд л зөндөө асуудал байгаа шүү дээ. Үүнийг бол зайлиггүй, энэ дэмжиж баталж гаргах ёстой. Энэ дээр бол үзэл бодлын зөрүүтэй хүмүүс байгаа юм байна. Тэгэхдээ энэ нийт улсынхаа эрх ашгийн төлөө бид тангараг өргөсөн хүмүүс ээ, бид өнөөдөр Цахим Монгол гэдэг хөтөлбөрийг Монгол Улсын Их Хурлаар баталсан аливаа бүх зүйлийг цахимжуулж байж, ил тод байж байж, энэ авлигал, хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үүд хаалга чинь нээгдэнэ шүү гэдгийг энд зориуд хэлье.

Энэ асуудлыг бол Төсвийн байнгын хороон дээр ч ярьсан, үүнийг би дахиж дэмжиж байгааг энд илэрхийлж байгаагаа үүгээр уламжилж байна.

Г.Занданшатар:

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн
үг хэлэн.

Х.Булгантуяа: Энэ төсвийг дагаад хамгийн их ярьж байгаа нь сүүлийн үеийн сэдэв бол энэ оптек гэрээг энэ худалдан авах, борлуулах гэрээг ил тод болгоё оо гэсэн. Одоо яг ил тод болгоё гэхээр яаж ил тод болгохоо ингээд бүгдээрээ яриад тэгээд хаана үүнийг бүртгэх вэ, хаана

ил тод болгох вэ? Хэвлээд эс үгүй бол энэ Сүхбаатарын талбайнхаа хажууд самбар дээр дээр үед тарьдаг шиг хэвлээд тавих юм уу. Ард түмэн минь ирж танилцаарай гээд. Мэдээж энэ чинь цахимаар хаа нэгэн газар тавигдаж таар аа. Эрхбиш одоо энэ татварын систем нь арай илүү хөгжсөн иргэд олон нийтэд бид нар бас цахим болно гээд цахим үндэстэн болно гээд ингээд зарласан юм чинь үүнтэйгээ холбоотойгоор л бид нар тавьж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Эс үгүй бол парламент.мн дээрээ тавих юм уу, яг хаана тавих юм. Нэгэнт хэрвээ энэ татварын нэгдсэн систем ч ер нь энэ цахим юмандаа хэрвээ итгэж чадахгүй байгаа юм бол бид нар бүхэл бүтэн цахим яам байгуулаад энэ явж байгаа ахиц дэвшил тэгээд хэнд итгэх вэ, юунд итгэх вэ. Тэгээд хэрвээ цахим дээр байдаг юм уу, ил тод болгохгүй бол ямар өнөөдөр санцитай ямар арга хэмжээ авах юм гэдэг нь бас тодорхойгүй шүү дээ.

Тэгэхээр бүтээгдэхүүнээ экспортод гаргаж чадахгүй гэхээр эрх биш нөгөө компани нь өөрөө бүтээгдэхүүнээ гаргахын тулд үгүй ээ, манайхыг бүртгээч ээ гээд албан бичиг өгөөд хэрэв бүрдэхгүй байгаа бол эрх биш УИХ-д байдаг юм уу, холбогдох байгууллагад нь хандах байлгүй дээ. Тэгэхээр энэ нь миний ойлгож байгаагаар нэгдүгээрт татварын нэгдсэн системд бүртгүүлнэ ээ, хэрвээ үүнд итгэхгүй байгаа бол тэгвэл өөр ямар нэгэн бид нар гарц гаргалгааг гаргах ёстой. Бид нар нөгөө уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиа батлаагүй байгаа учраас бид нар бас үнэнийг хэлэхэд энэ бас хэцүү байх шиг байна, Жавхлан сайд энэ дээр хариулт өгөх байх. Тэгээд бүртгүүлээгүй байвал яах

юм бэ гэдэг нь бас тодорхойгүй байгаа учраас үүнийг оруулж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ, бүртгүүлээгүй тохиолдолд бүтээгдэхүүнийг экспортод гаргахгүй ээ гээд. Тэгээд эрхбиш энэ чинь татварын дарга нь үүнийг дунд нь эрэмбэлээд эрхбиш сууж байхгүй байлгүй дээ, одоо бид нар нэг ийм юмандаа 21 дүгээр зуунд итгэх цаг нь болсон байлгүй дээ. Цахим системдээ и-монгол дээр бүх хүмүүсийнхээ мэдээллийг аваад хийчихсэн, бүх иргэдээ цахимаар та бүхэн маань мэдээллээ аваарай бид нар ил тод төр болж байгаа шүү гэсэн мөртөө үүндээ итгэж чадахгүй байна гэхээр ухралт л болох гээд байна л даа. Хэрвээ ингэх юм бол энэ оптек гэрээ юмнууд ил болохгүй ээ л гэсэн үг.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа.

6 хүн үг хэлсэн. Санал хураалт явуулъя. Тэгээд шаардлагатай бол яах вэ, тэр цахим ил тод байдал, бүртгүүлээгүй бол экспортод гаргахгүй гэдгээ заавал бүртгүүлж байж экспортод гаргах гэдэг үгээр сольдог ч юм уу, жоохон найруулгын засвар хийнэ биз, тийм ээ.

Ингээд санал хураалт явуулъя. 35 гишүүн дэмжсн 64,8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ер нь тэр ил тод байдлыг хангах чинь л хамгийн сайн хяналтын систем байгаа шүү.

6. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 10 дахь дэд заалт нэмэх:

“10/Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн өр төлбөрийг

2023 оны төсвийн жилд өр төлбөр үүсгэхгүйгээр барагдуулах арга хэмжээ авах.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 64,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хороо, аль дээр нь, ингэе. Одоо дэмжээгүй саналыг уншихаар та түүн дээр холбогдуулаад үг хэлчих.

Энэ тогтоол л явж байна. Дэмжсэн саналуудаар санал хураалт дууссан, одоо тогтоолын Төсвийн байнгын хороо дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 11 дэх дэд заалт нэмэх:

“11/Орон нутагт нислэг үйлдэж байгаа авиа компанид олгож байгаа татаасыг тухайн аймагт байнга оршин суугч зорчин явагч иргэдийн тийзийн үнээс хөнгөлөх зарчмаар өөрчлөн шийдвэрлэхийг Засгийн газарт даалгах.”. Санал гаргасан УИХ-ын гишүүн Шатарбалын Раднаасэд нарын 19-ийн гишүүн гаргасан байна.

Хамгийн түрүүнд Аубакир гишүүн гар өргөсөн. Батлут, Раднаасэд, Адьшаа, Болорчулуун гишүүнээр тасаллаа.

Орно оо, тайван байж бай л даа. Тилеуханы Аубакир гишүүн үг хэлнэ.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ алслагдсан аймгуудад бас л маш чухал асуудал, хүндрэл учруулаад байгаа нэг ийм асуудал байсан юм. Энэ бол

агаарын тээврийн асуудал. Үндсэндээ автобусаар буюу хувийн машинаар гарахад 26-30 цаг явж ирдэг, зам хол, тийм учраас алслагдсан аймгууд, Завханаас цаашаа Увс, Ховд, Баян-Өлгий гэдэг аймгуудад амьдарч байгаа иргэдэд Улаанбаатар нийслэлд ирэхэд маш их хүндрэл тулгардаг юм. Хол амьдардаг хүмүүс болбол мэдэж байгаа, бид болбол энэ асуудлыг удаа дараа ярьсан. Онгоцны тийз үнэтэй байна, Баян-Өлгий, Ховд руу нисээд ирэх юм, үндсэндээ Сөүл ороод ирэхээс илүү үнэтэй, 2 талдаа яваад ирэхэд л 2 сая орчим төгрөг болдог, тэр болгон иргэд зорчигчид зорчоод байж чаддаггүй нэг ийм асуудал үүсээд байсан юм. Үүнийг зөрүүг нь навигацын мөнгөнөөс улсын төсвөөс гаргачих нэг ийм бололцоо байгаад байгаа юм.

Энэ маань нэг талдаа алслагдсан орон нутгийн иргэдийн ахуй амьдралд нэмэр болж байгаа, нөгөө талдаа бас авиа компаниудаа бид нар хөл дээр нь босгох боломжтой ийм чухал заалт л даа. Тийм учраас сүүлийн үед бас ярьж байна, манай ЗГ-аас хотоос хөдөө рүү шилжих хөдөлгөөнийг дэмжиж байгаа, Улаанбаатар хотын түгжрэл, нягтралтай холбоотой, хөдөө орон нутаг руу явж байгаа иргэдэд ямар туслалцаа дэмжлэг байж болох вэ гэдэг тал талын ийм ач холбогдолтой ийм заалт байгаа юм. Тийм учраас энэ Байнгын хорооны дэмжээгүй саналыг манай гишүүд маань аппаратдаа гараа хүргэхгүй байж байгаад нэг дэмжээд өгөөч ээ. Энэ алс хол амьдарч байгаа иргэдэд маш их тулгамдсан асуудал. Улаанбаатар хот ороод ирэхэд л 2 сая төгрөгөөр явж ирнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ. Энэ чинь гадаад улс Сөүл, Бусан руу яваад ирэхэд 1,3 сая төгрөг

хүрэхгүй байж байдаг, гэтэл Ховд ороод ирэхэд 2 сая орчим төгрөгөөр, Баян-Өлгий аймаг ороод ирэхэд 2 сая төгрөгөөр яваад ирнэ гэдэг юу гэсэн үг вэ.

Тийм учраас энэхүү Байнгын хорооны дэмжээгүй саналыг гишүүд маань гар хүрэхгүй байж байгаад дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Би энэ саналыг бол дэмжихгүй байгаа юм. Өнөөдөр татаас өгдөг бодлого гэж байж болохгүй ээ. Хамгийн муу менежер л татаас өгдөг байна шүү. Төр өөрөө хамгийн муу менежер байна гэдэг тэр нэрээ ингээж дархалж болохгүй, бид нарт бол бас боломжууд байгаа. Монгол УИХ, ЗГ өөрөө онгоцны шатахууны үнийг бууруулах чиглэлээр олон талт арга хэмжээ авах гээд ажиллаж байгаа. Эрчис ойл компани гээд гаргаж байна. Ингээд ирэх юм бол онгоцны шатахууны үнэ гуч гаруй хувиар буурах боломжтой гэж байгаа юм. Онгоцны шатахууны үнэ тийзний үнэд маш чухал нөлөөлөл үзүүлж байгаа. Тэгэхээр бид шатахууныхаа үнийг бууруулж чадах юм бол тийзний үнэ мөн дагаад бууна.

Хоёрдугаарт нь, агаарын тээврийнхээ либералчлалыг хурдан хийх хэрэгтэй, ингэж чадаж гэмээ нь бид нар энэ тийзнийхээ үнийг бууруулах болохоос биш татаас өгөх зарчмаар бууруулна гэдэг бол хамгийн муу менежерийн хийх ажил шүү.

Дээрээс нь аймагт нислэг нэмэгдэх тусам тэр болгонд татаас өгөх болох уу. Өнөөдөр эдийн засгийн

нөхцөл байдал хүндэрчихсэн байна, цаашидаа хэзээ эдийн засаг сэргэх нь ойлгомжгүй байгаа шүү дээ. Харин тийм их мөнгөтэй байгаад байгаа юм бол энэ мөнгөө хүүхдийн төлөө зарцуулах хэрэгтэй, хүүхдийн хоолны мөнгө ямар байгаа билээ, тэр хүүхдүүд идэж байгаа хоол нь ямар байгаа билээ, өнөөдөр ирээдүйн сан дээр ямар байдалтай байгаа билээ, хүүхдийн мөнгөн дээр ямар асуудлууд гарч байгаа билээ гээд олон асуудлууд байгаа. Энэ бүхнийгээ харах хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд төр өөрөө татаас өгдөг тийм бодлоготой байж болохгүй шүү. Энэ бол муу менежер гэсэн үг, тийм учраас өөр арга барилаар, ажлын арга барилаар, тэр бензиний шатахууны үнийг бууруулах замаар, либералчлалыг маш хурдтай хийж хэрэгжүүлэх тал дээр арга хэмжээ авах хэрэгтэй, салбарын сайд нь. Ингээж байж энэ чинь ажил хэрэг болно, илүү боломжууд бүрдэнэ гэж харж байна шүү.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ ийм юм. Энэ нэг 9 аймгийн зовлон байхгүй юу. Өвддөг, зовдог, онгоцоор явах болдог сая, сая 800, сая 200, 300-г төлдөг ийм л зовлон байгаа юм. Энэ хөтөлбөр нөхөн олговор олгох энэ хөтөлбөр хэрэгжих юм болбол Улаангом хот руу гэхэд Увс руу гэхэд 253000, Завхан руу 202000, Мөрөн рүү 175, Чойбалсан руу 175, Даланзадгад руу 175, Өмнөговь руу 141, Алтай руу 202, Ховд руу 253 ч гэдэг юм уу энэ бол одоо бол авиа компаниуд ийм өөрөө үнэ тогтоодог, суудал хангалтгүй болохоор бүр нисэхээ больдог. Тэгээд ерөөсөө захиалгат нислэг рүү орчихдог. Нийт нислэгийнх нь 80 хувь

нь зөвхөн уул уурхайн компаниудад ажиллаж байгаа газруудын захиалгатай ажлыг явагддаг. Тэнд амьдарч байгаа иргэд чинь настай хүн байна, өвчтэй зовлонтой хүн байна, нялх хүүхэдтэй хүн байна, ирэх очих шаардлага юм байдаг. Энэ хэрвээ ингээд буугаад ирэх юм болбол иргэд нисдэг болно. Иргэд нисэхийнхээ хэрээр тэр хоног хугацаатай төлөвлөгөөт нислэгүүд нь явагддаг болно. Тэгэх юм болбол энэ өөрөө эргээд энэ одоо шаардагдаж байгаа 9,8 тэрбум төгрөг болбол яваандаа үүнийг өөр авиа компаниуд өөрсдөө өрсөлдөөнийхөө журмаар бий болгоод явах боломжтой болчихоод байгаа байхгүй юу. Үүнийг тогтоогоогүйгээс болоод энэ авиа компаниуд чинь өөрсдөө ерөөсөө өрсөлдөөнтэй газар луу, уул уурхайн компаниудтай гэрээлж нисээд нэг ийм нөхцөл байдал үүсээд байгаа юм. Энэ 2019 онд хэрэгжиж байсан хөтөлбөр өө, ИНЕГ дээр өөр дээр нь. Гэвч энэ нөхцөл байдал нь татаасын юунаас болоод шийдвэрлэж өгөөгүйгээс болоод ингээд зогсчихсон юм байгаа юм. Үүнийг хийсний нэг төсөв дээр би бол нэг их дарамт болохгүй, угаасаа үүний дараагийн санал хураалт дээр энэ мөнгө төгрөг маань орчихсон явж байгаа. Энэ төсвийн хуулийн юун дээр хэлэлцэх юман дээр. Гол нь энэ эрх зүйн актын үндэслэлийг нь энэ тогтоолоор бий болгоод өгчих юм болбол бидэнд хэрэгтэй байгаа юм л гэж тийм л зүйл байгаа юм.

Түүнээс Говь-Алтай руу ч гэдэг юм уу, Ховд руу, Увс руу, Завхан руу галт тэрэг явахгүй байна шүү дээ, Батлут гишүүн ээ, галт тэрэг явахгүй байна. Бид нар энэ төвлөрлийг сааруулъя гэж байгаа юм. Үнэхээр орон нутагт аятай тухтай амьдарч, цаг шаардлагатай үед

Улаанбаатар хот руугаа хямд зардлаар ирчихдэг байвал тэнд хүн байгаад л байна биз дээ. Тэгэхгүй гэвэл энэ Улаанбаатартаа бүгдээрээ бөөгнөрөөд, ингээд сая сая төгрөгөөр төлж явснаас эндээ амьдаръя гээд ингээд түгжрээд л байж байя л даа.

Нөгөө шинэ сэргэлтийн бодлого, төвлөрлийг сааруулах бодлого, энэ нөгөө хөдөөг хөгжсүүлье гэдэг энэ бодлогууд чинь энд үүний цаана үүнээс эхлэх гээд байгаа байхгүй юу. Тийм учраас үүнийг та бүхэн минь дэмжээд оруулаад өгөөч ээ л гэж хэлээд байх юм.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: УИХ-ын 19 гишүүн энэ тогтоолын төслийг бас өргөн барьж байгаа юм. Та нар бас энд хүндэтгэлтэй хандаад энэ асуудлыг дэмжиж өгөхийг та бүгдээс хүсэж байна. Өнөөдөр Монголд эдийн засгийн хүндрэл болж, шатахуун тослох материалын үнэ нэмэгдсэнээс болоод бүх зүйлийн үнэ нэмэгдсэн, түүний дотор тээврийн хэрэгслийн үнэ хани болбол урд хожид байгаагүйгээр нэмэгдсэн. Баруун аймгууд руу нислэг хийдэг авиа компаниуд 2, 3 жилийнхээ өмнөх үнээс даруй 3 дахин үнээ нэмсэн байгаа. Энэ үнэхээр бэрхшээлтэй асуудал болсон. Үүнийг Монголын төр анхаарах ёстой, Монголын төр анхаарах ёстой. Энэ бензин шатахууны эрсдэл, эдийн засгийн хүндрэлээс ард иргэдээ хамгаалах нь Монгол төрийн үүрэг, түүний дотор өнөөдөр УИХ, ЗГ-аас дэвшүүлж байгаа төвлөрлийг сааруулах, хөдөө орон нутагт ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх энэ төр засгийн бодлоготой энэ бол нийцэж байгаа

юм. Тийм учраас энэ баруун аймгуудад энэ нислэг үйлдэж байгаа авиа компаниудын нислэгийг нь энэ татаас олгох асуудлыг та бүгд шийдэж өгмөөр байна. Энэ болбол зайлшгүй хийгдэх ёстой ажлуудын нэг ээ. Энэ алслагдсан аймгуудад авиа компаниудад татаас олгосноор, бас ард түмний амьдралыг жсоохон ч гэсэн боломжоор олгох ийм нөхцөл байдал бүрдүүлнэ. Энд манай Их Хурлын гишүүд бас анхааралтай бодитой бас хандаж энэ асуудлыг дэмжиж өгөхийг би хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Төвлөрлийг бууруулах санаачилга гарч байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Энэ орон нутагт онгоц ниснэ гэдэг асуудал болбол үнэхээр ус агаар шиг хэрэгтэй байна. Үүнийг тэгэхдээ татаас өгч байгаа хэлбэрээр шийдэхгүй шүү, үүнийг болбол зүгээр шийдэл гаргаж ажиллахыг ЗГ, ЗТЯ-нд даалгаж байгаа л асуудал, тийм. Үүнийг болбол бас ЗТЯ нэг учрыг нь олчихно гэж байна. Навигацын орлого ирэх жил бол маш өснө гэж байна, тэнд түүнээсээ яадаг ч юм уу, өөр нэг байдлаар ингээд зохицуулах байх гээд. Тэгэхгүй бол орон нутагт амьдарснаараа ард иргэд үнэхээр хохирч байна. Нэг өвчин зовлонтой хүмүүс, аваар осолд орсон хүмүүс 10 гаран сая төгрөг төлөөд хувийн онгоц хөлсөж ирж байна шүү дээ. Тэгэхээр бас нөгөө нэг бэртэгчин байж болохгүй ээ, бас энэ төв орчмын аймгийнхан энэ тэр бол бас нэг манайд хамаагүй гэсэн байдлаар хандаж болохгүй шүү гэдгийг бас хэлмээр байна.

Үнэхээр энэ 2023 оныг Монголд зочлох жил болгосон. Жуулчид энэ онгоц явахгүй бол хөдөө орон нутагт жуулчилна гэж байхгүй шүү. Улаанбаатарт ирээд л буцдаггүй юм болбол. Тэр аль алия бодоод нийслэлийн бөглөрөл, орон нутагт амьдрах хүмүүсээ хүндлээд бас энэ онгоцыг явуулах нь юу юунаас чухал гэдгийг хэлмээр байна.

Хэн нь тэгээд амиа боддог юм, бэртэгчин, хэн нь бас нэг орон нутгийнхаа ард иргэдийг боддогийг харах байх.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууссан.

Сангийн сайд дэмжээгүй үг хэлье. Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Болорчулуун гишүүнээ Сангийн сайд нь ганц үг хэлээдэхье.

Энэ дээр жаахан ойлголтын зөрүүнүүд байх шиг байна. Холын аймгуудын гишүүдийнхээ зовлонг ойлгож байна. Мэдээж тойрогтой холбоотой ийм асуудлууд, сонгогчидтой холбоотой өргөдөл гомдол зөндөө л ирж байгаа байх. Гэхдээ үүнийг тэвчих хэрэгтэй шүү, навигацийн орлогоос гэдэг ч буруу, Бямбацогт сайд үүнийгээ эргэж хараарай, навигацийн орлогоос ингээд салбарт орж байгаа жсоохон жсоохон орлогуудаа, тэгвэл Сангийн сайд гаалийнхаа орлогыг, татварынхаа орлогыг би мэдээд ийш нь зарцуулъя гэх үү. Төрийн өмчийн төрийн байгууллагуудын бүх орлогууд нэг саванд ороод тэндээсээ хуваарилагддаг төсвийн өөрийнх нь суурь алтан систем, алтан дүрэм шүү. Тэгээд навигацын ч орлого бай,

хаанахын ч орлого бай, бүгд төсвийн орлого болно. Тэндээсээ төсвийн хуваарилалтаа хийдэг тэр системээрээ л явна, нэгд.

2-т, энэ агаарын тээвэрт, ялангуяа орон нутгийн зорчигч тээвэрт энэ татаас өгдөг байж огт болохгүй. Энэ ерөөсөө буруу зарчим, одоо бид нар шөнийн тариф руугаа орчхоод буцаад гарч чадахгүй байгаа шүү, буцаад гарч чадахгүй байгаа. Энэ мэтчилэн маш олон татаас, тусламж, буцалтгүй тусламж гээд энэ олон зүйлүүдээсээ бид нар салж ядаж байхад зөрөөд ийм юм руу орох ийм зүйл ерөөсөө огт байж болохгүй. Тийм учраас энэ дэмжээгүйг дэмжих ёстой юм байгаа юм, судлаад ч хэрэггүй.

Г.Занданшатар: Баярсайхан гишүүн ээ, дэмжсэн гишүүн 3 хэлчихсэн. Ингээд боллоо.

Одоо санал хураалт явуулъя.
Санал хураалт.

Санал хураалтад 55 гишүүн оролцож, 16 гишүүн дэмжиж, 39 гишүүн татгалзаж энэ санал дэмжигдлээ.

Одоо найруулгын саналын өмнө УИХ-ын гишүүн, МАН-ын бүлгийн дарга. Байж байгаарай, хоёрхон санал, түр байж байгаарай. Найруулгын саналаар санал хураана.

1. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ саналтай холбогдуулж УИХ-ын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн МАН-ын бүлгийн дарга уг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Дарга аа, би 2 санал хэлэх гээд байгаа юм, чиглэл өгүүлэх.

Нэгд нь, энэ саяын 11 дүгээр дэд заалтыг яах вэ, дэмжигдчихлээ, бид гишүүдээ хүндэтгэлгүй яах вэ. Гэхдээ үүнийг авиа компаниас татаас авна гэж болохгүй. Зүгээр үүнийг ЗГ хууль дүрэм, журмын хүрээндээ алслагдсан аймгуудын онгоцны тиизийг бууруулах чиглэлийн арга хэмжээ авч хэрэгжүүл гэсэн хэлбэрээр оруулах нь зөв байх гэж бодож байна, тийм. Тийм учраас үүнийг ингэж найруулах, ийм хэлбэр лүү оруулж найруулах чиглэлийг Төсвийн байнгын хороонд өгөх хэрэгтэй байна.

Хоёрдугаарт нь, энэ цэцэрлэгийн хүүхдийн хүртээмжтэй холбоотой асуудлаар дарга аа, нэг чиглэл өгчихмөөр байгаа юм. Энэ юун дээр уначихсан юм байна лээ, ажлын хэсэгтээ. Байнгын хороо дээр яригдаагүй, би санал гаргах гэж байгаад нөгөө батлагдаад явчихсан байсан юм. Энэ 12 дахь заалт болгоод хүүхдийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 22 онд хэрэгжүүлсэн ажлыг улсын хэмжээнд үргэлжлүүлэн зохион байгуулах гэсэн агуулгатай юм. Өнгөрсөн жилийнх чинь нийслэлийнх дээр явчихсан юм. Тэгээд нөгөө олон хүн амтай, хүүхдийн цэцэрлэг нь дутуу ийм орон нутгууд байгаа. Үүнийг хувьсал зардлынхаа хүрээнд манай Боловсролын сайд бол боломжтой гэж байгаа юм. Тэгэхээр ийм хэлбэр рүү оруулах гээд байгаа юм, дарга аа.

Хүүхдийн цэцэрлэгийн хуртээмжийг нэмэгдүүлэх 22 онд хэрэгжүүлсэн ажлыг улсын хэмжээнд үргэлжлүүлэн зохион байгуулах, цэцэрлэгийн багш мэргэжлээр суралцах, суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, сургалцангаа ажиллах боломж бүрдүүлэх, туслах багш нарыг бэлтгэх, малчдын болон тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдэд зориулсан хувилбар, сургалтын үйлчилгээний орчныг сайжруулах гэсэн ийм чиглэлийг өгчихвөл Боловсролын сайд ингээд зохион байгуулаад явчих боломжтой юм байна лээ.

Тийм учраас үүнийг та бас дараагийн хэлэлцүүлэг дээр Төсвийн байнгын хороо үүнийг авч үзэж хэлэлцээрэй гэсэн ийм 2 чиглэлийг танаар өгүүлмээр байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна.

Тэгээд Агар-Эрдэнэ дарга аа, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалттай нийцүүлж эцсийн хэлэлцүүлгээр эдгээр саналыг хуулийн дагуу хэлэлцэхийг ажлын хэсэгтээ, бас Төсвийн байнгын хорооны чиглэл болгож байна. Тэгэхдээ үүнийгээ яах вэ, дэгээр гуравны хоёроор босгох нь уу, аль эсвэл яах нь уу, тэрийгээ.

Одоо санал хураалт явуулна. Найруулгын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Найруулгыг дэмжье гэж байгаа шүү. Цэцэрлэгийг ярьж байгаа энэ Цогтбаатар гишүүний ярьж байгаа саналуудыг л эцсийн хэлэлцүүлэг дээр гуравны хоёроор.

60,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Ингээд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

18.05 цаг

Дараагийн асуудалд орно.

Дөрөв. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Төслүүдийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэн танилцуулна.

18 цаг болчихсон учраас өнөөдөр төсвийн төслийнхөө 2 хэлэлцүүлгийг дуустал үргэлжлүүлэн хуралдах саналтай байна, гишүүд дэмжиж байна уу. Олонх нь дэмжиж байгаа учраас үргэлжлүүлэн хуралдахаар шийдвэрлэлээ.

Г.Тэмүүлэн: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн

2023 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дэх хэлэлцүүлгийг УИХ-ын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 6, 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

УИХ-ын даргын 2022 оны 151 дүгээр захирамжаар төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг УИХ-ын гишүүн миний бие ахлан, ажлын хэсгийг байгуулан ажиллуулсан бөгөөд тус ажлын хэсгээс төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажил хэсгийг байгуулан ажиллаж, саналуудыг нэгтгэн хэлэлцлээ.

УИХ-ын бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд санал тус бүрээр санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүй эсэхээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн. Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 2 болон 3-ны өдрүүдийнхээ хуралдаанаараа төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн бусад Байнгын хороо төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан аваагүй эсэхээр бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлтгэсэн.

Түүнчлэн УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс төсвийн төслийн 2 дахь

хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3, 29.4-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, гарсан дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёолыг нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан болно.

Төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хорооноос ЗГ-ын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар дараах зарчмыг баримталсныг нийт хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1 дүгээрт, төсвийн тэнцэл сайжруулахтай холбогдуулан төсвийн алдагдлыг бууруулах үүднээс төсвийн орлогыг 130 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, ДНБ-д эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 0,23 хувиар сайжруулахаар санал бэлтгэлээ.

2. Эдийн засгийн хүндрэлтэй цаг үед төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагааны зардал, ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний зардал, гадаад зээл, тусламжтай холбоотой зарим шаардлагагүй зардлыг бууруулж, 170 орчим тэрбум төгрөгийг төсвийн хяналт бий болгох саналыг бэлтгэв.

3. Зарим шаардлагагүй зарлагыг бууруулсан эх үүсвэрээр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авахаар санал бэлтгэлээ. Үүнд, тухайлбал, улсын хэмжээнд гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн зардалд

шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, ойн хортон шавжтай тэмцэх ажилд шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, хүүхэд хамгаалах арга хэмжээ болон “өнөр бүл” хүүхдийн төвийн урсгал зардал, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдал зэрэг нийгэм, эдийн засагт үүссэн хүндрэлтэй асуудлуудыг зохицуулахаар санал бэлтгэн танилцуулж байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг 2 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: УИХ дахь АН-ын бүлгийн санал, дүгнэлтийг бүлгийн дарга, Одонгийн Цогтгэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Монгол УИХ-ын дарга, УИХ-ын эрхэм гишүүд ээ, Дэлхий дахины улс төр, эдийн засгийн нөхцөл байдал амаргүй ээдрээтэй цаг үед 2023 оны Монгол Улсын нэгдсэн төсвийг хэлэлцэж байна. ОУВС, Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын санхүүгийн байгууллагууд дэлхийн улс орнуудад төсвийн бодлогоо

чангаруулж, орлогоо зөв төсөөлж, хэмнэлттэй зардлаа танасан алдагдалгүй төсөв батлахыг анхааруулан зөвлөж байна. Гэвч ЗГ-аас тэрхүү анхааруулгыг үл тоон бодит бус төсөөлөлтэй, алдагдал өндөртэй төсвийн төслийг оруулж ирснийг хариуцлагагүй үйлдэл гэж АН-ын бүлэг үзэж байна. Дөрөвхөн сарын өмнө бас хуульчлан баталсан төсвийн голлох үзүүлэлтүүд, Төсвийн тогтвортой байдлын, Төсвийн тухай хуулийн заалтуудыг зөрчсөн төсөл УИХ-д өргөн барьж хэлэлцэгдэж байна.

Тогтвортой байх хуулийг хамгийн тогтворгүй болгож, үүндээ огт хариуцлага хүлээдэггүй явдал сүүлийн жилүүдэд энгийн үзэгдэл боллоо. Мөн төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, эрэмбэ, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын зарчим алдагдсан жилүүд өнгөрч байна. Гуравхан жилийн өмнө Монгол Улс 9 их наядын төсөвтэй байсан, харин сүүлийн 3 жилд зөвхөн төсвийн алдагдал нь 10 их наяд хүрлээ, энэ хэмжээгээр өр нэмэгдлээ, ирэх жилийн төсөв 1,5 их наядын алдагдалтай гэж ярьж байна. Гэвч дээр нэмэгдэх далд, гэвч энэ нь дээр нь далд нуугдмал алдагдлууд ихээр нэмэгдэнэ.

Ирээдүйн өв санд хуримтлагдах ёстой 1,5 их наяд төгрөг буюу зарласан алдагдалтай тэнцүү хэмжээний алдагдлыг нуун задалж бас оруулж ирж байна. Хэмнэлтийн хэмээх хууль хэрэгжсэнгүй, төсвийн алдагдал дээрээ нэмээд 2 их наядаар төсөв тэлж байна. Дээр нь экспортлох нүүрсний хэмжээг энэ жилээс 2 дахин их буюу 36000000 тонн гэж тооцсоны, зэсийн үнийг олон улсын санхүүгийн

байгууллагуудын төсөөллөөс хэт өндрөөр буюу тонныг нь 8400 доллароор төсөөлсний зэрэг болзошгүй нуугдмал алдагдлууд бас цаана нь нэмэгдэнэ. Энэ бүхнийг оруулж тооцвол ирэх оны төсвийн алдагдал бодитойгоороо 5-6 их наяд хүрнэ.

Улсын төсвийн сүүлийн 4 жилийн алдагдал 15 их наяд төгрөгөөр хэмжигдэх нь ээ. Ийм хэмжээний хөрөнгө нь Монгол Улсын иргэн бүрд 5 сая төгрөг ногдох, мөн гэр хорооллын бүх айлыг тохилог орон сууцанд оруулах хэмжээний ийм боломжийн тухай яриа.

Тооцоо судалгаагүй төрийн шийдвэрүүд цаашид үнэ өсөх, хани сулрах, гадаад валютын нөөц багасах, зээлийн хүү нэмэгдэх, зээлжих зэрэглэл буурах зэрэг олон муу үр дагаврыг дагуулах нь дамжиггүй ээ. ОУВС Монгол Улсын 2023 оны төлөвийг сэргэлт эмзэг, эрсдэл их гэж дүгнэсэн. Гэтэл улсын эрх ашгаас намын эрх ашгийг өндөрт эрэмбэлсэн эрх баригчид ирэх оны төсвийн төсөлд орлогоо хэт зохиомлоор төсөөлж байна. Нийт татварын орлого 18 онд 6,2 их наяд байж, 23 онд 17 их наяд болж, 4 жилийн дотор татвараас олох орлогыг 3 дахин нэмүүлэхээр тооцож байна. Эдийн засаг 3 дахин өссөн бил үү. Ингэснээр бүтэн 3 жил ковидын хатуу хөл хорионд үйл ажиллагаа нь тасалдсан ААН-үүд иргэдээс их хэмжээний татвар авах замаар төсвийн орлогоо нэмэгдүүлэхээр тооцсон нь иргэд, бизнесүүдэд нэн халтай бодлого болох нь ээ.

АН-ын бүлгийн гишүүд яагаад төсвийн алдагдал, тэлэлтэд анхаарал хандуулан, онцгойлон бас эсэргүүцээд

байна вэ. Эсэргүүцэх олон шалтгаан байгаа ч онцгойлон 4 зүйлийг бас дурдъя.

Нэгдүгээрт нь, төсөв тэлж, төсвийн алдагдал ихэссэнээр ирэх 2023 онд Монгол Улс гадаад төлбөр тооцоогоо төлж чадахгүй дампуурал буюу депольт зарлах бодит эрсдэл улам нэмэгдэж байна. 4 тэрбум доллар хүртэлх өр своп хэлцлийг төлөх эдийн засгийн чадамж, валютын нөөц манайд байхгүй ээ. Хөрөнгө оруулагчдын Монголын бондод итгэх итгэл улам унаж, гадаад зах зээлээс дахин зээл авч, өрийг өрөөр дарах боломжгүй болсон нь бас харагдаж байна.

Хоёрдугаарт нь, төсөв тэлж, төсвийн алдагдал ихэссэнээр Монголбанк мөнгөний бодлогоо хатууруулж, 2023 онд иргэд бизнест мөнгө зээл очихгүй нь ээ, очсон мөнгө нь илүү өндөр хүүтэй болж, эдийн засаг хаалтад болбол борц болох аюул ирж байна.

Гуравдугаарт нь, төсөв тэлж, төсвийн алдагдал ихэссэнээр эдийн засаг дахь төрийн оролцоо улам ихсэж, авлигажсан, үр ашиггүй тогтолцоог улам өдөөнө өв. Төсөв сүүлийн 4 жилд 9 их наядаас 20 их наяд болж 2 дахин томорлоо. Олон олон Таван толгойн нууц гэрээ шиг олон Хөгжлийн банкнууд шиг төсөв, төр томорсноор дараагийн шинэ шинэ дуулианууд үргэлжлэн мэдээж дэлгэгдэнэ ээ.

Дөрөвдүгээрт нь, төсөв тэлж, төсвийн алдагдал эхэлснээр төгрөгийн хани унаж, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт ирэх онд ч үргэлжлэхээр болж байна. Монголбанк мөнгөний бодлогоо

чангалж, бизнесүүдийг борцолж байгаа энэ үед ЗГ төсвөө тэлж, алдагдлаа нэмэгдүүлж, эсрэг тэсрэг ажиллаж байгаа нь эдийн засагчдын гайхширлыг бас төрүүлж байна.

Нэгдсэн улсын нэгдсэн эдийн засгийн бодлого хаана нь явна вэ. Ийм бодлогын алдааг улсаараа дампуурсан улсуудын олон жишээн дээрээс бид нар бас харж болно оо.

Өнөөгийн Монголын эдийн засагт төрийн оролцоо давамгайлж төржсөн, түүхий эдэд тулгуурласан төрөлжилтгүй, эдийн засгийн загвар луу улам хурднаар чиглэсээр байна. Түүхий эдийн үнэ үргэлж савладаг, манай Засгийн газрууд үнэ өсөхөөр зарцуулаад үнэ буурахаар зээлдэг, үндсэн ганицхан арга барилтай. Өсөлт бууралтыг ирээдүйдээ хадгалах замаар дунджилдаг олон улсын сайн туршилагыг оруулж ирсэн ч тэр Ирээдүйн өв сан маань ЗГ-ын төсвийн алдагдлыг нөхдөг хавсарга данс болж хувирсан. Хоёрхон жилийн өмнөх та бүхний сонгуулийн амлалтуудын бэх нь чадаагүй, цуурай нь ч буугаагүй байна гэдгийг АН-ын бүлгээс дахин нэг сануулъя.

Монгол Улсын нийт иргэдийн 75 хувь нь, хүүхдийг хасвал 45 хувь нь халамж авдаг орон болж хувирлаа. Зөвхөн сонгуульд ялах зорилгоор татвар төлөгчдийн мөнгийг халамж хэлбэрээр хайр найргүй тараах нь улс орныхоо ирээдүйг хорлож буй ноцтой гэмт хэрэг мөн. Олон төсөвтэй байж болохгүй, гадаад өрийг нэмж болохгүй гэх шүүмжлэл МАН-ын улс төрчдийн амнаас салдаггүй байсан цаг саяхан. Гэвч өнөөдөр Монгол Улсын төсөвтэй зэрэгцэн Монголбанк, Хөгжлийн банк, Эрдэнэт, Эрдэнэс таван толгой гэх

мэт ТӨК-ууд төсвийн шинж чанартай санхүүжилтийг тоолбол бие даасан 10 гаруй төсөвтэй боллоо. Төсвийн иж бүрэн байдлын зарчим ийнхүү бүрэн алдагдлаа.

Өнөөгийн эрх баригчид та бүхэн 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэр Монгол Улсын иргэн бүрд 15000000 төгрөгийн өр ноогдож байгаа талаар хангалттай ярьсан, харин одоо энэ үзүүлэлт 30 сая төгрөг гэдэг үзүүлэлтэд хүрч байна. Хэрэв Монголбанкны своп, Хөгжлийн банкны 500 сая ам. Долларын богд, МИАТ, Төмөр зам зэрэг төрийн өмчит олон компаниудын өр, өрийн баталгаа зэргийг нэмж тооцвол зөвхөн ЗГ-ын өр ДНБ-ий 100 хувиас давах хэмжээнд хүрлээ. Ийнхүү Монгол Улс гадаад өрийн хавх гэдэг зүйлд гүн бат шигдэж байна. Өрийн асуудал Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлаас болж улс орны тусгаар тогтнолын асуудал болж бас хувирахыг анхааруулъя.

АН-ын бүлгээс ирэх оны төсөвт дараах тодорхой зарчмын саналыг бас дэвшүүлж байна.

Нэгдүгээрт нь, хэмнэлтийн гэж буй ч үрэлгэн, өгөөжгүй, түүхэн өндөр төсвийн зардлаа эрс царцааж, төсвийг алдагдалгүй баталъя.

Хоёрдугаарт нь, өрөө бодитоор төлж багасгах бодлогоо барья, алдагдалгүй төсөв батлагдсанаар ийм боломж үүсэж, олон улс дахь манай үнэлгээ ч бас сайжирна. Энэ бол УИХ дахь АН-ын бүлгийн гэхээсээ илүүтэй Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын ирээдүй, өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд нийцэх шаардлага юм. Улс орны эдийн засаг сэхээний

тасагт гадаадын өр, зээл гэсэн хиймэл амьсгаа залгагдан хэвтэж байна. Ийм байдалд хүргэсэн эрх баригчдын тооцоо судалгаагүй шийдвэрүүд, төсвийн буруу бодлого, жижиг дунд үйлдвэрлэл, Хөгжлийн банк, нүүрсний оптек гэрээ зэрэг дуулианууд шил шилээ даран задарч олонд бас ил болж байна. Улс төрийн нөлөө ихтэй, улс төрчдийн дохио зангаагаар явдаг хаалттай нөхцөл байдал энэ мэт ялзарсан асуудлууд цаашид ч тасралтгүй гарсаар байх болно оо.

Төмөр зам, эрчим хүчний систем, агаарын тээвэр гээд л олон салбарт Таван толгойн хаалттай нууц гэрээнүүд шиг асуудлууд цаашид ч бас ил гарч ирнэ. Энэ бол зүй ёсны л үйл явц. Хаалттай захиргааны аргаар удирдах гэсэн урхагт бодлогын үр дүн ийм л байдаг.

Зах зээлийг чөлөөлж, нээлттэй, ил тод болгож, төрийн өмч, өмчит компаниуддаа нэн даруй олон нийтийн юм болгож, төрийн оролцоогоо үлэмж багасгах нь энэ бүхний магадгүй ганц шийдэл ээ.

Ужгирсан асуудлын шалтгааныг олж дарахын оронд дотоодоосоо дайсан илрүүлдэг хэн нэгнийг цовдолж нийгмээрээ яллуулдаг арга ажиллагаа, зарчмаар цаашид хол явж чадахгүй нь тодорхой.

Хэлбэрийн төдий косметик шинжтэй, буруутныг хайсан, улс төрийн богино зай нь оноо авах гэсэн энэ мэт үйлдлүүдээсээ нэн даруй татгалзаж томорсон төсөв данхайсан төрөө багасгах системийн шинжтэй шинэчлэлт, өөрчлөлтийг зоригтой хийж эхлэхийг эрх баригч

та бүхнээс хүсэж бас шаардаж байна.

Улс орны хэтийн ирээдүйд тусдаа эрс олон өөрчлөлтүүдийг салбар бүрд хийж эхлэхгүй аваас нэгэнт оройтсон байх, хожим харамсмаар үнэ төлөх бараан ирээдүйг бодитойгоор өсөн байгааг УИХ-ын хариуцлагатай индэр дээрээс анхааруулан сануулж байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ.

Төсвийн төслийн талаарх 2 дахь хэлэлцүүлгийн үеэр олонхын дэмжлэг авсан санал нь энэ хуулийн Төсвийн тухай хуулийн талын 70.7.2, 70.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаарх УИХ-ын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгжийн дүгнэлтийг хэлтсийн дарга Даваасүрэнгийн Эрдэнэсамбуу танилцуулна. 1 номер. Индрийн 1 номер.

Д.Эрдэнэсамбуу: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.7.2 дахь заалт, 70.7.3 дахь заалт, 70.13 дахь хэсэгт заасны дагуу УИХ-ын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс Төсвийн байнгын хорооны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн саналд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн орлого нэмэгдүүлэх 2 санал, урсгал зардал нэмэгдүүлэх 14 санал, хөрөнгийн зардал нэмэгдүүлэх 3 багц

санал болон төсвийн зардал бууруулах 4 саналууд нь Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.7.2-т заасан ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлэхгүй байх гэсэн шаардлагыг хангасан байна

2. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн зардлыг 176 тэрбум 861,9 сая төгрөгөөр бууруулах, урсгал зардлыг 97 тэрбум 121,9 сая төгрөгөөр бууруулах, хөрөнгийн зардлыг 79 тэрбум 740 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналууд нь Төсвийн тухай хуулийн 6.2.6-д заасан тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зардлыг нэмэгдүүлэх, хэмжээг нэмэгдүүлэхгүй байх гэсэн шаардлагыг хангасан байна.

3. Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан хөрөнгө, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10 тэрбум 222,2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, 12 төсөл, арга хэмжээний санал болон магадлалын ерөнхий дүгнэлтэд үндэслэн төсөвт өртгийг нэмэгдүүлж, санхүүжих дүнг 50 тэрбум 628,4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн 72 төсөл, арга хэмжээний санал, мөн төсвийн төсөлд тусгагдаагүй боловч өмнөх Төсвийн тухай хуульд тусгагдан батлагдаж байсан 18 тэрбум 889,4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 хөрөнгө оруулалтын төсөл, арга арга хэмжээг төсөлд нэмж тусгах 3 багц санал нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасан хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг, төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл

олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана гэсэн шаардлагыг хангасан байна.

Тухайлбал, төсөвт өртөг нэмэгдүүлсэн 72 төсөл, арга хэмжээнээс 32 төсөл, арга хэмжээ, төсвийн өртгийг магадлалын ерөнхий дүгнэлтээр, 32 төсөл, арга хэмжээний төсвийн өртгийг өмнөх жилийн төсөвт тусгагдан батлагдаж байсан төсвийн өртгийг тооцож тусгасан байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан хөрөнгө оруулалтын нийт 125 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, зохицуулалт хийх санал нь Төсвийн тухай хуулийн 29.3-т заасан шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах гэсэн шаардлагыг хангасан байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ажлын хэсгийн гишүүд төсвийн өмнөх ажлын хэсгийн гишүүдтэй нэг адил мөн байна. Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мижиддоржийн Санжаадорж тэргүүтэй Сангийн яамны дэд ажлын хэсэг ажиллаж байгаа.

Төсвийн байнгын хорооноос гаргасан нэгтгэн гаргасан зарчмын зөрүүтэй 16 саналаар санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя.

Гишүүд чуулганы танхимд цугларна уу.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн. Үндсэндээ 16 санал байгаа

Төсвийн байнгын хороо дэмжсэн саналаар явуулна.

Төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой төсвийн орлого нэмэгдүүлэх санал байгаа. Нэгдүгээрт. Төсвийн орлого нэмэгдүүлэх санал.

1.1. Ул хөдлөх эд хөрөнгийн албан татвараас төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 37,754.7 сая төгрөгөөр, газрын төлбөрөөс аймаг, нийслэлийн орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 60,860.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ширнэнбаньдын Адьшаа, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Баагаагийн Баттөмөр, Энхбаярын Батиугар, Жадамбын Бат-Эрдэнэ, Гочоогийн Ганболд, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтайн Ганибал, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн,

Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жамъянгийн Мөнхбат, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Саранчимэг, Цэдэвийн Сэргэлэн, Цэвэгдоржийн Туваан, Чинбатын Ундрэм, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Содномын Чинзориг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Төмөртоогоогийн Энхтүвшин /цаашид “ажлын хэсэг” гэж нэрлэнэ/. Санал хураалт.

Орлого нэмэгдүүлэх 2 саналаар санал хураалт явуулья. Санал хураалт.

Чимэдийн Хүрэлбаатар гишүүн горимын санал гаргая. Дараад байхад нь эсрэг гарсан байна. Пүрэвдорж гишүүнийх эсрэг гарсан байна. Хүрэлбаатар, Наранбаатар, Чимэдийн Хүрэлбаатар.

Ч.Хүрэлбаатар: Үгүй ээ, сая санал хураалт алх цохихоос өмнө эндээ хүрчихсэн юм. Тэгчхээд ингээд дарахаар юу орохгүй байна. Тэгээд сая санал яачихлаа. Би энэ алх цохихоос өмнө энд хүрсэн учраас төхөөрөмж. Харин тийм, тийм учраас уучлаарай, түүнээс биш би энэ ажлын хэсгийн бүх саналыг нь бол дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Санал хураалтыг тэгэхээр хүчингүй болгох горимын санал гаргалаа, Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ер нь бол 33, 4 гишүүн байгаа байхгүй юу. Сая тэгээд эсрэг гараад байна. 35 болчихлоо.

Хүрэлбаатар гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Адьяаа гишүүн, Амартүвшин гишүүн. Энэ тэнцчихлээ. Болдын Жавхлан гишүүн.

Б.Жавхлан: Их Хурлын дарга аа, энэ миний буруугаас болчихлоо, тийм. Би дэмжиж санал өгөлгүй яах вэ, кнопод буруу байхгүй ээ. Надад буруу явчихлаа. Дахиж санал хураалгах уу, яах вэ, эсвэл миний саналыг протоколоор дэмжсэн талд нь оруулчих уу, тийм үү. Тэгвэл дахиж санал хураалгаж өгөөч. Санал хураалтыг хүчингүй болгож өгөөд.

Г.Занданишатар: Төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах зорилгоор түр завсарлага.

Цайны завсарлага, 15 минут.

Г.Занданишатар: Нэгдсэн хуралдаанаа үргэлжлүүлж, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулиудын төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн байнгын хороо дэмжсэн саналуудаар санал хураалт явуулна.

Нэгдүгээрт, төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой төсвийн орлого нэмэгдүүлэх саналыг хэлэлцүүлж, санал хураалт явуулна. Төсвийн орлого нэмэгдүүлэх саналаар санал хураалт явуулъя.

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 37,754.7 сая төгрөгөөр, газрын төлбөрөөс аймаг, нийслэлийн орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын хэмжээг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн түвшингөөр тооцож, төсвийн орлогыг 60,860.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Ажлын хэсгийн гишүүдийг түрүүнд танилцуулсан. Саналтай холбогдуулж УИХ-ын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж үг хэлнэ, Пүрэвдоржоор тасаллаа.

Б.Пүрэвдорж: Ардын намынхан 2012-2016 оны хооронд АН-ыг 3 төсөвтэй болчихлоо гээд зүгээр аюул болдог байсан. Улсын төсөв, үнэ тогтворжуулах хөтөлбөр, ипотекийн зээл гээд энэ Хүрэлбаатар хамгийн их хаширдаг байсан, сууж л байна. Одоо энэ Монгол ардын нам 10 төсөвтэй болсон. Би та нарт хэлээд өгье. Улсын төсөв 20,4 их наяд төгрөгийн зардалтай зардал нь замбараагүй, энэ 20,4 гэдэг чинь 2012-15 оны хоорондох бүх зардал төсөвтэй тэнцэж байгаа. Монголбанк ипотекийн зээл, үнэ тогтворжуулах хөтөлбөр, тэгээд 10 их наядын зарим нэгэн төсвийн шинжтэй хөрөнгө оруулалтуудыг санхүүжүүлж байгаа. Хөгжлийн банк байна, 500 сая долларын бондыг 2018 оны 10 сард гаргаад үүгээрээ төсвийн алдагдлыг нөхсөн гэдэг ийм зүйл байгаа. Зарцуулалтаа ил гаргахгүй байгаа. Эрдэнэт УҮГ 1,2 их наяд төгрөгийг цахилгааны төлбөрт төлсөн төсвийн шинжтэй, дээрээс нь 100 тэрбумаар жорлон хийгээд л явж

байна, тэнд. Эрдэнэс Таван толгой байна, төмөр замын маш их олон одоо санхүүжүүлж, төмөр замыг санхүүжүүлсэн, Эрдэнэс Гашиун сухайт, Таван толгой, тэгээд тэр Чойр юуны Чойр юу билээ, Таван толгой хүртэл говийн замыг бас санхүүжүүлсэн байгаа. Эрдэнэс силвер байна, 700 тэрбум төгрөгөөр ахмадын өрийг тэглэсэн байгаа. ОТ-н барьцаа хөрөнгө 1,2 их наяд төгрөг байсныг нь иргэдэд 300000-аар тарааж өгсөн байж байна, 5,1 их наяд, 10 их наядын хөтөлбөрүүд байж байна, энэ хөтөлбөрүүд төсвийн шинжтэй үйл ажиллагааг маш их санхүүжүүлдэг. Төрийн өмчийн компаниуд тус тусдаа аймаг болгонд байгаа орчин болгондоо төсвийн шинжтэй хөрөнгө оруулалтыг санхүүжилтүүд хийдэг. Тэгээд одоо та нарын энэ тал талаас иддэг, уудаг, төсвийн хөрөнгөөс иддэг, дээрээс нь төрийн өмчийн компаниудын томоохон компаниудыг төсвийн шинжтэй хөрөнгө оруулалт хийж энэ хулгай зэлгий хийдэг юм чинь арай хэтэрч байна. Яасан замбараагүй, ийм хариуцлагагүй байна гэж юу гэсэн үг вэ. Тэгээд ийм их зардал гаргасан мөртөө тэгээд орлого талдаа ерөөсөө ажиллахгүй, бүгдийг нь баахан зардал гаргачхаад түүнийгээ бонд гаргаж баахан төлбөрөө төлдөг. Бонд гаргаад л байдаг, бонд гаргаад л байдаг, хойч үрдээ баахан өр тавьдаг. Өнөөдрийг хүртэл 4 тэрбум доллароор ЗГ-ын зээлийг нэмэгдүүлчихсэн. Дарханы замыг ч хүртэл бүтэн тавьж чадахгүй, нэг хагасыг нь тавьчхаад үгүй ямар айхтар шоу хийв ээ, ийм л байна шүү дээ, та нар. 10 төсөвтэй Ардын намынхан.

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа. Төсвийн орлого нэмэгдүүлэх санал уншиж танилцуулсан. Санал хураалтад бэлдье.

Жавхлан гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Болдын Жавхлан гишүүний горимын саналаар санал хариулт явуулна. Санал хураалт. Санал хураалтууд төхөөрөмж гацаад байгаа учраас төстийн санал хураалт явуулна.

Төстийн санал, туршилт. Туршилтын. Бат-Эрдэнэ гишүүн картаа уншуулаарай, Цэрэнпунцаг гишүүн картаа уншуулаарай. Тогтохоо дарга аа, саналаа хураая. Ирц болчихлоо.

Саяны санал хураалт, хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

33 гишүүн дэмжиж 67,3 хувийн саналаар горимын санал дэмжигдэж энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Өмнөх санал хураалтуудыг хүчингүйд тооцсон учраас нэг дэх саналаар түрүүн уншиж танилцуулсан, 1 дэх саналаар, ажлын хэсгийн 1 дэх саналаар санал хураалтыг дахиж явуулна. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт. 67,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1.2.Монголбанкны худалдан авах алтны хэмжээг 2023 оны төсвийн жилд 20 тонн болгохтой холбогдуулан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 29,100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёрт, төсвийн зарлага нэмэгдүүлэх, бууруулах санал.

2.1.1. Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн цалин хөлс, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, зээлийн хүүгийн төлбөрийн зардлаас бусад улсын төсвөөс санхүүжих үйл ажиллагааны зардлыг 1.88 хувиар буюу 94,527.6 сая төгрөгөөр бууруулах;

2.1.2. Төслийн 2 дугаар хавсралтын “VI.2.4.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2023-2023 он, төсөвт өртөг 80,000.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 80,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2023 онд санхүүжих дүнг 40,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах;

2.1.3. Төслийн 2 дугаар хавсралтын “XII.1.1.73. Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам 50 км” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 10,969.1 сая төгрөгөөр, мөн хавсралтын “VI.2.1.1. Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр буюу нийт 15,969.1 сая төгрөгөөр бууруулах; Үүнийг тодруулахгүй бол болохгүй юм байна шүү.

2.1.4. Төслийн 2 дугаар хавсралтын “VI.2.1.2. Гадаадын зээл,

тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт” гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 26,365.2 сая төгрөгөөр бууруулах.

Нийт 176,861.9 сая төгрөгөөр дараах хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх. Үүнд:

2.2. Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал:

2.2.1. Улсын хэмжээнд гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн зардалд шаардагдах 33,628.0 сая төгрөгийг Эрчим хүчний сайдын урсгал зардалд нэмж тусгах.

2.2.2. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 13,500.0 сая төгрөгөөр Эрүүл мэндийн сайдын урсгал зардлыг нэмэгдүүлэх.

2.2.3. Ойн хортон шавжтай тэмцэх ажилд зориулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын урсгал зардлыг 8,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгагдсан Өнөр бүл хүүхдийн төвийн урсгал зардлыг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгагдсан Хүүхэд хамгаалах арга хэмжээний зардлыг 2,700.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.6. Шинэ сэргэлтийн бодлогын тэргүүлэх зорилт-Боомтын сэргэлтийг дэмжих хүрээнд Боомтын

асуудал хариуцсан сайдын урсгал зардлыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.7. Монгол Улсын Засгийн газраас 2023 оныг Монгол Улсад зочлох жил болгон зарласантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын урсгал зардлыг 3,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.8. Хууль тогтоох байгууллагын хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангахад зориулан урсгал зардлыг 5,919.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.9. Санхүүгийн зохицуулах хорооны урсгал зардлыг 2,900.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.10. Жендэрийн үндэсний хорооны урсгал зардлыг 217.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын урсгал зардлыг 242.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.2.12. Байгаль цаг уурын эрсдэлд өртсөн орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд зориулж Нийгмийн халамжийн сангийн урсгал зардлыг Ховд аймагт 1,000.0 сая төгрөгөөр, Увс аймагт 622.2 сая төгрөгөөр, нийт 1,622.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, үүнтэй холбогдуулан орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээнд зохих өөрчлөлтийг тусгах.

2.2.13. Төсвийн орлого нэмэгдүүлэх 1.1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу орон нутгийн холбогдох зардлыг 10,692.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх:

/аймаг, нийслэлийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 82,647.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймаг, нийслэлд үлдэх орлогын хэмжээг 10,692.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 5,274.1 сая төгрөгөөр бууруулах/

2.2.14. Төсвийн орлого нэмэгдүүлэх 1.2 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу орон нутгийн холбогдох зардлыг 2,910.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх:

/орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн дүнг 2,910.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх/

2.3. Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал:

2.3.1. Саналын томьёоллын 1 дүгээр хавсралтад тусгагдсан 12 төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 10,222.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үүнтэй уялдуулан тухайн төслийн хэрэгжиж дуусах хугацааг өөрчлөх.

2.3.2. Саналын томьёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан 83 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалын дүгнэлтэд үндэслэн төсөвт өртгийг 221,285.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, үүнтэй

уялдуулан тухайн төслүүдийн санхүүжих дүнд 50,628.4 сая төгрөгийн өөрчлөлт оруулах.

2.3.3. Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдсан, 2023 оны төсвийн төсөлд тусгагдаагүй, саналын томъёоллын 3 дугаар хавсралтад тусгагдсан 32 хөрөнгө оруулалтын болон 6 төрлийн урсгал зардлыг 23,678.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөлд нэмж тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, санал хураалт.

Санал байхгүй л дээ, энэ чинь дэмжсэн дэмжээгүй л үг хэлнэ. Тэгж хэлээгүй учраас санал хураалт явчихлаа.

52,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дэмжсэн, дэмжээгүй л үг хэлж болно, санал хэлэх дэг байхгүй. Энэ санал батлагдчихлаа.

3. 2023 оны төсвийн санхүүжилт үүнд нөлөөлөхгүй зохицуулалт хийх санал.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хоорондын зохицуулалт.

3.1.1. Саналын томъёоллын 4 дүгээр хавсралтад тусгагдсаны дагуу хөрөнгө оруулалтын 7 төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал өөрчлөх, төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжүүлэн өөрчлөх 2 төсөл, арга хэмжээний зохицуулалт хийх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Энэ дээр хэлчихье ээ. Үүнийг хүчингүй болгоод.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцъё.

Энэ саналыг дэмжсэн, дэмжээгүй бол үг хэлэх юм байна шүү.

Дэмжсэн Мөнхөөгийн Оюунчимэг, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа.

М.Оюунчимэг: Зарчмын хувьд энэ орж ирж байгаа орлого болоод урсгал зардал нэмэгдэх зүйлүүд дээр бол бас бид нар зайлиггүй зүйлүүд гээд ингээд анхаараад ажиллаж байгаа. ЗГ-аас орж ирж байгаа нөгөө санхүүжилт, тоо хэмжээг бол бууруулахгүй, харин бид УИХ хянаж байж юун дээр илүү ач холбогдол өгч, санхүүжилт туслах вэ, юун дээр илүү байна гэж тооцоолох ёстойг, Төсвийн ажлын хэсэг ч бид ингэж бас ярьж байгаа. Энэ дээр нэг зүйл байна. Энэ нөгөө “элэг бүтэн Монгол” дээр бид 7 тэрбумыг тусгая гээд бүлэг дээрээ ярьцаагаад энэ бол бас зөв өө гээд санал нэгдсэн. Тэгээд нэг шөнийн дотор 17 тэрбум болоод 10 тэрбум гараад ороод ирж байна л даа. Тэгэхээр би үүнийг бол жишээ нь хавдартай тэмцэх бидний нэг номерын зорилго байгаа. Бид 2016-20 онд 100 тэрбум төгрөг зарцуулсан. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн санаачлагч 20 гишүүний нэг нь би байгаа юм.

Тэгэхээр эхний ээлжид Нийгмийн бодлогын байнгын хороон дээр энэ 100 тэрбумын үр дүн яаж гарсан, энэ ач холбогдлоо өгсөн үү, үгүй юу гэдгийг нь нэгдүгээрт би тайлагнах хэрэгтэй байна. Тэгж байж дараагийн хөтөлбөр гаргаж ирэхгүй бол гэнэт санаачлаад дахиад элэг бүтэн хөтөлбөр шинээр гаргаж

ирэхээр болж байна л даа. Энэ чинь 2017 онд эхлээд 20 онд дууссан хөтөлбөр. Одоо тэгээд ходоодны хорт хавдраар манайх дэлхийд бараг эхний 2-т ороод ирчихлээ. Хүүхдийн цусны болоод тархины мэдрэлийн Монголд эмчлэх ямар ч боломжгүй, хорт хавдрын тоо эрс өсөж байна. Жилд 50-55 хүүхэд сая үүнээс болоод Монгол хүүхэд нас барж байна. Тэгвэл бид нар яагаад ганцхан “элэг бүтэн Монгол” гэдэг дээр энэ 17 тэрбум байснаас 7 тэрбумаар нь үлдээгээд, харин бусдыг нь тэр эрт оношилгоо тэр яагаад вирус нь гараад байгаа юм уу, ЭМД-аа татаж унагаахгүйгээр зохицуулах хэрэгтэй байна л даа. Тэгэхгүй бол ганц нэг эрхтэн дээр ингэж 17 тэрбум тавихаар бусад нь яах вэ. ЭМД-ын үүнийг бас татаж унагах хэмжээнд хүрч байна л даа.

Дээрээс нь Эрүүл мэндийн сайдын багцыг сая 1,4 их наядаар нэмсэн, энд нь эрт оношилгоо, ЭМД-ын сангаас бүх төрлийн хавдар дээр бас төсөвт тусгаад өгчихсөн. Тэгэхээр давхардсан юм болчих вий, энэ мэтчилэн бид бас тооцоо судалгаагаа сайн хийхгүй бол үнэхээр энэ дээр надад ингээд судалгаанууд орж ирж байна л даа, хавдрын өвчлөл дээр. Ялангуяа сүүлийн үед улаан хоолой, ходоодны хорт хавдар, хүүхдийн хорт хавдар 0-19 насны ихсэж байна гэж байгаа юм. Гэхдээ ихэнх нь ингээд судалгаа аваад үзэхэд бид нар хавдар чиглэл дээр асар их хөрөнгө мөнгө зараад байгаа хэр нь 2021 оны судалгаагаар жишээ нь 4970 хүн хорт хавдраар өвчилсөн байхад түүний 4000 нь нас барж байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид эмчлээд л байдаг, нөгөө өвдсөнийх нь дараа энэ нас баралт нь дэлхийн хэмжээнд манай Монгол Улс өндөр хэвээр байдаг, бусад улсад хор

хавдрын эсрэг эмчилгээ нь үр дүнгээ өгөөд эмчлэгдэж байхад манайд эсрэгээрээ нас баралт нь буурахгүй, харин ч 80, 70 хувь болоод байгаа нь өөрөө учир шалтгаан нь хаана вэ гэдэг байгаад байгаа юм. Тийм учраас бид нар үүнийг Байнгын хороон дээрээ харж үзээд ганц нэг элэг бүтэн дээр биш, ер нь энэ санхүүжилтээр зөв тусгах нь хэрэгтэй байгааг Байнгын хороон дээрээ авч үзэх хэрэгтэй байна гэсэн саналыг хэлэхийг хүсэж байна. Төсвийн байнгын хороо, ажлын хэсгийнхэн маань ч бас энэ дээрээ анхаарах хэрэгтэй байна шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор:

Энэ олон улсуудын хувьд 2023 он бол үнэ уналт болно оо гээд ОУВС-аас энэ ирэх онд нөхцөл байдал бол эрс дордож болзошгүй ээ гэж анхааруулж байгаа. Тэгээд ер нь энэ цаашид Засгийн газруудын хувьд бол энэ бодлогын тэргүүлэх чиглэл нь бол инфляцыг бол онилж байгаа болон нөлөөлж байгаа энэ хүчин зүйл болох эрчим хүч болон хүнсний түүний аюулгүй байдлыг хангах нь бол тэргүүний асуудал болоод байгаа. Тэгээд өнөөдөр энэ дэлхий дээр бүхнийг фронтод гэдэг шиг 190 гаруй сая хүн өлсгөлөнд нэрвэгдэж байгаа энэ цаг дор болбол бүхнийг хүнсэнд урианд оруулаад шийдлүүдийг бол ирэх илэрхийлж эрэлхийлж, Засгийн газрууд болбол зорьж ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр манай улсын хувьд болбол 1 тэрбум доллар орчим тийм ээ, энэ импортоор хүнснийхээ барааг татдаг, импортын хамаарал бүхий ийм, хүнсний хангамж бол өндөр эрсдэлтэй, ийм улс орон байгаа. Тэгэхээр энэ агуулгаараа ч гэсэн энэ

ХАА-н салбарын үйлдвэрлэлийг нэг шат ахиулах мөн энэ валютын урсгалыг болбол нэмэгдүүлэх бодлогыг бол ЗГ, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга дор бол хүнсний хангамж, аюулгүй байдлын талаарх асуудал санаачилгыг гаргасан.

Гэтэл өнөөдөр энэ хэлэлцээж байгаа, энэ асуудал бол төсөв дээр тухайлсан, яг энэ асуудлаар болбол баримталсан зарчим 2 бол хоорондоо болбол туйлын зөрүүтэй байна. Энэ ер нь ямар учиртай юм бэ? Дөрөвхөн сарын өмнө бид нар баталсан хүнсний хангамжийг нэмэгдүүлэх УИХ-ын шийдвэрээр бол 23 онд 521 тэрбум төгрөг шаардлагатай, үүнээсээ гадаад зээлийн эх үүсвэрээр 190 тэрбум, хувийн хэвшилд болбол зээлийн батлан даалт гаргахаар 55 тэрбум, үлдсэн нь болбол 300 тэрбум орчим төгрөгийг болбол улсын төсвөөр хэрэгжүүлнэ ээ гэж ийм төлөвлөлт хийсэн байж байгаа. Тэгээд энэ үндсэндээ болбол энэ төсвийн хөрөнгө оруулалт болбол байхгүй гэж ойлгогдож байна.

Төлөвлөлтөөр болбол энэ улсын төсөв ирэх онд бол 12 тэрбумын хүлэмж 19,2 тэрбумын зоорьтой болохоор ёстой байгаа. Гэтэл энэ төсөв дээр болбол бас л алга, Сангийн сайд аа. Тэгээд ингээд энэ хэрэгжүүлэх түвшинд дөрөвхөн сарын тийм ээ, ийм ой санамжтай, ингээд ингээд ингээж явах юм бол бид нар юун тэр дунд хугацааны зорилт байтугай тийм ээ, энэ чинь Монгол Улсын 3 сая хүний хүнсний хэрэгцээг хангах ийм үндэсний аюулгүй байдлын асуудал шүү дээ. Тэгээд яагаад энэ дээр ингээд асуудлаа ингээд хэрэгжүүлэх тал дээр нь, тийм ээ, үүнийг хооронд нь ингээж холбож

болохгүй байгаа юм бэ? Тэгээд миний хувьд бол энэ хүнсний хэрэгцээг хангаж байгаа, бас стратегийн гол бүс нутгийн гишүүний хувиар болбол бас үнэхээр санаа зовж байна. Тэгээд энэ гишүүд ч гэсэн бас энэ дээр бас анхаарлаа хандуулахыг бас та бүгдээс хүсээж байна. Тэгээд энэ дээр Сангийн яам болон сайд тодорхой шийдэл гаргаж бас эргээж харах нь зүйтэй байна.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Үг хэлж дууслаа, дэмжсэн, дэмжээгүй. Энэ саналтай шууд холбоотой санал биш байна.

Санал хураалт явуулна. 62 хувиар санал дэмжигдлээ.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Гишүүддээ оройн мэнд хүргэе. УИХ-ын тухай хуулийн 33.1.4, Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хэлэх гэж байна. Завсарлага авах тухай. Монгол Улсын 2023 оны төсвийг хэлэлцээж байна. Энэ олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмжийн эсрэг олон улсын нөхцөл байдал, тэр тусмаа 2 хөршийн эдийн засгийн нөхцөл байдал, эдийн засгийн өсөлт болоод олон зүйлд эрэлтийн таамгийнх нь эсрэг ийм асар өндөр алдагдалтай ийм төсөв оруулж ирж байна.

Дахиад бас хэмнэлтийн нэртэй хууль батлагдсан байтал төсөв маань хэдэн их наядаар нийт дахиад тэлж байдаг, алдагдлаас гадна төсөв маань тэлсэн ийм л төсөв орж ирж байна. Тэгээд энэ төсөв дээр тавьж байгаа шаардлага болоод төсвийн алдагдалгүй баталъя, алдагдлыг эрс

бууруулъя гэдэг шаардлагыг бид нар бас анхнаас нь ярьж хэлсээр ирсэн, бас энэ төсвийн хэлэлцүүлгийн үе шатанд энэ дээр бас тодорхой хэмжээний ахиц дэвшил гарах болов уу гэж бас тодорхой хэмжээнд харсан.

Ер нь яг үнэндээ бид нар ирэх жил Монгол Улсаараа дампуурах эрсдэл байхад 2, 3 их наядаар барилга байшин барьж бид нар үнэндээ бас яг, яг яах гээд байгаа юм бэ. Тийм болохоор бас энэ төсвийг сайжруулах, төсвийн алдагдалгүй болох, алдагдлыг эрс бууруулах чиглэлд энэ төсвийн ажлын хэсэг, Төсвийн байнгын хороонд олонхын бүлгээс бас чиглэл өгөөч, бас АН-ын бүлэг ч гэсэн дотроо бас энэ дээр зөвлөж ярилцах шаардлагатай. Ийм учраас бас ажлын 5 хоногийн завсарлага өгөөч ээ гэж Их Хурлын даргаас хүсэж байна.

Г.Занданшатар: Төсвийн 2 дахь хэлэлцүүлэг явж байна. 11 дүгээр сарын 15-ны дотор хуулийн хугацаатай асуудал учраас 5 хоногийн завсарлага өгөх боломжгүй.

16 санал гэдэг чинь хуулийн хугацаатай асуудал учраас бол энэ чинь маргааш өглөө. Төсөв 4 хэлэлцүүлэгтэй, ахиад 3 хэлэлцүүлэг явах ёстой. Нэг 7 хоногийн хугацаа байна. Тэгээд ажлын 5 хоногт энэ зүйл тохиролцоогүй. Тийм учраас энэ хугацаанд нь бол хэлэлцүүлэх бололцоогүй.

1 цагийн завсарлага өгье. Сая Адышаа гишүүн 1 цагийн дотор завсарлага авъя гэсэн.

1 цагийн дотор завсарлага өглөө.

Г.Занданшатар: Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацаа дууссан тул Чуулганы нэгдсэн хуралдаанаа үргэлжлүүлбэ.

Ардчилсан намын бүлгийн дарга Цогтгэрэл. Чуулганы хугацаа дууссан байна, хэлэх үг байна уу. Пүрэвдорж гишүүн ээ, Ардчилсан намын бүлгээс өөр хүн алга байна. Та л байна. Чуулганы завсарлагын хугацаа дууссан гэж тооцох уу. Чуулганы завсарлагын хугацаа дууссан байна.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж үг хэлэх үү.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ээ, Цогтгэрэл даргыг дуудчихаач. Цэвэгдоржийн Туваан гишүүн. Завсарлагын хугацаа дууссан байна. Үг хэлж болно. Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл гишүүн завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж үг хэлэх үү. Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

О.Цогтгэрэл: Төсвийн 2 дугаар хэлэлцүүлэг явж байгаатай холбоотойгоор завсарлага авсан. 1 цагийн завсарлага гэж байна. Өнөөдөр 11 дүгээр сарын 3. Хуулийн хугацаа 11 сарын 15 гэхэд цаана нь бараг хоёр 7 хоногийн хугацаа байгаа. Тэгэхээр энэ хугацаанд уг нь энэ төсвийг Монгол Улсын эрх ашгийн төлөө өөрчлөн сайжруулах, төсвийн алдагдлыг эрс бууруулах боломжууд байсан. Тэгээд энэ бүгдийг ашиглахгүй, энэ нөхцөл байдалд энэ төслийн түвшинд үргэлжлүүлнэ гэж ингээд үзэж байгаа юм байна. Тэгээд нэгэнт хуулийн хугацаа дууссан тул бид нар яалтай билээ. Тэгэхдээ энэ

үнэхээр Монгол Улсын 2023 оны төсвийг бас өөрчлөн сайжруулах боломж бололцоог үргэлжлүүлэн ашиглах ёстой л гэж дахин дахин хэлэх байна.

Г.Занданшатар: Баярлалаа. Цогтгэрэл гишүүн үг хэллээ. Ингээд өнөөдөр чинь 4 дэх өдөр, ирэх 7 хоногийн 10, 11-ний 4 дэх, 5 дахь өдрийн чуулганаар хэлэлцэнэ. 12, 13 бол хагас бүтэн сайн, 14-нд дуусах ёстой 15-наас өмнө гэхээр, тэгээд 14 нэгдэх өдөр байгаа. Тэгэхээр үндсэндээ нэг 7 хоногийн хугацаа л байгаа гэдгийг бас хуулийн хэлэлцүүлэг гэдгийг тодруулъя.

Ингээд одоо санал хураалтаа үргэлжлүүлж явуулна.

3.1.1 дэх саналыг 63,2 хувийн саналаар дэмжсэн.

Одоо 3.1.2-оор санал хураана. Саналын томъёоллын 5 дугаар хавсралтад тусгагдсаны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 оны санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 58 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнд холбогдох зохицуулалт хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулах уу.

Санал хураалт. Жавхлан, Раднаасэд, Цэрэнпунцаг. Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ж.Сүхбаатар: Над дээр микрофон өгөөд байх юм. Би ямар ч зөрчилгүй шүү дээ.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн гэж хэлсэн юм.

Ш.Раднаасэд: Санал хураалтад хоцорчихлоо. Дахин санал хурааж өгнө үү.

Г.Занданшатар: Раднаасэд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Тогтохоо дарга аа, Тэмүүлэн гишүүн суудалдаа суугаарай.

Санал хураалт. Хүчингүй болгох санал хураалт. Раднаасэд гишүүний гаргасан горимын саналаар.

63,6 хувиар горимын санал дэмжигдэж, өмнөх саналыг хүчингүйд тооцлоо.

Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.1.3.Төслийн 2 дугаар хавсралтын ХХ.3.1.Нийтийн тээврийн автобус /Улаанбаатар/ гэсэн төсөл, арга хэмжээний 2023 онд санхүүжих дүнг 22,000.0 сая төгрөгөөр бууруулж хэрэгжих хугацааг 2023-2024 он болгон өөрчилж, “Түгжрэлийг бууруулах, хотын төвлөрлийг сааруулах асуудлын хүрээнд захиргааны зарим байгууллагын нэгдсэн цогцолбор барилгын дуусгал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ хэрэгжих хугацаа 2023-24 он, төсөвт өртөг 45,000.0 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 22,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж, зохицуулалт хийх Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.1.4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцын урсгал зардал болох бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх борооны нуужин 2500 ширхэг авахад 1,500.0 сая төгрөгийг мөн сайдын багцын урсгал зардалд нэмж, зохицуулалт хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал байна.

Санал хураалт. 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.1.5. Соёлын сайдын урсгал зардлыг 100.0 сая төгрөгөөр бууруулж, Кино урлагийг дэмжих сангийн үйл ажиллагааны зардалд 100.0 сая төгрөгийг шилжүүлэн зохицуулалт хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн. Санал хураалт. Асуулт байхгүй.

56,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зарчмын бусад санал.

4.1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах.

4.1.1. хүснэгтийн толгой хэсгийн “үр дүнгийн” гэсний дараа “талаарх” гэж, 9.1.2 дахь заалтын дараа “9.1.3 Нийцлийн аудитын тоо”, 2023 оны зорилтот түвшинг “0” гэж, 15.2.1, 15.2.2 дахь заалтын “Хуулийн” гэсний өмнө “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай” гэж, 23.6.1, 23.6.2,

23.6.3, 23.6.4, 23.7.1, 23.8.1, 23.8.2, 23.9.1 дэх заалтын “тоо” гэсний дараа “мянга” гэж, 28.1.2 дахь заалтын “Малын гоц халдварт” гэсний дараа “өвчний” гэж тус тус нэмэх;

4.1.2. хүснэгтийн 1.1.3 дахь заалтын “хөдөлгөөн” гэснийг “үндэсний хөдөлгөөнийг” гэж, мөн заалтын “270-аас доошгүй тогтоолын төсөл” гэснийг “270-аас доошгүй хууль, тогтоолын төсөл” гэж, 2.1.3 дахь заалтын “Цахим мэдээллийн санд төвлөрүүлсэн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн тоо” гэснийг “Хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх цахим мэдээллийн санд төвлөрүүлэх тайлангийн тоо” гэж, 4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтын “хуулийн хугацаанд шийдвэрлэх” гэснийг “хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах” гэж, 7.1.1 дэх заалтын “хяналт тавих” гэснийг “тавих хяналтын” гэж, 12.1.2 дахь заалтын “шилжүүлэлтийн” гэснийг “шилжүүлэх” гэж, 16.1.1 дэх заалтын “Нийт төрийн өмчит” гэснийг “Төрийн болон орон нутгийн өмчит” гэж, 16.1.3 дахь заалтын “Төрийн өмчийн байгууллагын” гэснийг “Төрийн өмчит хуулийн этгээдийн” гэж, 18.2.1 дэх заалтын “Бүсийн тээвэр логистикийн шинээр нэмэгдэх төв” гэснийг “Шинээр нэмэгдэх бүсийн тээвэр логистикийн төв” гэж, 19.1.1 дэх заалтын “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт” гэснийг “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт” гэж, 19.2.1 дэх заалтын “стандартад нийцүүлэн ханган ажиллах” гэснийг “стандартыг хангаж ажиллах” гэж, 20.1.1, 20.1.2, 20.1.3, 20.2.1 дэх

заалтын “га” гэснийг “мянган га” гэж, 20.1.2 дахь заалтын “Ойн хөнөөлт шавж” гэснийг “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх” гэж, 20.2.2 дахь заалтын “хамгаалалтын зурвасын нэмэгдсэн” гэснийг “хамгаалалтын зурвас хийх талбайн хэмжээ” гэж тус тус өөрчлөх;

4.1.3.хүснэгтийн 15.2 дахь хэсгийн дэд гарчгийн “талаар” гэснийг, 16.2.5 дахь заалтын “хохирогчийг” гэсний дараа “хамгаалах” гэснийг, 20.1.2 дахь заалтын “тэмцлийн” гэснийг, 25.1.1 дэх заалтын “Зорилтыг бүрэн хэрэгжсэн,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 69,4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Содномын Чинзориг гишүүн.

4.2 Бусад санал.

4.2.1.Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 65,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.2.2.Төсөлд зүйл заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд

өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршилыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 71,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.2.3.Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хуулийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1. Хууль зүйн байнгын хороо.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр” нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны

Пүрэвдорж. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй.

Санал хураалт. Дэмжээгүйг дэмжинэ.

30 гишүүн дэмжиж, 61,2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ. Дэмжээгүй санал дэмжигдлээ.

2. Эдийн засгийн байнгын хороо.

1. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн төслийн Зам, тээврийн сайдын багц дахь Иргэний Нисэхийн ерөнхий газрын... Пүрэвдорж гишүүн татчихсан гээд байсан шүү дээ, татаагүй юм уу.

2. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардлыг 350.0 сая төгрөгөөр бууруулж, “Гурван хүүхдийн заставын засвар /Ховд, Булган сум/, хэрэгжих хугацаа 2023-2023 он, төсөвт өртөг 350.0 сая төгрөг, санхүүжих дүн 350.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг төсөлд нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Дэмжээгүйг дэмжье гэсэн Байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя.

62,0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны санал байна.

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайдын багц дахь

Иргэний нисэхийн ерөнхий газрын төсөвт төвлөрүүлэх агаарын навигацийн орлогыг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Орон нутгийн /Алтай, Ховд, Өлгий, Улаангом, Улиастай, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад, Баянхонгор/” чиглэлд нислэг гүйцэтгүүлэхэд тийзийн үнийн татаас олгоход 9,800.0 сая төгрөг нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хураалт. Энэ чинь дэмжихгүй шүү дээ, энэ чинь.

Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар санал хураалт явуулъя.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр бууруулж, Улсын Их Хурлын даргын урсгал зардлыг 1,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

***Б.Энхбаяр:** Саяын энэ гаргасан саналаа миний бие татаж авч байна.*

Г.Занданшатар:

Баттөмөрийн Энхбаяр гишүүн микрофонд хэлсэн үү. Микрофонд хэлэх ёстой. Баттөмөрийн Энхбаяр гишүүн саналаа татсан учраас саналыг татсанд тооцлоо.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулъя.

1. Төслийн 2 дугаар хавсралтын “IX.1.50.Сумын төвийн цэвэр усны шугам /Өвөрхангай, Төгрөг сум/ хэрэгжих хугацаа 2021-2023 он, төсөвт өртөг 1,892.5 сая төгрөг, 2023 онд санхүүжих дүн 1,292.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан. Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг.

Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Саналаа тайлбарлаж эсвэл татаж үг хэлж болно.

С.Чинзориг: Гишүүдийнхээ оройн амгаланг айлтгая. Энэ манай Өвөрхангай аймгийн говийн сум байгаа юм, Төгрөг сум гээд. Тэгээд 21 онд эхэлсэн юм, цэвэр усны шугам татах чинь шаардлагатай. Манай бүх л энэ говийн аймгууд сумдад байдаг зовлонгийн нэг л дээ. Ус нь маш хатуулагтай, ийм устай, тэгээд сумын төвөөс бол 5 километрийн зайтайгаас иргэд нь дандаа өөрсдөө явганаар цэвэр усаа зөөдөг ийм сум. Тэгээд нэг цэвэр усны шугам байгуулъя гээд оруулсан юм.

Тэгээд магадлан хийгээд энэ барилгын материалын үнийн өсөлттэй холбоотойгоор төсөвт өртөг нь 800 саяар нэмэгдчихээд байгаа юм. Ирэх оны 23 оны санхүүжих дүн нь 1 тэрбум 292,5 сая төгрөг байгаа юм. Санхүүжих ирэх оны санхүүжих дүн дээр нь бол нэмэлт, өөрчлөлт бол орохгүй ээ. Төсөвт өртгийг нь 800 саяар нэмэгдүүлье гээд магадлан хийгээд магадлал нь гарчихсан байгаа юм.

Тэгэхээр үүнийг манай гишүүд бас дэмжиж, өгөөч ээ гэж. Байнгын хороон дээр ийм санал гаргаад Байнгын хорооныхон сайн ойлгоогүй байх, гэхдээ техникийн бас алдаа гарсан байх шиг л ойлгож байгаа юм. Тэгээд энэ алдаагаа засаад үүнийг шийдээд өгчхөөч ээ гэж.

Хамгийн гол нь бид сая төсөв батлахдаа 2 дугаар хавсралтаар төсөвт өртөг нь нэмэгдсэн болбол өөрчлөлт оруулна гээд орчихсон шүү дээ. Тэгээд 2 дугаар хавсралтаа та бүхэн хараарай. 2 дугаар хавсралт чинь яг манай энэ гаргаж байгаа саналтай адилхан төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа, гэхдээ санхүүжих дүнд нь өөрчлөлт ороогүй 20 санал орчихсон байгаа юм, 20 санал орчихсон байгаа юм, 2 дугаар хавсралт дээр чинь. Төсөвт өртөг нь нэмэгдчихсэн, гэхдээ 23 оны санхүүжих дүнд нь өөрчлөлт ороогүй 20 төсөл орчихсон байгаа юм. Тэгэхээр сая Нямаа Энхболд даргын яриад байгаа зөв, нэг л зарчим барья гэж.

Тийм учраас бол энэ 2 дугаар хавсралтын 20 төсөлтэй яг адилхан, төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа, магадлан гарчихсан, тэгэхдээ 23 оны санхүүжих дүн нь бол нэмэгдэхгүй, ийм төсөл байгаа юм.

Тийм учраас гишүүд үүнийг босгож өгөхийг бол хүсэж байна. Манай гишүүдэд кноптоо хүргэхгүйгээр, хүрэхгүйгээр Байнгын хорооны дэмжээгүй саналыг босгодог арга байдаг гэж байна. Тэгээд энэ аргаа хэрэглээд кнопдоо хүрэхгүйгээр энэ төслийг, саналыг маань босгоод өгөөч ээ гэж та бүхнээсээ хичээнгүйлэн хүсэж байна.

Говийн сум байгаа юм. Сумаасаа 5 километр зайтай усаа өөрсдөө зөөдөг, тэгээд үүнийг нь болбол сумын төв рүү нь 5 километр зайтай турбагаар ус татаж, сумын төвд нь цэвэр усны байгууламжтай болгох асуудал бол байгаа юм. 2 дугаар хавсралтад орсон 20 тэр төсөл арга хэмжээтэй ч яг адилхан, төсөвт өртөг нь нэмэгдэж байгаа, гэхдээ 23 оны санхүүжих дүн нэмэгдэхгүй, ийм санал байгаа юм.

Байнгын хорооны гишүүд анзаараагүй оролцсон уу, эсвэл техникийн алдаа гараад ингээд олонхын саналаа авч чадаагүй, тийм учраас та бүхнийг тэр туршлагаараа кнопоо хүрэхгүй байж байгаад босгоод өгөхийг бол хичээнгүйлэн хүсэж байна.

Төсөвт бол ирэх оны санхүүжилтэд болбол нэмэлт санхүүжилт шаардахгүй, ирэх оны санхүүжих дүн дээр болбол өөрчлөлт бол орохгүй ээ. Үгүй ээ, яг ийм 20 төсөл орчихсон байгаа юм, Энхболд дарга аа. Ням Энхболд дарга аа, яг ийм 20 төсөл орчихсон байгаа юм.

Г.Занданшатар: Чинзориг гишүүн ээ, энэ татчих аа, 1 л стандарт, 1 л зарчмаар явъя. Би ч гэсэн улс төрийн манлайлал, үлгэр дуурайлал үзээд байя гэж Сангийн яаманд нэг ч төсөл шахаж хэлж яриагүй, үнэ төсөл нэмэгдүүлээгүй ер нь тэгсэн чинь ер нь тэгээд бүр сүүлдээ юу ч үгүй болох.

Дахиж үг байхгүй. Санал хураалт явуулъя.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн

саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ингээд ийм буруу жишиг тогтоочих юм бол бүх хүн л тэгж бодно шүү дээ. Ер нь 1 л стандарт, зарчмаараа явъя.

Ямар арын хаалгатай улсууд вэ энэ. Үгүй ээ, говьд ч гэсэн зөндөө тийм юм кейс байна. Би тэгвэл санал хураалгая тэгвэл.

Санал хураалт дууссан уу. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Дараагийн асуудалд орно.

Одоо Чинзоо гишүүний санаачилсан хуулийн төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын төсвийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дахь хэлэлцүүлэг явж дууслаа. 3 дугаар хэлэлцүүлэг дээр төсөвт өртгийг сайтар нягтлаарай. Энэ саналын томъёоллууд, төсөвт өртгөө сайтар нягтлаарай гэдэг чиглэлийг өгч байна.

Тэгээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууссан учраас 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

*Өнөөдрийн хэлэлцэх асуудал
дууссан тул чуулганы нэгдсэн
хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

21.06 цаг

*Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ*

П.ОЮУНГЭРЭЛ